

Ус хангамж, усны эрэлтийн зөрүү арилгах эрэмбэлсэн шийдлүүд

Монголын говийн нүүрсний уурхайн бүс нутгуудад
хийсэн усны эдийн засгийн шинжилгээ



Хураангуй

2030 Усны нөөцийн бүлгийн Монгол улс дахь түншлэл нь Монгол улсад усны нөөцийн тогтвортой менежмент бий болгох зорилттой. Монгол улсын Засгийн газар болон 2030 Усны Нөөцийн Бүлэг нь Монгол улсад тулгараад байгаа усны асуудлаар хамтран ажиллах тухай санамж бичигт 2013 оны 9 сарын 16-нд гарын үсэг зурсан.

Монгол улсын эдийн засгийн хөгжил усны томоохон хангамж шаардагдах бүс нутгуудын усны нөөцөд ачаалал өгөх юм. Иймээс ус нь зарим тохиолдолд эдийн засгийн өсөлт хөгжлийг хязгаарлах хүчин зүйл болох ч бас боломжийг бий болно. Энэхүү шинжилгээг цахилгаан станц, нүүрс угаах үйлдвэр, нүүрс шингэрүүлэх болон шахмал түлшний үйлдвэр зэрэг нэмүү өртөг шингэсэн нүүрсний технологиудад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж буй Тавантолгой, Нялга Шивээ-Овоогын нүүрсний уурхайн бүсэд чиглэн хийв. Шинжилгээний хүрээнд тус бүс нутгуудад усны эрэлт хангамжийн зөрүү 2040 онд ямар байх талаар үнэлгээ хийж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор дээрх зөрүүг арилгах боломжит шийдлүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлсэн юм.

Ус хангамж, усны эрэлт хэрэгцээний одоогийн байдал

Дээрх бүс нутгуудад бий болох усны эрэлт хэрэгцээг 2030, 2040 оны байдлаар бага, дунд, өндөр эрэлттэй хувилбаруудаар тооцож үзэв. Мөн хэрэгжсэн болон төлөвлөсөн боловч хэрэгжээгүй төслүүдийг ялган авч үзсэн. Нялга Шивээ-Овоогийн бүсэд төлөвлөсөн бүх төслүүдийг хэрэгжүүлэхэд ус хангамж, усны эрэлтийн зөрүү 2040 онд усны өндөр эрэлттэй хувилбараар 35% (34.25 сая м³/жил), бага болон дунд эрэлттэй хувилбаруудаар 30-31% байна. Харин Тавантолгойн бүсэд төлөвлөсөн бүх төслүүдийг хэрэгжүүлэхэд ус хангамж, усны эрэлтийн зөрүү усны өндөр эрэлттэй хувилбараар 60% (18.85 сая м³/жил), дунд эрэлттэй хувилбараар 33% тус тус байна.

Ус хангамжийг нэмэгдүүлэх, усны эрэлт хэрэгцээг бууруулах шийдлүүдэд хийсэн усны эдийн засгийн шинжилгээ

Шинжилгээний хүрээнд усны эрэлт хэрэгцээг бууруулах, ус хангамжийг нэмэгдүүлэх олон төрлийн арга хэмжээг тодорхойлсон ба эдгээрийг хэрэгжүүлбэл Нялга-Шивээ Овоогийн бүсэд жилд 67.34 сая м³ (зөрүү: 34.25 сая м³/жил), Тавантолгой бүсэд 53.11 сая м³ (зөрүү: 18.85 сая м³/жил) ус хэмнэх боломжтой байна. Эдгээр усны эрэлтийг бууруулах, ус хангамжийг нэмэгдүүлэх талаар энэ санал болгож буй арга хэмжээг хэрэгжүүлснээр усны нөөц нь нийгэм, эдийн засгийн цаашдын хөгжлийг боомилох хүчин зүйл болохгүй юм.


Усны эдийн засгийн шинжилгээний дүнгээр Нялга-Шивээ Овоогийн бүсийн өндөр эрэлттэй хувилбараар ус хангамж, усны эрэлтийн зөрүүг суурь технологийн хувилбартай харьцуулахад жилд 33.2 сая ам.долларын өсөн нэмэгдэх зардлаар арилгах боломжтой.¹ Хамгийн зардал багатай шийдлүүд нь уурхайн буюу төлөвлөсөн төслүүдийн тоосжилт дарах аргыг өөрчлөх, хөргөх систем болон хөргөлтийн ус боловсруулах үр ашгийг нэмэгдүүлэх, FGD болон усны хэмнэлттэй шүргэгч суурилуулах зэрэг усны эрэлтийг багасгах арга хэмжээ юм. Энэ бүгд нийлээд дээрх зөрүүг 86%-иар бууруулах боломжтой. Үлдсэн 4.7 сая м³/жил-ийн зөрүүг шинээр газрын доорх ус татах цооногуудын байгууламж хангах боломжтой. Судалгаанд хамрагдсан говийн бүсийн газрын доорх ус үл нөхөгдөх тул газрын доорх усыг олборлохоос өмнө усны эрэлтийг багасгах өртөг хямд шийдлүүдийг бодож олох хэрэгтэй. Ингэснээр усны эрэлт, ус хангамжийн зөрүү арилгах зардлыг 36.5 сая ам.доллар/жил хүртэл өсгөх ба 2.95 сая м³ (4.7 сая м³/жил-ийн оронд) усыг жилд тухайн орчин дахь газрын доорх уснаас хангахаар байна.

Усны эдийн засгийн шинжилгээгээр дагуу Тавантолгойн бүсийн өндөр эрэлттэй хувилбараар ус хангамж, усны эрэлтийн зөрүүг суурь технологийн хувилбартай харьцуулахад 21.0 сая ам.доллар/жилийн өсөн нэмэгдэх зардлаар арилгах боломжтой. Усны эрэлт багасгах хамгийн зардал багатай шийдлүүд нь тоосжилт дарах аргыг өөрчлөх, хуурай аргаар нүүрс цэвэршүүлэх технологи нэвтрүүлж хэрэгжүүлэх зэрэг юм. Эдгээр эрэлтийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр ус хангамж, усны эрэлтийн зөрүүг 50%-ийг арилгах боломжтой. Үлдсэн 9.5 сая м³/жилийн зөрүүг шинээр газрын доорх ус татах цооногуудын байгууламж хангах боломжтой (2). Судалгаанд хамрагдсан бүсийн газрын доорх ус нөхөн сэргээгдэхгүй тул юуны түрүүнд усны эрэлтийг бууруулах бүх боломжит арга хэмжээг


¹Бүх зардлын тооцоог “Эквивалент жилийн зардал”-аар буюу активын ашиглалтын хугацааны жилийн хөрөнгийн, үйл ажиллагааны болон засвар үйлчилгээний зардлаар үзүүлэв.

хэрэгжүүлэх хэрэгтэй. Санал болгож буй усны эрэлтийг бууруулах бүх арга хэмжээг хэрэгжүүлснээр нийт 11.5 сая м³/жил ус хэмнэх боломжтой юм. Энэ нь усны эрэлт, ус хангамжийн зөрүү арилгах зардлыг 22 сая ам.доллар/жил хүртэл өсгөх ба 7.4 сая м³ (9.5 сая м³/жил-ийн оронд) усыг жилд тухайн орчин дахь газрын доорх уснаас хангах юм. Түүнээс гадна Орхон-Говь төслийг хэрэгжүүлсэнээр дээрх зөрүүг арилгах боломж бас бий. Гэхдээ уг төслийн зардал маш өндөр (212 сая ам.доллар) бөгөөд голын урсац, цаашдын эрэлт зэрэг тодорхойгүй байдалтай холбоотой эрсдлүүд бий.

Зураг 1 Нялга-Шивээ Овоо –Зардлын нэгдсэн муруй (санхүү, эдийн засаг, байгаль орчны шалгуураар)



Зураг 2 Тавантолгой –зардлын нэгдсэн муруй (санхүү, эдийн засаг, байгаль орчны шалгуураар)



Цаашдын алхмууд

Усны эрэлтийн ихээхэн хэсгийг төлөвлөлт/боловсруулалтын янз бүрийн шатандаа явж буй уул уурхайн төслүүд үүсгэнэ. Эдгээр төслүүд бүгдээрээ хувирамтгай буюу байнга өөрчлөгддөг ба зах зээл бүхий

нүүрстэй нөөцтэй холбоотой байна. Хэрэв төслийн хэрэгжилтэд тодорхойгүй байдал их бол өндөр эрэлттэй хувилбарын зөрүү арилгах шийдлүүдийг хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргах хэрэгтэй. Барихаар төлөвлөж буй дулааны цахилгаан станцуудад усны эрэлт хэрэгцээ өндөр тул ус-эрчим хүчний холбоог авч үзэх талаар хэлэлцэж, стратегийн ач холбогдлын талаар шийдвэр гаргах нь чухал. Цаашлаад оролцогч талууд үл нөхөгдөх газрын доорх усны нөөц ашиглах, холбогдох шийдлүүдийг хэрэгжүүлэх бэлэн байдлын талаар нэгдмэл шийдвэр гаргах нь зүйтэй. Усны эрэлтийг багасгах бүх арга хэмжээ хувийн болон төрийн өмчит компаниудад хамаатай тул тэдний эдгээр арга хэмжээнд хөрөнгө оруулах чадвар, бэлэн байдлын талаар ойлголттой байх хэрэгтэй. Энэ зорилгоор банкны хөнгөлөлттэй зээл, импортын татварын хөнгөлөлт, усны зөвшөөрлийг тусгай нөхцөлөөр олгох зэрэг санхүүгийн болон бусад дэмжлэгийг тодорхойлон хэрэгжүүлж болно. Эцэст нь хэлэхэд дээрх шийдлүүдийг авч хэрэгжүүлэхийн өмнө Засгийн газраас өмнө нь тогтоож баталсан болон шинээр тогтоосон усны нөөцөд эл түрүүнд байгаль орчны нөлөөллийг авч үзэн, техник эдийн засгийн болон байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, судалгаа хийж усны ашиглах боломжит нөөцийг баталгаажуулах шаардлагатай.

Гарчиг

1. Үйл явцын товчоон.....	9
1.1. Монгол улсын нүүрсний салбарын өнөөгийн хөгжил, ач холбогдол	9
1.2. Говийн бүсэд өмнө хийсэн болон явагдаж буй уул уурхайн үйл ажиллагаа	11
1.3. Тайлан дахь судалгааны бүс нутгууд: Тавантолгой, Нялга-Шивээ Овоогийн хүрэн нүүрсний бүс.....	12
1.3.1. Нялга-Шивээ Овоогийн хүрэн нүүрсний бүс.....	12
1.3.2. Тавантолгойн нүүрсний бүс.....	13
2. Судалгааны талаар товчхон.....	16
2.1. Зорилго	16
2.2. Судалгааны талаар товчхон	16
2.3. Оролцогч талуудын хэлэлцүүлэг	20
3. Бүс нутгийн усны асуудал: Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг тодорхойлох нь	21
3.1. Усны эрэлтийн үнэлгээ, хувилбар боловсруулалт	21
3.1.1. Усны эрэлтийн үнэлгээ.....	21
3.1.2. Усны эрэлтийн хувилбар боловсруулах нь	22
3.1.3. Нийт усны эрэлтийн тойм	23
3.2. Усны нөөцийн үнэлгээ	24
3.2.1. Нүүрсний уурхайн шүүрлийн болон боловсруулалтаас гарах усыг эргүүлэн ашиглах нь	25
3.2.2. Одоо байгаа усны нийт нөөц.....	26
3.3. Усны баланс: Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг тодорхойлох нь	26
3.4. Нялга-Шивээ Овоогийн хүрэн нүүрсний бүс.....	26
3.5. Тавантолгой.....	28
4. Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах боломжит шийдлүүдийг тодорхойлох нь..	30
4.1. Усны эрэлтийг бууруулах шийдэл.....	30
4.1.1. Дулааны цахилгаан станц (ДЦС), нүүрс шингэрүүлэх үйлдвэр (НШҮ).....	30
4.1.2. Шахмал түлшний үйлдвэр	31
4.1.3. Нүүрс угаах үйлдвэр	31
4.1.4. Нүүрс олборлолт	32
4.2. Ус хангамжийг нэмэгдүүлэх шийдлүүд	33
4.2.1. Газрын доорх ус ашиглах нэмэлт талбайг тодорхойлох	33
4.2.2. Гадаргын ус шилжүүлэн ашиглах.....	35
5. Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах шийдлүүдийг эрэмбэлэх, сонгох.....	37
5.1. Үнэлгээний хүрээ	37
5.2. Зардлын муруйн танилцуулга	39
5.3. Зардлын муруй.....	41
5.3.1. Зардлын нэгдсэн муруй – Нялга-Шивээ Овоогийн бүс.....	42
5.3.2. Зардлын нэгдсэн муруй –Тавантолгойн бүс	46
5.3.3. Хагас чанарын болон чанарын шалгуурууд	48
5.3.4. Усны эрэлтийг бууруулах арга хэмжээний тухайд	49
6. Дүгнэлт, зөвлөмж	50
6.1. Тулшгамдсан асуудал/ Сорилт	50

6.2. Эн тэргүүнд хэрэгжүүлэх шийдлүүд.....	50
6.3. Дараагийн алхмууд	51
7. Үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөө	54
Хавсралт А. Хавсралтууд.....	55
А.1. Нэмэлт тайлангийн товч мэдээлэл	55
А.2. Оролцогчидийн жагсаалт (Ярилцлага, Зорилтот бүлгэтэй хийсэн хэлэлцүүлэг болон семинар).....	55
А.3. ГДУ-ны тогтоогдсон нөөцүүд	61
А.4. Усны нэмэлт баланс.....	64
А.5. Усны эрэлт нийлүүлэлтийг арилгах боломжит шийдлүүдийг тодорхойлох.....	66
А.6. Үнэлгээний алгачлал	93
А.7. Санхүүгийн зардлын муруй	97
А.8. Зардлын муруйд харуулсан арга хэрэгсэлүүд нарийвчилсан мэдээлэл	105

Зургийн жагсаалт

Зураг 1 Нялга-Шивээ Овоо – нэгдсэн зардлын муруй (санхүү, эдийн засаг, байгаль орчны шалгуур)	3
Зураг 2 Тавантолгой – нэгдсэн зардлын муруй (санхүү, эдийн засаг, байгаль орчны шалгуур)	3
Зураг 3 Нүүрс үйлдвэрлэл ба экспорт, 2005-2014 (зүүн), Монгол улсын ашигт малтмалын экспортын орлого (баруун)	10
Зураг 4: Монгол улсын уул уурхайн салбарт хийсэн хөрөнгө оруулалт	10
Зураг 5 Судалгааны бүс - Нялга-Шивээ Овоо	13
Зураг 6 Судалгааны талбай – Тавантолгойн бүс нутаг	15
Зураг 7 Судалгааны өндөр түвшний зорилго	16
Зураг 8 Нялга-Шивээ Овоо (зүүн) болон Тавантолгойн (баруун) өндөр эрэлттэй хувилбарын ус хангамж, усны эрэлтийн зөрүү	17
Зураг 9 Нялга-Шивээ Овоо - нэгдсэн зардлын муруй (санхүү, эдийн засаг, байгаль орчны шалгуурууд).....	18
Зураг 10 Тавантолгой - нэгдсэн зардлын муруй (санхүү, эдийн засаг, байгаль орчны шалгуурууд).....	18
Зураг 11 Нялга-Шивээ Овоо бүсийн усны баланс – төлөвлөсөн төслүүд хэрэгжих тохиолдол дахь усны эрэлтийн хувилбарууд	27
Зураг 12 Нялга-Шивээ Овоо бүсийн усны баланс (өндөр эрэлттэй хувилбар, төлөвлөсөн төслүүд хэрэгжинэ гэж үзэх)	27
Зураг 13 Тавантолгой бүсийн усны баланс - бүх хувилбараар төлөвлөсөн төслүүд хэрэгжинэ гэж үзэх ...	28
Зураг 14 Тавантолгой бүсийн усны баланс (өндөр эрэлттэй хувилбар, төлөвлөсөн төслүүд хэрэгжинэ гэж үзэх)	29
Зураг 15 ДЦС, НШҮ-ийн усны эрэлт багасгах техникийн боломжууд	31
Зураг 16 Шахмал түлшний үйлдвэрийн усны эрэлт багасгах техникийн хувилбарууд	31
Зураг 17 Нүүрс угаах үйлдвэрийн усны хэрэгцээг бууруулах техникийн хувилбарууд	32
Зураг 18 Уурхайн тоосжилт дарахад хэрэглэдэг усны эрэлт бууруулах техникийн хувилбарууд.....	32
Зураг 19 Тодорхойлсон УТБТ-аас татах, харьцангуй нэмэлт усны хэмжээ	34
Зураг 20 Бүсийн хэмжээний УТБТ-аас татах, харьцангуй нэмэлт усны хэмжээ.....	35
Зураг 21 Ус хангамж, усны эрэлтийн зөрүү арилгах шийдлүүдийг эрэмбэлэх үнэлгээний аргачлал	37
Зураг 22 Зардлын муруйг хэрхэн тайлбарлах вэ?	41
Зураг 23 Нялга-Шивээ Овоо бүс – Нэгдсэн зардлын муруй	42
Зураг 24 Тавантолгой – Нэгдсэн зардлын муруй.....	46
Зураг 26 ШТҮ-ийн усны эрэлтийг бууруулах техникийн боломжууд	68
Зураг 27. Нүүрс угаах үйлдвэр дэхь усны эрэлтийг бууруулах техникийн хувилбарууд.....	69
Зураг 28. Уурхайн ашиглалтын талбайн тоосжилтыг дарахад усны эрэлтийг бууруулах техникийн хувилбарууд.	70
Зураг 29 Нялга Шивээ Овоо бүсийн тогтоосон ус татах талбай.....	86
Зураг 30. Сонгож авсан ус татах талбайгаас нэмэлтээр ус татах ундарга	87
Зураг 31 Тавантолгой бүсэд тогтоосон ус татах талбай.....	88
Зураг 32 Тавантолгойн бүстэй ойролцоох хүрэн нүүрсний ордод тогтоосон ус татах талбай.....	88
Зураг 33. Тухайн бүсэд байгуулах ус татах талбайгаас нэмэлтээр авах ундарга.....	89
Зураг 34 Нялга Шивээ Овоо – Санхүүгийн зардлын муруй	97
Зураг 35 Таван Толгой – Санхүүгийн муруй	101

Хүснэгт

Хүснэгт 1 Нялга-Шивээ Овоо бүсэд төлөвлөгдөж буй төслүүдийн тойм	12
Хүснэгт 2 Тавантолгойн бүс нутагт хийгдэж буй болон төлөвлөсөн бүтээн байгуулалтын тойм	14
Хүснэгт 3 Тавантолгойн бүсэд төлөвлөсөн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт болон усны эрэлтийн хувилбарууд	22
Хүснэгт 4 Нялга-Шивээ Овоо бүсийн нийт усны эрэлт	23
Хүснэгт 5 Тавантолгойн бүсийн нийт усны эрэлт	23
Хүснэгт 6 Нялга-Шивээ Овоо бүсийн уурхайн шүүрлийн усны боломжит нөөц	25
Хүснэгт 7 Тавантолгой бүсийн уурхайн шүүрлийн усны боломжит нөөц	25
Хүснэгт 8 Нялга-Шивээ Овоо бүсийн газрын доорх усны батлагдсан нөөц	26
Хүснэгт 9 Тавантолгой бүсийн газрын доорх усны батлагдсан нөөц	26
Хүснэгт 10 Нялга-Шивээ Овоо бүсийн бүх хувилбаруудаар харуулсан ус хангамж, усны эрэлт	27
Хүснэгт 11 Тавантолгой бүсийн бүх хувилбаруудаар харуулсан ус хангамж, усны эрэлт	28
Хүснэгт 12 Нялга-Шивээ Овоо бүсийн ус татах байгууламжийн талбайн тухай мэдээлэл	34
Хүснэгт 13 Тавантолгойн бүсэд тодорхойлсон УТБТ-нууд	35
Хүснэгт 14 Үнэлгээний аргачлалын шалгуурууд	38
Хүснэгт 15 Нялга-Шивээ Овоо – Эрэмбэлсэн шийдлүүдийн жагсаалт (нэгдсэн зардлын муруй)	43
Хүснэгт 16 Тавантолгой – Эрэмбэлсэн шийдлүүдийн жагсаалт (нэгдсэн зардлын муруй)	46
Хүснэгт 17 Нялга-Шивээ Овоо бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа оролцогч талууд	52
Хүснэгт 18 Тавантолгой бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа оролцогч талууд	53
Хүснэгт 19. Ярилцлага хийсэн оролцогч талуудын жагсаалт	55
Хүснэгт 20 Хоёр дахь хэлэлцүүлэгт оролцосон оролцогч талууд	58
Хүснэгт 21. ОУСК-ийн Дугуй ширээний уулзалтад оролцосон оролцогч талуудын жагсаалт	59
Хүснэгт 22. Нялга Шивээ Овоо уурхайн бүсэд тогтоогдсон ГДУ-ны нөөц	61
Хүснэгт 23. Таван Толгойн бүсэд тогтоогдсон ГДУ-ны нөөц	62
Хүснэгт 26. Өндөр өсөлттэй хувилбараар нүүрс угаах үйлдвэрийн усны эрэлтийг бууруулах боломжууд	69
Хүснэгт 27. Усны өндөр эрэлтийн хувилбараар тоосжилтыг дарахалд усны эрэлтийг бууруулах боломжууд	71
Хүснэгт 28.Таван Толгой болон Нялга Шивээ Овоо дахь дулааны цахилгаан станцад авч ашиглах технологид хэрэглэгдэх усны тооцоо	72
Хүснэгт 29 Нялга Шивээ Овоо бүсэд шинээр төлөвлөсөн НШҮ-ийн технологийн хувилбаруудыг авч ашиглахад шаардагдах усны тооцоо	76
Хүснэгт 30. Шинээр төлөвлөсөн ШТҮ-ийн технологийн хувилбаруудыг авч ашиглахад шаардагдах усны тооцоо	83
Хүснэгт 31. Тавантолгой бүсэд шинээр төлөвлөсөн нүүрс угаах үйлдвэрийн технологийн хувилбаруудыг авч ашиглахад шаардагдах усны тооцоо	83
Хүснэгт 32. Нүүрс олборлотод технологийн хувилбаруудаас тоосжилт дарахад авч ашиглахад усны тооцоолол (Их эрэлтийн хувилбараар)	84
Хүснэгт 33 Нялга Шивээ Овоо бүсийн ус татах талбайн мэдээлэл	86
Хүснэгт 34 Тавантолгой бүсийн ус татах талбайн мэдээлэл	89
Хүснэгт 35. Орхон-Говь ус дамжуулах схемийн хөрөнгийн зардлын тооцоо – Хувилбар С	92
Хүснэгт 36. Орхон-Говь ус дамжуулах схемийн үйл ажиллагааны зардлын тооцоо – Хувилбар С	92
<i>Зураг 37. Нялга Шивээ Овоо –Шийдлүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлсэн жагсаалт (санхүүгийн шалгуур)</i>	<i>98</i>
<i>Хүснэгт 38 Таван Толгой – Шийдлүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлсэн жагсаалт (Санхүүгийн шаардлага)</i>	<i>102</i>
Хүснэгт 39. Нялга Шивээ Овоо бүсэд ус хангамжийг нэмэгдүүлэх арга хэрэгсэлүүдийн зардлын үр ашигтай байдал (санхүүгийн, амнах хувилбаруудтай харьцуулсанаар)	105
Хүснэгт 40. Тавантолгой бүсийн ус хангамжийг нэмэгдүүлэх арга хэрэгсэлүүдийн зардлын үр ашигтай байдал (санхүүгийн, амнах хувилбаруудтай харьцуулсанаар)	115
Хүснэгт 41. Нялга Шивээ Овоо бүсийн ус хангамжийг нэмэгдүүлэх арга хэрэгсэлүүдийн зардлын үр ашигтай байдал (санхүүгийн, амнах хувилбаруудтай харьцуулсанаар)	118
Хүснэгт 42. Тавантолгой бүсийн ус хангамжийг нэмэгдүүлэх арга хэрэгсэлүүдийн зардлын үр ашигтай байдал (санхүүгийн, амнах хувилбаруудтай харьцуулсанаар)	130

МЭДЭЭЛЭЛ, ЗӨВЛӨМЖӨӨР ХАНГАСАН:

Др. Дэчинлхүндэвийн Доржсүрэн (Цэнгэг усны хүрээлэн)
Хелен Лаури (Граундвотр Менежмент Солушн)
Бусад оролцогч талууд

ТОВЧИЛСОН ҮГС

AFW	Амек Фостер Вийлэр
АОУХА	Австралийн олон улсын хөгжлийн агентлаг
BAT	Шилдэг боломжит технологи
CFB	Нойтноор эргэлдүүлэх технологи
Chalco	Хятадын хөнгөн цагааны корпораци
CTB	Шахмал нүүрсний үйлдвэр
CTL	Нүүрс шингэрүүлэх
EAC	Нийт зардал эквалент
GWMC	Газрын доорх усны менежментийн шийдэл Groundwater Management Solutions
IBRD	Олон улсын сэргээн босголтын банк
IC	Нэмэлт өртөг
IFC	Олон улсын санхүүгийн корпораци
MEGDT	Байгаль орчин, Ногоон хөгжил, Аялал жуулчлалын яам
MINIS	Уул уурхайн дэд бүтэц, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл
MRAM	Ашигт малтмалын газар
OTIA	Оюу Толгой хөрөнгө оруулалтын гэрээ
PwC	Прайс Уотер Хайс Күүперс
SDC	Швейцарийн Хөгжлийн Агентлаг
SEFIL	Strategic Entities Foreign Investment Law
SGR	Өмнийн говийн бүс
TC	Нийт зардал
TNC	The Nature Conservancy
TPP	Дулааны цахилгаан станц

ЖИН, ХЭМЖҮҮР

км	километр
кВт	киловатт цаг
л	литр
м	метр
мв	мегаватт
мвц	мегаватт цаг
ам.доллар	АНУ-ын доллар

1. Үйл явцын товчоон

2030 Усны нөөцийн бүлэг (2030 УНБ) нь төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэл, хамтын ажиллагааны талбар бөгөөд улс орнуудын Засгийн газарт эдийн засгийн өсөлт, урт хугацааны хөгжлийг дэмжихэд чиглэсэн усны нөөцийн тогтвортой менежментийг санаачлах, эрчимжүүлэхэд туслах, дэмжлэг үзүүлэх зэргээр ажилладаг. 2030 УНБ-ээс усны салбарын өөрчлөлт шинэчлэлийг явуулахдаа гол оролцогч талуудыг татан оролцуулж улс төр болон бизнесийн удирдлагуудын аль алинд ойлгомжтой байдлаар бэлтгэсэн усны нөөцийн болон түүний тогтвортой менежментийн талаар иж бүрэн мэдээллийг хүргэх замаар тэдгээрийг идэвхжүүлэн, нэгдмэл зорилготой, илүү харилцан ойлголцлыг бий болгоход нь дэмждэг юм.

Монгол улсын Засгийн газар болон 2030 УНБ Монгол улсад тулгамдаж байгаа усны асуудлаар хамтран ажиллах тухай санамж бичигт 2013 оны 9 сарын 16-нд гарын үсэг зурсан. Монгол улсын усны нөөцийн тулгамдсан асуудлын талаар илүү тодорхой ойлголт авах үүднээс “Монгол улсын усны нөөцийн менежментэд зорилтот шинжилгээ хийх” төслийг хэрэгжүүлсэн бөгөөд үүнийг **Энэтхэг, Монгол, Германы Прайсюотерхаус Куперс (PwC) болон Стихтинг Дэлтарэсийн** мэргэжилтнүүдээс бүрдсэн олон улсын багаар гүйцэтгүүлсэн юм. Шинжилгээний үр дүн дээр үндэслэн БОНХАЖЯ-тай хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай 3 бүсийн тухайлбал Тавантолгой, Нялга-Шивээ Овоо, Улаанбаатар зэрэг 3 бүсийн онцгойлон анхаарахаар сонгосон бөгөөд ингэснээр байгаль орчин, нийгмийн хэрэгцээг давхар авч үзсэн болно. Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах шийдлүүдийг тодорхойлж эрэмбэлэх, орон нутгийн асуудлуудыг уялдуулахын тулд энэхүү судалгааг **PwC Энэтхэг компанийн Монгол дахь салбар, Амек Фостер Вийлер (AFW), Жи Даблю Эм Эс (GWMC)**-ийн мэргэжилтнүүд багтсан олон улсын баг гүйцэтгэв. Мөн түүнчлэн Амек Фостер Вийлер (AFW) болон Жи Даблю Эм Эс (GWMC)-ийн мэргэжилтнүүд Орхон-Говь төсөлд нарийвчилсан шинжилгээ хийж үнэлгээ дүгнэлт өгөн энэхүү судалгаанд оруулсан.

Тайлангийн Хавсралт А.1-т судалгааны тухай нэмэлт материал, мэдээллийн эх үүсвэрүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг оруулсан бөгөөд түүнээс энэхүү судалгааны мэдээллийн эх үүсвэр, үр дүнгийн талаар илүү гүнзгий ойлголт авч болох юм.

1.1. Монгол улсын нүүрсний салбарын өнөөгийн хөгжил, ач холбогдол

Монгол улс нь нүүрс, зэсийн батлагдсан ихэнх нөөц, тэрнээс гадна бас алт, цагаан тугалга, вольфрам болон бусад эрдсийн орд ихтэй, эрдэс баялагийн нөөцөөр баян орон. Тус улсын ашигт малтмалын нөөцийн дөнгөж 15% нь судлагдсан бөгөөд 17%-д хайгуул хийгдэж байна.² 2013 оны 11-р сарын байдлаар тус улсын нийт нутаг дэвсгэрийн 29%-ийг хамарсан хиймэл дагуулын зураглал хийсэн байна.³ Нүүрс, зэс, алтны дэлхийд томоохонд тооцогдох ордууд Монгол улсад илрээд байгаа билээ.

Монгол улсын нүүрсний батлагдсан нөөц 170 тэрбум орчим тонн гэж тооцоологдсон ба ихэнх нөөц нь нарийвчлан судлагдаагүй. Тавантолгой нь Монгол Улсын нүүрсний хамгийн том нөөцтэй орд газар бөгөөд дэлхийд томоохонд тооцогддог нүүрсний ордуудын нэг (ойролцоогоор 7.42 тэрбум тн нөөцтэй). Нийт нөөцийн 75% нь эрчим хүчний нүүрс ба дотоодын хэрэглээнд голчлон ашиглагддаг. Үлдсэн 25% нь гангийн үйлдвэрлэлийн гол орц болох коксжих нүүрс бөгөөд Хятад улс руу экспортолдог. Шивээ Овоо нь тус улсын хоёр дахь том нүүрсний орд газар бөгөөд 2.7 тэрбум орчим тонн нөөцтэй. Эрчим хүчний нүүрсээр ихэвчлэн Улаанбаатарын дулааны цахилгаан станцуудыг хангадаг. Монгол улсад олборлож

²Престиж ХХК, УУДБХОДТ, БОНХАЖЯ, Дэлхийн банк (2014) – Санхүү, эдийн засаг, байгаль орчин, нийгмийн анхан шатны судалгааны тайлан – Орхон голын урсгал өөрчлөх, усан сангийн цогцолбор барих ТЭЗҮ-ийн Ажлын удирдамж боловсруулалт


³ Оксфордын бизнес групп (2014) Монгол улсын тайлан, хуудас (91 - 102)

Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах эрэмбэлсэн шийдлүүд
PwC

буй нийт нүүрсний 53%-ийг экспортолж, 30%-ийг дотоодын түлшний хэрэглээнд зориулж, 17%-ийг үйлдвэрлэлд ашиглаж байна.⁴


Монгол улсын эдийн засагт уул уурхайн салбар чухал үүрэг гүйцэтгэдэг: 2014 онд тус салбар ДНБ-ий 17 %, экспортын 83%-ийг бүрдүүлсэн. Сүүлийн жилүүдэд ашигт малтмалын бүтээгдэхүүн, ялангуяа зэс, нүүрс экспортын орлогын 80 гаруй хувийг бүрдүүлж байв. Гэтэл нүүрсний үнэ ихээхэн хэлбэлзэж нүүрсний үйлдвэрлэл, экспорт, улмаар Монгол улсын эдийн засагт шууд нөлөөлөх болсон (Зураг 3). Тиймээс цахилгаан үйлдвэрлэл, нүүрсийг шингэрүүлэх, шахмал түлш үйлдвэрлэх, нүүрс угаах зэрэг түүнд нэмүү өртөг шингэсэн технологи нэвтрүүлэх нь экспортын орлогыг өсгөх, тогтмолжуулах чухал ач холбогдолтой.

Зураг 3 Нүүрсний үйлдвэрлэл ба экспорт, 2005-2014 (зүүн), Монгол улсын ашигт малтмалын экспортын орлого (баруун)



Монгол улсын нүүрсний 50 гаруй хувийг хувийн хэвшлийн уул уурхайн компаниуд үйлдвэрлэдэг. 4-р зурагт үзүүлснээр нийт хөрөнгө оруулалт, ялангуяа уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт 2012 онд оргил цэгтээ хүрч, 2014 онд буурсан байна.

Зураг 4: Монгол улсын уул уурхайн салбарт хийсэн хөрөнгө оруулалт



Эх сурвалж: Монгол улсын Үндэсний статистикийн газар, 2015 оны 9 сар

2010-2012 оны уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын гэнэтийн огцом өсөлтийг дараахь хүчин зүйлсээр тайлбарлаж болох юм. Үүнд: 1) Хятадын эрдэс түүхий эдийн эрэлт хэрэгцээний өсөлт, 2) Монгол улсын Засгийн газар, Канадын Айвенхоу Майнс компанитай Оюутолгойн зэс, алтны ордыг олборлох хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурсан явдал. Тус гэрээ нь дэлхийн санхүүгийн хямралд өртөөд байсан эдийн засгийн өсөлтийг 2010-2012 оны хооронд хангасан гэж хэлж болно. 2013 оноос эхлэн саарсан уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт нь 1) дэлхийн зах зээл дээр нүүрсний үнэ унасан; 2) Хятадын эрдэс түүхий эдийн эрэлт хэрэгцээ буурч, Австралийн өрсөлдөх чадвар нэмэгдсэн, 3) улс төрийн тогтворгүй байдал, засгийн газрын үр ашигтай ажиллагаа суларсан зэрэгтэй холбоотой. 3-рт

⁴Монгол улсын УСГ (2015 оны 9 сар)

Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах эрэмбэлсэн шийдлүүд
PwC

дурдсан Засгийн газраас баталсан хууль болон бодлоготой холбоотой шалтгаан нь дараахь 3 шийдвэрээс улбаатай:

- a) **Хөрөнгө оруулалтын тухай тодорхой бус хууль**– Хятадын Хөнгөн цагааны корпорац (Чалко) Саус Гоби Ресурсийг худалдаж авах санал гаргасантай холбогдуулж Засгийн газраас 2012 оны 5 сард баталсан Стратегийн аж ахуйн нэгжийн гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль. Тус хуульд стратегийн ач холбогдолтой аж ахуй нэгж дэх гадаадын хөрөнгө оруулалтын хувь хэмжээ 49%-ийн босгоос хэтрэхээр бол УИХ-аас зөвшөөрөл авах тухай заасан байдаг.
- b) **Тусгай зөвшөөрлүүдийг цуцалсан**– 2013 онд Дээд шүүхээс АМГ-ын даргын авилгад өртсөн хэрэгтэй холбогдуулж 106 тусгай зөвшөөрөл цуцалсан.
- c) **Бодлогын өөрчлөлт** – 2012 онд давхар татварын 4 гэрээ цуцалсан. Мөн Рио Тинто компанитай Оюутолгой төслийн талаар хийсэн маргаан сунжирсан.

Хөрөнгө оруулагчдын сонирхлыг буцаан сэргээх нь Монгол улсын хувьд зайлшгүй бөгөөд үүний нэг чухал хэсэг болох ус хангамжийн асуудлыг хөгжилд чөдөр тушаа болохооргүй зохицуулах ёстой юм.

1.2. Говийн бүсэд өмнө хийсэн болон явагдаж буй уул уурхайн үйл ажиллагаа

Улсын хэмжээний усны нөөцийн судалгаа нэлээд өмнө нь хийгдсэн (2000 оноос хойш) бөгөөд өмнөд говийн бүсийг онцгойлон анхаарах болсон. Энэ нь ашигт малтмалын хайгуулын ажлуудын үр дүн, олон тооны ордуудын олборлолт эхэлсэн, улмаар үйлдвэрлэлийн болон суурин газруудын усны эрэлт хэрэгцээ өссөний үр дагавар юм. Өмнөд говийн бүсийн хуурай уур амьсгал, газрын доорх усны нөөц нь орон нутгийн том хэмжээний ус хангамжийн шийдэл боловсруулах ганц боломж нь болдог.

1970 оноос эхлэн тус бүс нутагт газрын доорх усны судалгааг эрчимтэй хийж, газрын доорх усны олон орд илрүүлсэн. Эдгээр ордын нөөцийн үнэлгээ, ус хангамжийн потенциалыг улсын хэмжээнд мөрдөх болсон албан ёсны аргачлалын дагуу тооцож хийсэн бөгөөд энэ нь тус бүсийн нөөцийн үнэлгээнд гол үндэс болж байна. Сүүлийн жилүүдэд өмнөд говийн бүсэд усны эрэлт, ус хангамжийн судалгаа нэлээн хийгдсэн боловч цар хүрээ, судалгааны арга, бүс нутаг, нэр томъёоны хувьд ялгаатай байна. Тиймээс энэ төрлийн судалгааны үр дүнг харьцуулахдаа үүнийг бодолцон, судалгааны онцлог нь хөгжлийн төлөвлөлт хийхэд төөрөгдөл, тодорхойгүй байдалд хүргэж болохыг анхаарах нь зүйтэй.

Засгийн газрын албан ёсны нөөцийн үнэлгээнээс гадна газрын доорх усны нөөц болон эрэлтийн үнэлгээний талаарх гол тайлангуудад дараахь баримт бичгүүд багтана: Говийн бүсийн газрын доорх усны нөөцийн үнэлгээ⁵, Өмнөд говийн бүсийн байгаль орчны үнэлгээ⁶, Монголын өмнөд бүсийн дэд бүтцийн стратеги⁷, Монгол улсын усны менежментийн нэгдсэн төлөвлөгөө⁸, Орхон голд урсацын тохируулга хийж усан цогцолбор байгуулах ажлын санхүү, эдийн засаг, байгаль орчин, нийгмийн анхан шатны судалгааны тайлан – ТЭЗҮ-ийн ажлын удирдамж боловсруулах нь ⁹, Монгол улсын Усны нөөцийн менежментэдхийсэн зорилтот шинжилгээ зэрэг орно^{10,11}.

Мөн говийн бүсийн уул уурхайд чиглэсэн усны менежментийн гол үйл ажиллагаануудыг дурьдвал:

- ОУСК-иас зохион байгуулж буй “Өмнө говийн ус ба уул уурхайн салбарын дугуй ширээний уулзалт” нь уул уурхайн (2013-2016) усны менежментэд оролцогч талуудыг зохицуулан оролцуулдаг ба хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа эрхэлдэг компаниудын усны менежментийн практикийг сайжруулах, талуудын оролцоог дэмжих, орон нутгийн ус хангамжийн тухай бодит

⁵Туинхоф, Буянхишиг (2010) Монголын говийн бүсийн газрын доорх усны үнэлгээ

⁶Дэлхийн банк (2010) Өмнө говийн бүсийн байгаль орчны үнэлгээ

⁷ЕСБХБ & Дэлхийн банк (2009) Монголын өмнөд бүсийн дэд бүтцийн стратеги

⁸БОНХАЖЯ (2013) Усны менежментийн нэгдсэн төлөвлөгөө, Монгол

⁹Престиж ХХК, УУДБХОДТ, БОНХАЖЯ, Дэлхийн банк (2014) – Санхүү, эдийн засаг, байгаль орчин, нийгмийн анхан шатны судалгааны тайлан – Орхон голын урсгал өөрчлөх, усан сангийн цогцолбор барих ТЭЗҮ-ийн Ажлын удирдамж боловсруулалт

¹⁰ 2030 УНБ (2014) Монгол улсын Усны нөөцийн менежментийн асуудлын шинжилгээ. Боловсруулсан: PwC/Deltares.

¹¹ Дэлгэрэнгүйг Тайлангийн Нэмэлтээс үзэж болно: # 2.2 Анхны нөөцийн үнэлгээний судалгаануудын харьцуулалт. Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах эрэмбэлсэн шийдлүүд

ойлголтыг тэдэнд өгч уул уурхайн үйл ажиллагаа, нөлөөллийг нутгийн иргэдэд мэдээлэхэд голлон ажилладаг.

- Дэлхийн банк болон Австралийн олон улсын хөгжлийн агентлагаас (АОУХА) санхүүжүүлсэн “Газрын доорх усны менежментийг бэхжүүлэх нь” төсөл нь “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” (УУДБХОД) төслийн хэсэг юм. Энэ төслөөр газрын доорх усны менежментийг хариуцдаг төрийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, Газрын доорх усны менежмент, мэдээллийн нгэж байгуулахад төвлөрч ажилладаг. УУДБХОД төсөл нь (2013-2016) газарзүйн байршлын хувьд Дорноговь, Өмнөговь, Дундговь аймгуудыг хамардаг ба төслийн хүрээнд Усны сав газрын 1 зөвлөл, Усны сав газрын 3 захиргаа байгуулан ажиллаж байна.
- Азийн сангаас Швейцарийн хөгжлийн агентлагийн (ШХА) санхүүгийн дэмжлэгтэйгээр “Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь-II” төслийг хэрэгжүүлж байгаа ба тус төсөл нь бичил уурхай буюу гар аргаар ашигт малтмал олборлолтоос байгаль орчинд (ус, хөрс г.м) үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилготой. Төсөл нь бичил уурхайн салбараас орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах, бичил уурхай эрхлэгчдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, зохистой ажлын байраар хангагдах эрхийг нь хангахад хувь нэмэр оруулахад чиглэдэг.

1.3. Тайлан дахь судалгааны бүс нутгууд: Тавантолгой, Нялга-Шивээ Овоогийн хүрэн нүүрсний бүс

1.3.1. Нялга-Шивээ Овоогийн хүрэн нүүрсний бүс

Нялга-Шивээ Овоогийн хүрэн нүүрсний бүс нь Улаанбаатар хотоос зүүн урд зүгт оршдог. Энэ судалгаанд ойролцоо байрлалтай, төлөвлөн хэрэгжүүлж буй төслүүд болох Шивээ Овоо, Төгрөг нуур, Бөөрөлжүүтийн тал гэсэн 3 гол уурхайг хамруулсан. Улаанбаатар хотын ДЦС-уудын нүүрсний хэрэгцээг одоогийн байдлаар төрийн өмчит Шивээ-Овоо, Багануурын уурхайгаас (судалгааны бүсийн хойд хэсэгт оршдог) хангадаг. Тус 2 уурхайг өргөтгөх ажлын төлөвлөгөө хийгдэж байгаа ба Төгрөг нуур, Бөөрөлжүүтийн тал гэсэн төстэй 2 уурхайд шинээр олборлолт хийх төсөл эхэлж байна. Судалгаанд авч үзсэн төлөвлөгдөж байгаа төслүүдийн жагсаалтыг **Хүснэгт 1 Нялга-Шивээ Овоо бүсэд төлөвлөгдөж буй төслүүдийн тойм**.

Бүс нутгийн усны нөөц болон эрэлтийн нэгдсэн судалгаа хийхийн тулд судалгааны талбайг уурхайнуудын орчимд 50-100 км-ээр сунгасан (

Зураг 5). Судалгааны бүс нь Хэрлэн, Умард говийн гүвээт халхын дундад тал гэсэн 2 сав газрыг, Төв, Говьсүмбэр, Дундговь аймгуудыг хэсэгчлэн хамарч оршино. Түүнчлэн Чойр-Нялгын хонхрын нүүрс агуулагч бүсийн хагас нь судалгааны бүсэд багтсан. Гидрологийн хүндралыг харгалзан судалгааны талбайг тогтоохдоо Хэрлэн, Төвийн ус сав газар зэрэг жижиг талбайг хамардаг голуудын сав газрыг оруулаагүй.

Хүснэгт 1 Нялга-Шивээ Овоо бүсэд төлөвлөгдөж буй төслүүдийн тойм


Но.	Төлөвлөгдөж буй төслүүд	Хүчин чадал	Оператор компани	Байршил	Ус татах (м³/жил)	Статус	Судалгаан дахь дугаар
1	Цахилгаан станц	270 мв	Ван Пауэр Глобал Лимитэд	Шивээ Овоо	860,000	Төлөвлөсөн	1
2	Цахилгаан станц	750 мв	АйЭм Пауэр Плс	Шивээ Овоо	4,793,472	Төлөвлөсөн	2
3	Цахилгаан станц	5280 мв	Хятадын Стэйт Грид корпорац	Шивээ Овоо	15,700,000	Төлөвлөсөн	3
4	Цахилгаан станц	600 мв	Цэцэнс майнинг & энерги	Бөөрөлжүүтийн тал	2,000,000	Төлөвлөсөн	4

Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах эрэмбэлсэн шийдлүүд
PwC

5	НШҮ	Жилд 600,000 т дизель/газولين	Гермон Газ ХХК	Шивээ Овоо	4,777,536	Төлөвлө сөн	24
6	НШҮ	Жилд 880,000 т дизель/газولين; 84,00 т LPG; 50,000 т бусад бүтээгдэхүүн	СиТиЭл Монголиа ХХК	Төгрөг нуур	10,000,000	Төлөвлө сөн	5
7	НШҮ	Жилд 500,000 т дизель/газولين	Цэцэнс майнинг & энержи	Бөөрөлжүүти йн тал	4,500,000	Төлөвлө сөн	6
8	ШТҮ	Жилд 57,600 т коксжих нүүрс	Камэкс ХХК	Төгрөг нуур	57,600	Төлөвлө сөн	10

Тайлбар: Дугаарыг зардлын муруй болон цаашидын судалгаанд хэрэглэнэ.

Зураг 5 Судалгааны бүс - Нялга-Шивээ Овоо



1.3.2. Тавантолгойн нүүрсний бүс

Өмнөд говьд орших өндөр чанартай коксжих нүүрсний Тавантолгой орд нь Монгол улсын хамгийн их нөөцтэй (6.4 тэрбум тонн) бүс. Тавантолгой орд нь Ухаа худаг, Цанхи (баруун, зүүн), Бортолгой, Бортээг, Баруун өмнөд, Зүүн гэсэн 6 хэсэгт хуваагддаг. Ухаа худагаас бусдыг нийлүүлээд цаашид Тавантолгой гэж нэрлэнэ.

Судалгаанд Ухаа худаг болон Тавантолгой ордыг хамрууллаа. Нэгдсэн үнэлгээ хийх зорилгоор судалгааны талбайн радиусыг ордуудын эргэн тойронд 50-100 км-ээр авч үзсэн (Зураг 6) учраас судалгааны талбайд Занаду майнс-ын тусгай зөвшөөрлийн талбай орсон, харин Оюутолгой орд (зэсийн

ордууд) ороогүй. Түүнээс гадна судалгааны талбайд аймгийн төв Даланзадгад, Цогтцэций сум зэрэг суурин газрууд хамрагдсан.

Судалгааны талбай нь Өмнөговь аймгийн Галба Өөш Долоодын говь, Умард говийн гүвээт халхын дундад тал, Онги гэсэн 3 голын сав газрыг хэсэгчлэн хамрав. Судалгааны талбайг тогтоохдоо Алтайн өвөр говийн сав газар зэрэг жижиг талбайг хамардаг голуудын сав газрыг оруулаагүй.

Баруун Цанхийн уурхайн хувьд олон улсын уул уурхайн компаниудын консорциумтай гэрээ байгуулах шатанд явж байна. Гэрээ байгуулж тус ордоос олборлолт эхэлбэл жилийн нүүрс үйлдвэрлэл 3.6 сая тонноос¹² 20 сая тонн¹³ хүрэх төлөвтэй бөгөөд төмөр зам, 450мв хүчин чадалтай ДЦС, нүүрс угаах үйлдвэр барих бүтээн байгуулалтын ажлууд эхэлнэ. Одоо хийгдэж байгаа болон төлөвлөсөн нийт бүтээн байгуулалтын тухай тойм мэдээг **Хүснэгт 2** -аас харна уу.

Хүснэгт 2 Тавантолгойн бүс нутагт хийгдэж буй болон төлөвлөсөн бүтээн байгуулалтын тойм


Но.	Хийгдэж буй/төлөвлөгдөж буй төслүүд	Хүчин чадал	Оператор компани	Байршил	Усны хэрэглээ (м³/жил)	Статус	Судалгаан дахь дугаар
1	Цахилгаан станц	18 мв	Монголиан Майнинг корпорац	Ухаа худаг	132,000	Байгаа	17
2	Цахилгаан станц	450 мв	Консорциум яригдаж байгаа / MCS Энержи удирдана	Тавантолгой	1,200,000	Төлөвлөсөн	18
3	Нүүрс угаах үйлдвэр	15 сая түүхий нүүрс	Монголиан Майнинг корпорац	Ухаа худаг	756,864	Байгаа	28
4	Нүүрс угаах үйлдвэр	Мэдээлэл байхгүй (хуурай технологи)	Тавантолгой JSC	Тавантолгой	0	Байгаа боловч одоогоор ажиллаагүй	27
5a	Нүүрс угаах үйлдвэр	15 сая түүхий нүүрс	Консорциум яригдаж байгаа / MMC удирдана	Ухаа худаг	2,270,592	Төлөвлөсөн	32
5b	Нүүрс угаах үйлдвэр	30 сая түүхий нүүрс	Консорциум яригдаж байгаа / Эрдэнэс Тавантолгой удирдана	Тавантолгой	4,541,184	Төлөвлөсөн	25
5c	Нүүрс угаах үйлдвэр	5 сая түүхий нүүрс	Эрдэнэс Тавантолгой ХҮ	Тавантолгой	0	Төлөвлөсөн	27
6	Нүүрс угаах үйлдвэр	Мэдээлэл байхгүй (хуурай технологи)	Тавантолгой ХҮ	Тавантолгой	0	Төлөвлөсөн	27

Тайлбар: #5a, #5b, #5c дугаартай нүүрс угаах үйлдвэрүүд нь хийгдэж буй төлөвлөлтөөс хамаарна. Дэлгэрэнгүйг 3-р бүлгээс харна уу. Шинжилгээнд #27 дугаартай төслүүдийн хувьд сайжруулах зүйлс хийгдэхгүй тул цаашид судлаагүй.

Зураг 6 Судалгааны талбай – Тавантолгойн бүс нутаг

¹²Mongolia Extractive Industries Transparency Initiative, Ninth EITI Reconciliation Report 2014, by KPMG, December 2015

¹³ “ Монголын мега төслүүд”, Монголын эдийн засаг сэтгүүл, 2013-10-09



Уурхай: Ухаа худаг
Оператор компани:
Энержи Ресурс

Уурхай: Тавантолгой
Оператор компани:
Энержи Ресурс
компани: Эрдэнэс ТТ

Уурхай: Тавантолгой
Оператор компани:
Тавантолгой ХК



Төлөвлөж буй цахилгаан
станц



Одоогийн цахилгаан
станц



Төлөвлөсөн нүүрс угаах
үйлдвэр




Одоогийн нүүрс угаах
үйлдвэр

2. Судалгааны талаар товчхон

2.1. Зорилго

Энэхүү шинжилгээгээр цахилгаан станц, нүүрс угаах болон шингэрүүлэх үйлдвэр, шахмал түлшний үйлдвэр зэрэг нүүрсэнд нэмүү өртөг шингэсэн технологиудад далайцтай хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөгдөж буй Тавантолгой, Нялга-Шивээ Овоогийн¹⁴ бүс нутагт гол анхаарал хандууллаа. Эдгээр бүтээн байгуулалтын ажилд ус шийдвэрлэх хүчин зүйл болно. Тус шинжилгээний хүрээнд өнөөгийн болон 2030, 2040 онуудад ус хангамж, усны эрэлтийн зөрүү ямар байхыг тооцоолон усны нөөцөд тулгарч болзошгүй асуудлыг тодруулж, оролцогч талуудад ойлгуулах зорилготой юм. Ойлголтыг илүү тодорхой болгохын тулд усны эрэлтийг бага, дунд, өндөр гэсэн 3 хувилбараар тооцлоо. Түүнээс гадна дээрх төслүүд хэрэгжих эсэх нь баталгаатай бус тул ус хангамж, усны эрэлтийн зөрүүнд эдгээр төлөвлөж байгаа төслүүдээс үзүүлэх нөлөөллийг тогтоохын тулд бүх төслүүд хэрэгжих болон хэрэгжихгүй байх тохиолдлуудад хувилбарууд ямар байх талаар авч үзэв. Үүний дараа ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах олон тооны шийдлүүдийг авч үзсэн ба үүнд усны эрэлтийг бууруулах, ус хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээнүүд орно. Эдгээр арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлж, Монголчуудын болон Монгол улсын сайн сайхны төлөө хэрхэн хамгийн бага зардлаар хэрэгжүүлэх талаар зөвлөмж боловсруулав.

Зураг 7 Судалгааны өндөр түвшний зорилго



2.2. Судалгааны талаар товчхон

Усны эрэлт, ус хангамжийн үнэлгээгээр уурхайн шүүрлийн ус болон эргүүлэн ашиглах усыг оруулаад дээрх хоёр бүс нутгийн усны бэлэн байгаа нөөц нь бүх төслүүд хэрэгжих тохиолдолд 2040 оны усны эрэлтийг хангахад хангалттай хүрэлцэхүйц тооцоо гарч байна.¹⁵

Нялга Шивээ-Овоогийн бүсэд төлөвлөж буй бүх төслүүдийг хэрэгжүүлэхэд ус хангамж, усны эрэлтийн зөрүү 2040 онд усны өндөр эрэлттэй хувилбараар 35% (34.25 сая м³/жил), бага болон дунд эрэлттэй хувилбаруудаар 30-31% байна. Харин Тавантолгойн бүсэд төлөвлөсөн бүх төслүүдийг хэрэгжүүлэхэд ус


¹⁴ Уурхайнуудын эргэн тойрны 50-100 км газрыг газрын доорх ус олборлоход санхүүгийн хувьд боломжийн хувилбар гэж тооцсон тул тухайн 50-100 км газрыг судалгааны талбайд хамруулсан.

¹⁵ Бага усны эрэлттэй хувилбараар Тавантолгойд усны эрэлт, ус хангамжийн зөрүү гарахгүй.

Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах эрэмбэлсэн шийдлүүд
PwC

хангамж, усны эрэлтийн зөрүү усны өндөр эрэлттэй хувилбараар 60% (18.85 сая м³/жил), дунд эрэлттэй хувилбараар 33% байна (Зураг 8 Нялга-Шивээ Овоо (зүүн) болон Тавантолгойн (баруун) өндөр эрэлттэй хувилбарын ус хангамж, усны эрэлтийн зөрүү).

Зураг 8 Нялга-Шивээ Овоо (зүүн) болон Тавантолгойн (баруун) өндөр эрэлттэй хувилбарын ус хангамж, усны эрэлтийн зөрүү




Усны эрэлт, ус хангамжийн үнэлгээ болон сонгосон хувилбаруудын талаар дэлгэрэнгүйг 3-р бүлгээс үзнэ үү.

Эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн ус хангамж, усны эрэлтийн зөрүү арилгах олон шийдлийг тодорхойлсон ба үүнд ус хангамжийг нэмэгдүүлэх, усны эрэлтийг бууруулах арга хэмжээнүүд багтсан. Усны эрэлтийг бууруулах шийдэл гэдэг нь ус хэрэглээний үр ашгийг дээшлүүлэх гэх мэт үйл ажиллагааг бага усаар хийж гүйцэтгэх арга зам олох тухай юм. Ус хангамж нэмэгдүүлэх шийдэлд гадаргын ус шилжүүлэн ашиглан, ус нөөцлөх, гүний ус олборлох зэргээр усны нөөцийг нэмэгдүүлэх үйл ажиллагаанууд багтана. Эдгээр шийдлүүд нь одоо хэрэгжиж байгаа болон төлөвлөж буй төслүүдэд тусгайлан зориулсан бөгөөд олон улсын сайн туршлагауудыг дагаж мөрдсөн. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлбэл Нялга-Шивээ Овоогийн бүсэд 55.64 сая м³/жил (зөрүү: 34.25 сая м³/жил), Тавантолгойн бүсэд 57.12 сая м³/жил (зөрүү: 18.85 сая м³/жил) усны нөөцтэй болох боломжтой ба мөн дээрх зөрүүг арилгах боломжтой.


Техникийн шийдэл, ус хэмнэх/нэмэгдүүлэх боломжуудын талаарх дэлгэрэнгүйг 4-р бүлгээс үзнэ үү.

Энд авч үзсэн шийдлүүдийг хэрэгжүүлбэл ус хангамж, усны эрэлтийн зөрүү арилгах шаардлагыг давуулан биелүүлэх тул шийдлүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлсэн ба ингэж эрэмбэлэхдээ санхүү, эдийн засаг, байгаль орчны шалгууруудыг багтаасан үнэлгээний аргачлалыг үндэс болгож, усны нөөцийг хамгийн бага зардлаар нэмэгдүүлэх шийдлүүдийг тодорхойлсон. Хамгийн зардал багатай шийдэл бол м3 усанд хамгийн бага зардал (ам.доллар/м³) гаргаж усны эрэлт багасгах, эсвэл ус хангамж нэмэгдүүлэх арга хэмжээ юм. Эдгээр шийдлүүдийг зардлын үр ашгаар нь ангилахад “зардлын муруй” гэсэн график гарна. Ингэхэд метр куб усанд хамгийн бага зардал гаргах усны эрэлт багасгах, ус хангамж нэмэгдүүлэх хамгийн тохиромжтой шийдлүүд нь графикийн зүүн талд байрлаж байна. Графикийн баруун тал руу шилжүүлэхэд шийдлүүдийн зардал өндөр болж байна. Багана буюу шийдэл тус бүрийн өргөн нь хэр их усны нөөц бий болохыг харуулна. Тэгэхээр нарийн багануудад усны хэмнэлт бага байх буюу ус хангамж нэмэгдүүлэх боломж тааруу байхад өргөн багануудад эсрэгээрээ байна. Нялга-Шивээ Овоо болон Тавантолгойн бүсүүдийн зардлын муруйг Зураг 9 Нялга-Шивээ Овоо - , Зураг 10 Тавантолгой - тус тус харуулав.

Зураг 9 Нялга-Шивээ Овоо - Зардлын нэгдсэн муруй (санхүү, эдийн засаг, байгаль орчны шалгууруудаар)



Зураг 10 Тавантолгой - Зардлын нэгдсэн муруй (санхүү, эдийн засаг, байгаль орчны шалгууруудаар)



44

Саарал өнгөөр сүүдэрлэсэн хэсэг нь ус хангамж, усны эрэлтийн зөрүүний хэмжээг харуулна. Багануудын өнгө нь зургийн доорх тайлбарт заасан арга хэмжээний бүлэгт хамаарна.

Усны эдийн засгийн шинжилгээгээр Нялга-Шивээ Овоогийн бүсийн усны өндөр эрэлттэй хувилбараар ус хангамж, усны эрэлтийн зөрүүг одоогийн технологийн хувилбартай харьцуулахад 33.2 сая ам.доллар/жилийн өсөн нэмэгдэх зардлаар арилгах боломжтой.¹⁶ Өсөн нэмэгдэх зардал нь одоо байгаа технологид хөрөнгө оруулах буюу эдгээрийг сайжруулахад шаардлагатай зардал бөгөөд хэрэв боломжтой бол эдгээр технологийг бүрэн шинэчлэх буюу нийт зардалтай харьцуулсан зардал юм. Хамгийн зардал багатай шийдлүүд нь уурхайн буюу төлөвлөсөн төслүүдийн тоосжилт дарах аргыг өөрчлөх, хөргөх систем болон хөргөлтийн ус боловсруулахтай холбоотой үр ашгийн нэмэгдүүлэх, цахилгаан станцын уураас сулфурыг ялгаж авах болон усны хэмнэлттэй шүршигч суурилуулах зэрэг усны эрэлт багасгах арга хэмжээнүүд юм. Энэ бүгд нийлээд дээрх зөрүүг 86%-иар арилгах боломжтой. Үлдсэн 4.7 сая м³/жил-ийн зөрүүг газрын доорх ус олборлох байгууламжаар хангах боломжтой. Судалгаанд хамрагдсан говийн бүсийн газрын доорх ус үл нөхөгдөх тул түүнийг дахин олборлохоос өмнө усны эрэлтийг бууруулах илүү өртөг хямд шийдлүүдийг бодож олох хэрэгтэй. Ингэснээр усны эрэлт, ус хангамжийн зөрүү арилгах өсөн нэмэгдэх зардлыг 36.5 сая ам.доллар/жил хүртэл өсгөх ба 2.95 сая м³-ийг (4.7 сая м³/жил-ийн оронд) жилд тухайн орчны газрын доорх усны нөөцөөс олборлох шаардлага гарна.

Усны эдийн засгийн шинжилгээний дүнгээр Тавантолгойн бүсийн өндөр эрэлттэй хувилбараар ус хангамж, усны эрэлтийн зөрүүг одоогийн технологийн хувилбартай харьцуулахад 21.0 сая ам.доллар/жилийн өсөн нэмэгдэх зардлаар арилгах боломжтой. Усны эрэлт багасгах хамгийн зардал багатай шийдлүүд нь тоосжилт дарах аргыг өөрчлөх, хуурай аргаар нүүрс цэвэршүүлэх технологи нэвтрүүлж хэрэгжүүлэх зэрэг юм. Эдгээр эрэлт багасгах арга хэмжээг хэрэгжүүлснээр ус хангамж, усны эрэлтийн зөрүүг 50% арилгах боломжтой. Үлдсэн 9.5 сая м³/жилийн зөрүүг газрын доорх ус олборлох цооногийн байгууламжаар хангах боломжтой (2). Судалгаанд хамрагдсан бүсийн газрын доорх ус үл нөхөгдөх нөөцтэй тул усны эрэлт багасгах бүх боломжит арга хэмжээг юуны түрүүнд хэрэгжүүлэх хэрэгтэй. Санал болгосон усны эрэлт багасгах бүх арга хэмжээг хэрэгжүүлснээр нийт 11.5 сая м³/жил ус хэмнэх боломжтой. Тухайн орчны газрын доорх уснаас 7.4 сая м³/жил (9.5 сая м³/жил-ийн оронд) авч ашиглахын тулд усны эрэлт, ус хангамжийн зөрүү арилгах нэмэлт зардлыг 22 сая ам.доллар/жил хүртэл өсгөнө. Түүнээс гадна дээрх зөрүүг Орхон-Говь ус дамжуулах төсөл хэрэгжүүлж арилгах боломж бас бий. Гэхдээ тус төслийн зардал маш өндөр (212 сая ам.доллар) бөгөөд голын урсац, цаашдын эрэлт зэрэг тодорхойгүй байдалтай холбоотой эрсдлүүд бий.

Үнэлгээний аргачлал, зардлын муруй, одоо хийгдэж буй болон төлөвлөсөн төсөл арга хэмжээний тухай дэлгэрэнгүйг 5-р бүлгээс үзнэ үү. Санхүү, эдийн засаг, байгаль орчны шалгууруудыг багтаасан зардлын нэгдсэн муруйгаас гадна дан ганц санхүүгийн шалгуурт үндэслэсэн санхүүгийн зардлын муруйг бас харуулав.

Судалгааны бүсийн усны эрэлтийн ихээхэн хэсгийг төлөвлөлт/боловсруулалтын янз бүрийн шатандаа явж буй уул уурхайн төслүүд үүсгэнэ. Эдгээр төслүүд бүгд хувирамтгай буюу байнга өөрчлөгддөг зах зээлээр тодорхойлогддог нүүрсний нөөцтэй холбоотой. Өнөөдрийн байдлаар төлөвлөлт/боловсруулалтын янз бүрийн шатандаа байгаа төслүүдийг хэрэгжүүлэх эсэх нь эргэлзээтэй. Хэрэв эдгээр төслүүд хэрэгжихгүй бол Тавантолгойн өндөр эрэлттэй хувилбараас бусад тохиолдолд ус хангамж, усны эрэлтийн зөрүү гарахгүй тул техникийн шийдлүүд шаардлагагүй болно. Төслүүд хэрэгжих эсэх нь эргэлзээтэй хэвээр байвал уламжлалт аргыг санал болгох ба өндөр эрэлттэй хувилбарын ус хангамж, усны эрэлтийн зөрүү арилгах шийдлүүдийн тухай шийдвэрийг ямар ч тохиолдолд гаргах хэрэгтэй. “Хамгийн муу тохиолдлын хувилбар”-ын ус хангамжийн талаарх баталгаатай, тодорхой байдал нь хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, улмаар эдийн засгийн өсөлт, хүртээмжийг дэмжих боломжтой.

Засгийн газрын үйл ажиллагаа: Үл нөхөгдөх газрын доорх усны нөөцөө ашиглах, тохиромжтой шийдлүүдийг хэрэгжүүлэх талаар Засгийн газар санаачилж оролцогч бүх талууд нэгдсэн шийдвэрт хүрэх хэрэгтэй. Түүнчлэн төлөвлөж буй дулааны цахилгаан станцуудын усны эрэлт өндөр тул ус-эрчим хүчний шинжилгээг авч үзэх, стратегийн ач холбогдлын талаар нэгдсэн шийдвэрт хүрэх хэрэгтэй. БОНХАЖЯ, ЭХЯ, УУЯ, АУЯ-наас ус, эрчим хүчний талаарх бодлогын болон стратегийн баримт

¹⁶ Өөр өөр цаг хугаацааны мөчлөгтэй шийдлүүдийг харьцуулахдаа хөрөнгийн болон үйл ажиллагаа, засвар үйлчилгээний зардлыг жилээр тооцсоныг Жилийн Нийт Зардлын Эквалент гэж тодорхойлох ба бүхий л зардлын тооцоонд үүнийг дурьдах болно.

Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах эрэмбэлсэн шийдлүүд
PwC

бичгүүдийг нэгтгэж уялдаа холбоог ханган ажиллах нь зүйтэй. Үүнээс гадна талууд урамшууллаар ажил үүрэг гүйцэтгэх, эсвэл өөрсдийн үйл ажиллагааг сонгох зэргийн аль хэсэгт зохицуулалт хийх шаардлагатай байгааг шийдэх хэрэгтэй. Төлөвлөсөн үр дүнд хүрэхийн тулд гарсан шийдвэрүүдийг хэрэгжүүлж, биелэлтийг хангуулж, хянах шаардлагатай. Үүний тулд усны үнэлгээний аргачлал, ус ашигласны болон бохирдуулсны төлбөр, хотын усны тариф зэргийг шинэчлэх талаар хэлэлцэж байгаа 2030 УНБ-ийн “Усны үнэлгээ ба урамшуулал”-тай нягт уялдуулах боломжтой.

Компаниуд/хөрөнгө оруулагчдад холбогдох үйл ажиллагаа: Усны эрэлт багасгах бүх арга хэмжээ хувийн хэвшлийн болон төрийн өмчит компаниудад хамаатай тул тэдний эдгээр арга хэмжээнд хөрөнгө оруулах чадвар, бэлэн байдал болоод технологи нэвтрүүлэх боломжийн талаар ойлголттой байх хэрэгтэй. Энэ зорилгоор банкны хөнгөлөлттэй зээл, импортын татварын хөнгөлөлт, усны зөвшөөрлийг тусгай нөхцөлөөр олгох зэрэг санхүүгийн болон бусад дэмжлэгийг тодорхойлж болно. Монголын болон гадаадын компаниудын хооронд мэдлэг дамжуулах, чадавх бэхжүүлэх нь компаниуд/хөрөнгө оруулагчдад оновчтой, зардал багатай шийдэл олж хэрэгжүүлэхэд тус нэмэр болно. Үүний тулд усны асуудалд голлон анхаардаг уул уурхайн сайн дурын бүлэг байгуулж болох ба үүн дээр ОУСК-ийн Уул уурхайн дугуй ширээний техникийн багтай хамтарч ажиллах боломжтой.

Оролцогч талуудын хэлэлцүүлгийн ач холбогдол: Дээрх шийдвэрүүд бүх Монголчуудад шууд болон шууд бусаар нөлөөлөх тул оролцогч талуудын хэлэлцүүлэг чухал ач холбогдолтой.

Эцэст нь хэлэхэд тодорхойлсон шийдлүүдийг хэрэгжүүлэхийн өмнө Засгийн газраас баталсан болон шинээр тогтоосон усны нөөцөд байгаль орчны нөлөөллийн, техник эдийн засгийн болон байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, судалгаа хийж баталгаажуулах шаардлагатай.

Зөвлөмж, цаашдын алхмууд, хэлэлцүүлэгт оролцох гол оролцогч талуудын тухай дэлгэрэнгүй мэдээллийг 6-р бүлгээс үзнэ үү.

2.3. Оролцогч талуудын хэлэлцүүлэг

Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцогч талуудын хэлэлцүүлэг нь энэхүү судалгааны үе шатуудад тэргүүлэх ач холбогдолтой байв. Малчид, уурхайчид, орон нутгийн удирдлагууд зэрэг орон нутгийн болон засгийн газар, компанийн удирдлагууд, ТББ-ууд зэрэг үндэсний түвшний оролцогч талуудтай хэлэлцүүлэг хийв. Оролцогч талуудын хэлэлцүүлгээс гарсан мэдээллийг дараахь зүйлсэд ашиглав. Үүнд:

- Анхдагч ба хоёрдогч мэдээлэл цуглуулах,
- Нүүрсний болон нүүрстэй холбоотой салбаруудад гарч буй өөрчлөлт, мэдээ мэдээлэл дутмаг байгааг холбогдуулан мэдээллээ хянан баталгаажуулах
- Шийдэл болон үнэлгээний цар хүрээг дэвшүүлэхэд талуудыг оролцуулах,
- Тодорхойлсон шийдлүүдийн боломжийн талаар оролцогч талуудтай хэлэлцэх

Нийт 47 оролцогч ганцаарчилсан ярилцлагад оролцов. Ярилцлагад оролцсон 47 хүнээс 19 нь төрийн, 12 нь хувийн хэвшил, 15 нь ТББ, орон нутгийн иргэд, хөгжлийн агентлаг, засгийн газар хоорондын байгууллагуудын төлөөлөл байв. Ярилцлагаас гадна зорилтот бүлгийн 2 хэлэлцүүлэг хийв. Нэг нь шийдлүүдийг эрэмбэлэх үнэлгээний аргачлал боловсруулж батлах, нөгөө нь судалгааны явцын үр дүнг баталгаажуулах зорилготой байв. Даланзадгадад болсон Олон Улсын Санхүүгийн Корпорацийн уул уурхайн дугуй ширээний уулзалт дээр явцын үр дүнг танилцуулж, оролцсон шинжээчдээс санал авав.

Хэлэлцүүлэгт оролцогчдын жагсаалтыг хавсралтад оруулав.

3. Бүс нутгийн усны асуудал: Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг тодорхойлох нь

3.1. Усны эрэлтийн үнэлгээ, хувилбар боловсруулалт

Усны эрэлтийг суурь (2015) болон 2030, 2040 оны байдлаар үнэлэв. Цаашдын ус ашиглалтын талаар илүү олон талт ойлголттой болохын тулд усны эрэлтийг бага, дунд, өндөр эрэлт гэсэн 3 хувилбараар тооцов.

3.1.1. Усны эрэлтийн үнэлгээ

Усны эрэлтийн үнэлгээг анхдагч болон хоёрдогч мэдээлэлд үндэслэж хийв. Ус ашиглалтын талаар бодит мэдээлэл байхгүй тохиолдолд МУ-ын ЗГ-ын А301 тоот тогтоолд заасан усны норм, нормативыг ашиглав.

Усны эрэлтийн тооцоог зөвхөн судалгааны талбайн хэмжээнд хийв. Зарим тохиолдолд сумдын газар нутаг судалгааны талбайд хэсэгчлэн хамрагдаж байгаа тул төв суурин газрын ахуйн усны эрэлт нь сумын төв судалгааны талбайд багтсан эсэхээс хамаарна. МАА-н болон хөдөөгийн усны эрэлтийн хувьд судалгааны талбайд багтсан газар нутгийн хэмжээ нь энэхүү судалгаанд орсон усны эрэлттэй пропорциональ байна.

Тайлбар		Мэдээллийн эх үүсвэр
ХАА	Сумдын ХАА-н ургац үйлдвэрлэл, үйлдвэрлэсэн ургацын ус ашиглалтын норм болон бүсэд үндэслэв.	- Сумдын захиргаа болон вэб хуудаснаас анхдагч мэдээлэл авав; - МУ-ын ЗГ-ын А301 тоот тогтоол (усны норм)
МАА	Малын тоо толгой (морь, үхэр, тэмээ, хонь, ямаа) болон малын төрөл тус бүрийн ус хэрэглээний нормын тухай мэдээлэлд үндэслэв.	- Монгол улсын YCG (http://en.nso.mn/) - МУ-ын ЗГ-ын А301 тоот тогтоол (усны норм)
Унд ахуй	Хотын болон хөдөөгийн усны эрэлтийн үнэлгээг тус тусад нь хийв. Ус ашиглалтын талаар бэлэн байсан бодит мэдээллийг ашиглав (сумын төвүүдийн). Мэдээлэл байхгүй тохиолдолд сумын хүн амын статистикийг ашиглан усны хэрэглээний ангилалд (төвийн ус хангамжийн систем, гэр хороолол г.м) үндэслэж усны эрэлтийг гаргаж авав.	- Голын сав газрын захиргаа - Монгол улсын YCG (http://en.nso.mn/) - МУ-ын ЗГ-ын А301 тоот тогтоол (усны норм)
Уул уурхай	Уурхайнуудын усны эрэлтийг анхдагч мэдээлэлд үндэслэн тооцсон ба хувилбаруудыг оруулсан. Нэмэлт уурхайнуудын (100 км радиус доторх судалгааны үндсэн талбайн гадна) усны эрэлтийг тусгай зөвшөөрөл, жилийн үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн нэгж тус бүрийн усны хэрэглээнд үндэслэж тооцов.	- Хэлэлцүүлэг, уул уурхайн гол компаниудтай хамтарч мэдээлэл хянаж баталгаажуулах (Хавсралт Error! Reference source not found.-ыг харна уу) - Голын сав газрын захиргаад - Шинжээчийн ярилцлага - АМГ (тусгай зөвшөөрөл)
Үйлдвэрлэл (уул уурхай орохгүй)	Усны бодит хэрэглээнд үндэслэж усны эрэлтийг тооцов.	- Голын сав газрын захиргаад - Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам (БОНХАЖЯ)
Хийгдэж байгаа болон төлөвлөсөн бүтээн байгуулалт	Гол уурхайнуудын үнэлгээ болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг бодит (төлөвлөсөн) усны эрэлт, компаниудын технологийн төрөл, зөвшөөрөл олгосон удирдах байгууллагад үндэслэв. Мэдээллийг дотоодын тогтвортой байдал болон олон улсын жишгийн дагуу	- Эрчим хүчний яам - Уул уурхайн яам - Аж үйлдвэрийн яам - Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам (БОНХАЖЯ)

шалгасан. Компаниудтай холбоо барьж чадаагүй тохиолдолд албан ёсны эх сурвалж ашигласан бөгөөд олон улсын жишгийн дагуу шалгасан.

- Голын сав газрын захиргаад
- Оролцсон компаниуд
- Олон улсын жишиг


3.1.2. Усны эрэлтийн хувилбар боловсруулах нь

Усны эрэлтийн хувилбаруудыг бүтээн байгуулалтын бодит төлөвлөгөө болон шинжээчдийн ярилцлагуудад үндэслэж боловсруулсан ба эдгээрийг байхгүй тохиолдолд “Усны нөөцийн нэгдсэн менежментийг сайжруулах нь төслийн” үр дүн болох, өргөн хэрэглэгддэг Усны эрэлтийн гарын авлагад (2012) заасан усны эрэлтийн хувилбар, урьдчилсан тооцоог ашиглав¹⁷. Энэ нь цаашид Монгол улсад усны нөөцийн менежментийн чиглэлээр хийгдэж буй төрөл бүрийн судалгааны уялдаа холбоог хангахад чиглэгдэнэ.

Тавантолгойн бүсэд төлөвлөж буй бүтээн байгуулалтын ажлуудад зориулж нэмэлт хувилбар боловсруулсан ба учир нь 1) нүүрс угаах үйлдвэр зэргийн зарим хөрөнгө оруулалт нь өөр хоорондоо зөрчилтэй бөгөөд 2) компаниуд бүтээн байгуулалтын төлөвлөгөөндөө зориулж янз бүрийн бага, дунд, өндөр эрэлттэй хувилбар гаргасан. Тиймээс хувилбаруудыг бүтээн байгуулалтын бодит төлөвлөгөөнд үндэслэн боловсруулсан боловч дээр дурдсан асуудал байхгүй тул Нялга-Шивээ Овоон бүсэд ийм хувилбар боловсруулаагүй.

Тавантолгойн бүсэд төлөвлөсөн хөрөнгө оруулалтад хамаарах хувилбаруудыг Хүснэгт 3-аас харна уу.

Хүснэгт 3 Тавантолгойн бүсэд төлөвлөсөн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт болон усны эрэлтийн хувилбарууд



¹⁷ Төслийг Нидерландын вант улсын санхүүжилтээр БОНХАЖЯ хэрэгжүүлсэн. Усны эрэлтийн гарын авлагыг Г.Долгорсүрэн, Вим фон дэр Линдэн, Ч.Пунцагсүрэн нар бэлтгэн гаргасан.

3.1.3. Нийт усны эрэлтийн тойм

Нялга-Шивээ Овоо, Тавантолгойн бүсийн нийт усны эрэлтийн тоймыг Хүснэгт 4, Хүснэгт 5-аас харна уу.

Хүснэгт 4 Нялга-Шивээ Овоо бүсийн нийт усны эрэлт

Сая м ³ /жил	Суурь	Бага эрэлттэй хувилбар		Дунд эрэлттэй хувилбар		Өндөр эрэлттэй хувилбар	
Усны эрэлт – Суурь	2015	2030	2040	2030	2040	2030	2040
ХАА	2.94	3.96	4.83	4.21	5.34	4.49	5.91
МАН	1.43	2.19	3.02	2.19	3.02	2.50	3.72
Ахуйн хэрэглээ (хот)	1.59	2.08	2.54	2.14	2.61	2.26	2.75
Ахуйн хэрэглээ (хөдөө)	0.54	0.65	0.78	0.71	0.84	0.86	1.00
Үйлдвэрлэл	1.72	1.75	1.78	1.78	1.88	1.92	2.46
Уул уурхайн усны эрэлт	0.28	1.13	1.13	2.13	2.13	11.28	11.28
Нийт Суурь	8.49	11.76	14.08	13.17	15.82	23.30	27.12
Усны эрэлт – Төслүүд							
ДЦС-ууд (төлөвлөж буй)		22.33	22.33	22.33	22.33	22.33	22.33
НШҮ, ШТҮ (төлөвлөж буй)		19.34	19.34	19.34	19.34	19.34	19.34
Уурхайн нэмэлт ус		1.83	1.83	1.83	1.83	1.83	1.83
Нийт Төлөвлөж буй төслүүд	-	43.50	43.50	43.50	43.50	43.50	43.50
Нийт усны эрэлт	8.49	55.25	57.58	56.66	59.32	66.79	70.62

Хүснэгт 5 Тавантолгойн бүсийн нийт усны эрэлт

Сая м ³ /жил	Суурь	Бага эрэлттэй хувилбар		Дунд эрэлттэй хувилбар		Өндөр эрэлттэй хувилбар	
Усны эрэлт – Суурь	2015	2030	2040	2030	2040	2030	2040
ХАА	0.01	0.01	0.02	0.01	0.02	0.01	0.02
МАН	0.24	0.34	0.47	0.34	0.47	0.39	0.57
Ахуйн хэрэглээ (хот)	2.13	3.31	4.46	3.33	4.48	3.37	4.53
Ахуйн хэрэглээ (хөдөө)	0.50	0.57	0.65	0.63	0.71	0.74	0.83
Үйлдвэрлэл	0.25	0.38	0.53	0.63	1.17	1.25	3.65
Уул уурхайн усны эрэлт	0.34	1.12	1.12	6.15	6.15	12.71	12.71
Нийт Суурь	3.66	6.87	8.38	10.46	12.38	17.43	21.28
Усны эрэлт – Төслүүд							
ЦС-ууд (төлөвлөж буй)		-	-	1.20	1.20	1.20	1.20
НУҮ (төлөвлөж буй)		-	-	2.27	2.27	4.54	4.54
ЦС (одоо байгаа)	0.13	0.13	0.13	0.13	0.13	0.13	0.13
НУҮ (одоо байгаа)	0.76	0.76	0.76	1.51	1.51	2.27	2.27
Нэмэлт уурхайн ус		-	-	1.17	1.17	1.88	1.88
Нийт Төлөвлөсөн төслүүд	0.89	0.89	0.89	6.28	6.28	10.03	10.03
Нийт усны эрэлт	4.55	7.76	9.27	16.75	18.66	27.46	31.31

Хавсралтаас тооцоолол, мэдээллийн эх үүсвэр, аргачлалын тухай дэлгэрэнгүйг харна уу.

3.2. Усны нөөцийн үнэлгээ

Одоогийн байдлаар судалгааны 2 талбайн газрын доорх усны нөөц нь бэлэн байгаа цорын ганц усны эх үүсвэр юм. Газрын доорх усны нөөцийг бага гүний болон гүний уст давхаргын гэж ангилж болно.

Бага гүний уст давхаргууд харьцангуй нимгэн, нарийн, газрын гадаргаас 10 м хүртэл гүн аллювийн сэвсгэр хурдасны ус шүүрэлттэй холбоотой ба усны гүн <5м байх хандлагатай. Эдгээр уст давхаргууд их хэмжээний бороо орсны дараа борооны усаар тэжээгддэг ба усны чанар цэврээс давсархаг хүртэл байдаг. Их гүний уст давхаргууд нь тухайн бүс нутагт элбэг байдаг томоохон хэмжээний тунамал хурдаст сав газарт 400м хүртэл гүнд оршдог. Эдгээр гүний уст давхаргын дээр зузаан шаварлаг хагшаас байх тул тэжээгдэл муутай буюу үл нөхөгдөх чанартай бөгөөд ус нь давсархаг байдаг.

Бага гүний уст давхаргууд унд, ахуйн хэрэглээ, МАА, тухайн орчны газрын доорх уснаас хамааралтай ургамал, ногооны ус чухал эх үүсвэр болдог. Бага гүний уст давхаргын усны хэрэглээ ерөнхийдөө бага.

Энэхүү судалгааны хүрээнд их гүний уст давхаргын усны нөөцөд гол анхаарал хандуулав. Учир нь (а) их хэмжээний ус олборлолтыг хангахуйц нөөцтэй ба (б) бага гүний уст давхаргууд нь зөвхөн тухайн орчны эрэлтийг хангахад боломжтой байдаг.

Газрын доорх усны одоо байгаа нөөцийг Засгийн газраас баталсан газрын доорх усны нөөцийн үнэлгээг тооцоололд үндэслэж тооцсон. Газрын доорх усыг усны нөөцийн тогтоосон үнэмшилээс хамааруулж А(баттай/батлагдсан); В (тодорхойлогдсон/байж болох); С1/С (авч үзэж болох/боломжит), С2/Р (таамаг) гэсэн 4 ангилалд хуваадаг.

өмнө хийсэн судалгаагаар тогтоосон С1/С, С2/Р нөөцтэй уст давхаргуудын урд үзэхэд газрын доорх усны нийт нөөц боломжтой байж болох ч усны бодит нөөц тооцоолсноос бага байх магадлалтай ба энэ нь ихэвчлэн техникийн болон байгаль орчны хязгаарлалт, асуудалтай холбоотой. С1/С зэрэглэлээр хэсэгчлэн тооцоологдсон Балгасын улаан нуурын (газрын доорх усны нөөцийн судалгааны Тавантолгойн бүс нутаг) тухай саяхны маргаан үүний жишээ юм. Анх тус уст давхаргын нөөцийг 444 л/сек гэж тооцож байсан. Хотгорын төв хэсэгт судалгаа хийсэн КюЖиЭкс (QGX) компани байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээндээ 150 л/сек гэж бууруулсан байдаг. Тус компани газрын доорх усны түвшин тус бүс нутагт хэрхэн доошлохыг тооцоолсон загварчлал, ус олборлолтоос үүдэжнуурын ус ширгэх болон бусад олон тооны сөрөг нөлөөлөл үүсч болзошгүйг тооцож бууруулсан байна.¹⁸. 2008 онд тус бүс нутгийн газрын доорх усны нөөцийг 125 л/сек гэж баталсан. Харин саяхан засгийн газар уг тооцоог эргэж үзсэний үндсэн дээр 404 л/сек болгож дахин өсгөсөн байна.

ГДУМШ компани болон бусад газраас янз бүрийн тунамал чулуулгийн болон гидрогеологийн шинж чанарт голлож урд өмнө хийсэн судалгаануудад Нялга-Шивээ Овоо бүсийн С1/С нөөцтэй уст давхаргуудын нөхцөл баттай нөөц байх өндөр магадлалтайг харуулж байна гэж дүгнэсэн байдаг. Үүнийг нэмэлт ТЭЗҮ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж батлах хүртэл энэхүү судалгаанд Тавантолгойн А, В ангиллын газрын доорх усны уст давхарга, Нялга-Шивээ Овоо бүсийн А, В, С1 уст давхаргуудыг авч үзэв.

Зөвхөн сонгосон ангиллаартооцсон усны нөөцийг авч үзэх, бага гүний уст давхаргын усны нөөцийг оруулахгүй байхаар тогтож энэхүү судалгаанд усны балансын тооцооллыг хийж оруулав. Тиймээс ус хангамж, усны эрэлтийн тодорхойлсон зөрүү нь дутуу тооцсон шиг илүү өндөр байх магадлалтай. Орон нутгийн хэрэглэгчдэд бага гүний уст давхаргын ус чухал бөгөөд гүний уст давхаргууд үл нөхөн сэлбэгдэлийг харгалзан энэ аргачлалыг сонгосон. Усны нөөцийг одоогоор ашиглах эрхийн дагуу ашиглах нөөц гэж үзэхээс илүү нийт тоо хэмжээ гэж үзэх шаардлагатайг тэмдэглэж байна.

¹⁸Экотрэйд (2008) Балгасын улаан нуурын газрын доорх усны нөөцийг олборлох төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан

3.2.1. Нүүрсний уурхайн шүүрлийн болон боловсруулалтаас гарах усыг эргүүлэн ашиглах нь

Шүүрлийн усыг эргүүлэн ашиглах

Нүүрс олборлож буй гүн нь газрын доорх усны түвшнээс доор байрлаж байвал нүүрс олборлохын тулд уурхайн усыг шавхах шаардлагатай. Ус шавхалтын гүн талбай бүрийн тогтоц, шинж чанараас хамаарч харилцан адилгүй байдаг.

Тухайлбал 100 м гүнээс олборлолт хийдэг Шивээ Овоо уурхайн карьер 2 өдрийн дотор дүүрдэг. Ойролцоогоор 110 метрээс олборлолт хийдэг Ухаа худаг уурхайд (Тавантолгойн бүс) шүүрлийн ус маш бага байдаг.

Уурхайн шүүрлийн усны хэмжээг доорх хүснэгтээс харна уу. Хүснэгт дэх мэдээллийг үйл ажиллагаа явуулж байгаа уурхайнуудын ус шавхалтын одоогийн бодит хэмжээ болон бусад талбайн анхан шатны хайгуулын ажлын үр дүнгээс авав.

Хүснэгт 6 Нялга-Шивээ Овоо бүсийн уурхайн шүүрлийн усны боломжит нөөц

Уурхай	Шүүрлийн ус (л/сек)	Шүүрлийн ус (сая м³/жил)
Шивээ Овоо	175	5.52
Төгрөг нуур	200	6.31
Бөөрөлжүүтийн тал	175	5.5
Нийт НШО	□50	17□34

Хүснэгт 7 Тавантолгой бүсийн уурхайн шүүрлийн усны боломжит нөөц

Уурхай	Шүүрлийн ус (л/сек)	Шүүрлийн ус (сая м³/жил)
Ухаа худаг	15	0.47
Баруун наран	2	0.06
Эрдэнэс Тавантолгой, Тавантолгой ХҮ	байхгүй	Байхгүй
Нийт Т	17	0□54

Тайлбар: Эрдэнэс Тавантолгой, Тавантолгой хамтарсан үйлдвэрийн шүүрлийн усны тооцоо байхгүй байсан хэдий ч ЭТГ-н төлөөлөлтэй хийсэн ярилцлага болон гидрогеологийн мэдээллээс үзэхэд нийт шүүрлийн ус маш бага байх төлөвтэй байна. Ухаа худаг, Баруун наран уурхайд Монголиан майнинг корпорац (Энержи рэсурс) олборлолт хийдэг. Шүүрлийн усны хэмжээг компаниас өгсөн жилийн хамгийн бага үйлдвэрлэлийн хэмжээ буюу 5 сая тоннд үндэслэн тооцов.

Хоёр бүс нутгийн шүүрлийн усны чанарыг авч үзэхэд шүүрлийн усанд цэвэршүүлэлт хийлгүй ашиглах боломжтой. Шивээ Овоо уурхайд шүүрлийн усанд цэвэршүүлэлт хийлгүй ашиглаж байгаа ба бусад газруудад ч иймэрхүү байдлаар төлөвлөж байна. Олборлолт явуулахын тулд ус шавхах нь зайлшгүй тул (үйлдвэрлэлд) нөхөгдөшгүй зардалд оруулан нэмэлт ус шавхалтын зардал гаргах шаардлагагүй. Төлөвлөж буй бүтээн байгуулалтууд уурхайнуудтай ойрхон байрлах тул тээвэрлэлтийн зардал гарахгүй.

Энэ бүгдээс үзэхэд шүүрлийн усыг зардлын муруйн ус хангамж, усны эрэлтийн зөрүү арилгах шийдэл гэхээсээ илүү тус судалгааны усны балансын усны нөөцөд оруулан тооцлоо.¹⁹

Боловсруулалтаас гарах усыг эргүүлэн ашиглах нь

Тавантолгойн бүсэд Энержи рэсурс ХХК нь ус цэвэршүүлэх 2 үйлдвэртэй. Сумын төв болон Энержи рэсурс компанийн ажилчдын кемпээс гарсан бохир усыг цэвэршүүлээд Ухаа худаг уурхайн тоосжилт дарахад ашигладаг. Нийт цэвэршүүлсэн буюу эргүүлэн ашигласан ус 5.71 л/сек хүрдэг (0.8 сая м³/жил).

¹⁹ Шүүрлийн усыг ашиглахад зориулсан байгаль орчны болон нийгмийн зардал байхгүй тул шүүрлийн усыг зардлын муруйд оруулаагүй болно.

3.2.2. Одоо байгаа усны нийт нөөц

Хүснэгт 8, Хүснэгт 9-д газрын доорх ус болон шүүрлийн усыг оруулсан хоёр бүс нутгийн усны нөөцийг харуулав.

Хүснэгт 8 Нялга-Шивээ Овоогийн бүсийн газрын доорх усны батлагдсан нөөц

Усны эх үүсвэр	Усны нөөц	
	сая м ³ /жил	л/сек
Газрын доорх ус А ангилал	0.44	13.93
Газрын доорх ус В ангилал	5.92	186.55
Газрын доорх ус С ангилал	12.67	399.44
Шүүрлийн ус	17.34	546.99
Нийт	36.37	1,146.91

Хүснэгт 9 Тавантолгойн бүсийн газрын доорх усны батлагдсан нөөц

Усны эх үүсвэр	Усны нөөц	
	сая м ³ /жил	л/сек
Газрын доорх ус А ангилал	1.61	50.72
Газрын доорх ус В ангилал	10.13	319.5
Шүүрлийн болон боловсруулалтаас гарах ус	0.72	22.58
Нийт	12.46	392.89

Тайлбар: Эдгээр нь зөвхөн тооцоолол бөгөөд усны нөөцийн бодит хэмжээг нэмэлт судалгаа хийж баталгаажуулах шаардлагатай.

А.3 дугаар хавсралтад уст давхарга тус бүрийн усны нөөц болон Нялга-Шивээ Овоо, Тавантолгойн бүсийн уст давхаргын ангиллыг харуулав.

Усны нөөцийн нарийвчилсан тооцоо баталгаажуулалтын дараа нэмэлт усны нөөц тодорхой болно гэдгийг тэмдэглэх нь зүйтэй (3.2.1 дүгээр хэсгээс үзнэ үү). Одоогийн ашиглах боломжит усны тоо хэмжээ Тавантолгой (С1/С, С2/Р) ангиллын уст давхаргууд бүсийн хувьд 20.46 сая м³/жил, Нялга-Шивээ Овоо (судалгааны бүсийн С2 ангиллын уст давхарга) бүсийнх 8.79 сая м³/жил байна.

А.3 хавсралтад дэлгэрэнгүй тооцоолол, мэдээллийн эх үүсвэр, аргачлалын талаар оруулав.

3.3. Усны баланс: Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг тодорхойлох нь

Судалгааны бүсийн ус хангамж, усны эрэлтийн талаар ерөнхий ойлголт өгөхийн тулд усны нийт эрэлтийг одоо байгаа усны нөөцтэй харьцуулав. Төлөвлөж буй бүтээн байгуулалтын төслүүдийн усны эрэлтээс гадна ХАА, МАА, унд ахуй, уул уурхай, бусад салбарын усны эрэлт нийлээд нийт усны эрэлтийг бүрдүүлнэ (дэлгэрэнгүйг 3.1 дүгээр хэсгээс харна уу).

Энэ судалгаагаар төлөвлөж буй бүтээн байгуулалтын төслүүдийг өгөгдсөн усны нөөцөөр хэрэгжүүлж болох эсэхийг тодруулахын хамт бусад салбарын усны эрэлтийг авч үзэх, ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай эсэхийг авч үзлээ.

3.4. Нялга-Шивээ Овоогийн хүрэн нүүрсний бүс


Өнөөгийн болон цаашдын усны эрэлтийг одоо байгаа усны нөөцтэй харьцуулахад 2040 онд өндөр эрэлттэй хувилбараар усны эрэлтийг энэхүү судалгаанд авч үзсэн. Засгийн газраас баталсан газрын доорх усны нөөц болон шүүрлийн усаар хангах боломжгүй байгаа нь тодорхой байна.

Төлөвлөж буй төслүүд хэрэгжихгүй тохиолдолд бүх хувилбараар 2040 онд усны эрэлтийг одоо байгаа усны нөөцөөр хангах боломжтой. Харин төлөвлөж буй төслүүд хэрэгжих тохиолдолд шүүрлийн усыг бүтээн байгуулалтын төслүүдэд ашигласан ч бүх хувилбараар 2030 онд ус хангамж, усны эрэлтийн зөрүү гарахаар байна. (Зураг 11, Хүснэгт 10-ыг харна уу).

Хүснэгт 10 Нялга-Шивээ Овоо бүсийн бүх хувилбаруудаар харуулсан ус хангамж, усны эрэлт


сая м³/жил	Суурь	Бага эрэлттэй хувилбар		Дунд эрэлттэй хувилбар		Өндөр эрэлттэй хувилбар	
	2015	2030	2040	2030	2040	2030	2040
Усны нөөц	36.37	36.37	36.37	36.37	36.37	36.37	36.37
Усны эрэлт (төлөвлөсөн төслүүд хэрэгжихгүй)	8.49	11.76	14.08	13.17	15.82	23.30	27.12
Усны эрэлт (төлөвлөсөн төслүүд хэрэгжих)	8.49	55.25	57.58	56.66	59.32	66.79	70.62
Зөрүү (төлөвлөсөн төслүүд хэрэгжихгүй)	3.97	0.70	(1.62)	(0.71)	(3.37)	(10.84)	(14.66)
Зөрүү (төлөвлөсөн төслүүд хэрэгжих)	3.97	(42.79)	(45.12)	(44.21)	(46.86)	(54.33)	(58.16)

Зураг 11 Нялга-Шивээ Овоо бүсийн усны баланс – төлөвлөсөн төслүүд хэрэгжих тохиолдол дахь усны эрэлтийн хувилбарууд



Зураг 12-т өндөр эрэлттэй хувилбарыг дэлгэрэнгүй харуулсан бөгөөд үүнд 2040 оны усны эрэлтийн 160%-ийг эзлэх төлөвлөж буй бүтээн байгуулалтын төслүүдийн нэмэлт усыг оруулсан. Төслүүдийн өндөр усны эрэлт цахилгаан станц болон НШҮ-үүдийн 2 тэнцүү хэсгээс үүснэ. Тоосжилт дарах, ажилчдын усны хэрэглээ зэрэг уурхайн нэмэлт усны эрэлт харьцангуй бага хувь эзэлнэ.

Зураг 12 Нялга-Шивээ Овоо бүсийн усны баланс (өндөр эрэлттэй хувилбар, төлөвлөсөн төслүүд хэрэгжинэ гэж үзэх)



Бага болон дунд эрэлттэй хувилбарын нэмэлт граfiкийг хавсралтаас харна уу.

Ямар нэг арга хэмжээ аваагүй бөгөөд төлөвлөсөн төслүүдийг хэрэгжүүлэх тохиолдолд өндөр эрэлттэй хувилбарын ус хангамж, усны эрэлтийн зөрүү 35% (34.25 сая м³/жил) хүрнэ. Бага болон дунд эрэлттэй хувилбараар нийт эрэлтийн 30-31%-ийг одоо байгаа нөөцөөр хангаж чадахгүй.

3.5. Тавантолгой

Тавантолгойн судалгааны бүсийн газрын доорх ус, шүүрлийн ус болон боловсруулалтаас гарах усыг оруулсан одоо байгаа усны нөөц нь бага болон дунд эрэлттэй хувилбарын усны суурь эрэлтийг (төлөвлөсөн төслүүд орохгүй) 2040 он хүртэл хангахад хангалттай хүрэлцэхүйц байна. Харин өндөр эрэлттэй хувилбарын усны эрэлтийг 2030 оны байдлаар хангах боломжгүй болох төлөвтэй байна (2030 онд ус хангамж, усны эрэлтийн зөрүү 4.97 сая м³/жил, 2040 онд 8.82 сая м³/жил байна).

Төлөвлөсөн төслүүдийн усны эрэлтийг нэмэхэд (3.1-р хэсгийг харна уу) дунд болон өндөр эрэлттэй хувилбараар 2030 он гэхэд усны эрэлтийг одоо байгаа нөөцөөр хангах боломжгүй тооцоо гарч байна. Харин бага эрэлттэй хувилбараар одоо байгаа нөөц нь усны эрэлтийг хангахад хүрэлцэхээр байна (

Зураг 13). Дунд эрэлттэй хувилбараар ус хангамж, усны эрэлтийн зөрүү 2030 онд 4.29 сая м³/жил, 2040 онд 6.21 сая м³/жил байх бол өндөр эрэлттэй хувилбараар 2030 онд 15 сая м³/жил, 2040 онд 18.85 сая м³/жил байна. Хүснэгт 11-ээс энэ тухай харна уу.

Хүснэгт 11 Тавантолгой бүсийн бүх хувилбаруудаар харуулсан ус хангамж, усны эрэлт

сая м³/жил	Суурь	Бага эрэлттэй хувилбар		Дунд эрэлттэй хувилбар		Өндөр эрэлттэй хувилбар	
	2015	2030	2040	2030	2040	2030	2040
Усны нөөц	12.46	12.46	12.46	12.46	12.46	12.46	12.46
Усны эрэлт (төлөвлөсөн төслүүд хэрэгжихгүй)	4.55	6.87	8.38	10.46	12.38	17.43	21.28
Усны эрэлт (төлөвлөсөн төслүүд хэрэгжих)	4.55	7.76	9.27	16.75	18.66	27.46	31.31
Зөрүү (төлөвлөсөн төслүүд хэрэгжихгүй)	7.91	5.59	4.08	2.00	0.08	(4.97)	(8.82)
Зөрүү (төлөвлөсөн төслүүд хэрэгжих)	7.91	4.70	3.19	(4.29)	(6.21)	(15.00)	(18.85)

Зураг 13 Тавантолгой бүсийн усны баланс - бүх хувилбараар төлөвлөсөн төслүүд хэрэгжинэ гэж үзэх


Зураг 14-т өндөр эрэлттэй хувилбарын усны балансыг дэлгэрэнгүй харуулав. 2040 онд Тавантолгой бүсийн уурхайн усны эрэлт хамгийн өндөр байх нь тодорхой байна. Нэмэлт төслүүдийн усны эрэлт 2040 оны усны эрэлтийг 47%-иар ихэсгэж байна. Шүүрлийн ус нь ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгахад хангалтгүй. Ямар нэг арга хэмжээ авахгүй тохиолдолд 2040 онд усны эрэлтийн 60% (18.85 сая м³/жил) хангагдахгүй хэвээр үлднэ.

Зураг 14 Тавантолгой бүсийн усны баланс (өндөр эрэлттэй хувилбар, төлөвлөсөн төслүүд хэрэгжинэ гэж үзэх)



Бага болон дунд эрэлттэй хувилбарын нэмэлт зардлын мэдээллийг хавсралтаас харна уу.

график



4. Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах боломжит шийдлүүдийг тодорхойлох нь

4.1. Усны эрэлтийг бууруулах шийдэл

Энэ хэсэгт Тавантолгой, Нялга-Шивээ Овоогийн судалгааны бүсэд хэрэгжиж байгаа болон төлөвлөж байгаа төслүүдийн усны эрэлтийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх техникийн боломжит сонголтуудыг авч үзнэ. Усны эрэлт багасгах шийдлүүдийг тодорхойлохдоо ДЦС, НШҮ, ШТҮ, НҮҮ зэрэг бүтээн байгуулалтын төслүүд болон нүүрс олборлолтын үйл ажиллагаанд голлон анхаарсан болно.

Одоо хэрэгжиж байгаа болон төлөвлөгдөж байгаа төслүүдэд ашигласан, одоо байгаа (төлөвлөсөн) технологи, техникийн нөхцөлүүдийг тодорхойлж, суурь байдлаар хэрэглэн, үүнээсээ усны эрэлт бууруулах боломжийн шийдлүүдийг тодорхойлов. Бүтээн байгуулалтын төслүүдийн талаар дараахь 2 хүснэгтээс харна уу: **Хүснэгт 1 Нялга-Шивээ Овоо бүсэд төлөвлөгдөж буй төслүүдийн тойм тойм, Хүснэгт 2.**

Тус бүс нутгуудад одоо хэрэгжиж байгаа болон төлөвлөж буй төслүүдийн мэдээллийг холбогдох яамд (Эрчим хүч, Уул уурхай, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамд), усны сав газрын захиргаад, тухайн төслүүдийг хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа (төрийн) компаниудаас авсан болно. Ихэнх төслийн жилийн суурь усны тооцооллыг цуглуулсан өгөгдөл мэдээллээс гаргаж авсан хэдий ч техникийн нөхцөлийн талаарх нарийн мэдээлэл маш хязгаарлагдмал байв. Усны эрэлтийн эдгээр мэдээллээ баталгаажуулахын тулд төрөл бүрийн техникийн нөхцөлд усны эрэлтийн онолын харьцуулалт хийж, суурь нөхцөлийг тодорхойлсон. Шилдэг туршлагын тухай мэдээллийг төслийн багийн туршлага болон холбогдох тайлангуудад дурдсан шилдэг туршлагад үндэслэн гаргав.

Судалгааны хүрээнд авч үзсэн бүх төслийн усны эрэлт бууруулах боломж болон шийдлүүдийн тухай дор товч өгүүлэв. Тодорхой төслүүдийн усны эрэлт бууруулахтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаас үзэж болно.


4.1.1. Дулааны цахилгаан станц (ДЦС), нүүрс шингэрүүлэх үйлдвэр (НШҮ)

Дулааны аргаар цахилгаан үйлдвэрлэхэд их хэмжээний найдвартай усны эх үүсвэр шаардагддаг. Уламжлалт үйлдвэрүүдэд усны цорын ганц хамгийн том хэрэгцээ нь уурын турбины хөргөлтийн систем байдаг ба үүний дараа тогооны цэвэрлэгээ, утаа хүхэргүйжүүлэх ажиллагаа ордог. Нүүрс шингэрүүлэх үйлдвэрийн гол процесст мөн цахилгаан станцынхтай адил хэмжээний ус хэрэглэдэг.

Зураг 15-д ДЦС, НШҮ-ийн усны эрэлт хэрэгцээг багасгах техникийн ерөнхий боломжуудыг харуулав. Нүд бүрт технологийн боломжийг тайлбарлаж, тэдгээрийн баруун талд тодорхой арга хэмжээ хэрэгжүүлэн сайжруулах боломжийг харуулсан болно. ДЦС, НШҮ-үүдийн одоогийн суурь нөхцөлөөр нэмэлт боломжуудыг тодорхойлно. Баруун талд үзүүлсэн хуурай/агаараар хөргөх (CFB бойлэр, бойлороос гарах усыг дахин ашиглах) боломж нь ус ашиглалтын хувьд хамгийн шилдэг жишээ юм.

Зураг 15 ДЦС, НШУ-ийн усны эрэлт багасгах техникийн боломжууд

ШИЛДЭГ ЖИШЭЭ




Тайлбар: %-иар үзүүлсэн бууралт нь хувилбар тус бүрийг хэрэгжүүлснээр бий болох хуримтлагдах хувийг үзүүлнэ.

4.1.2. Шахмал түлшний үйлдвэр

Нүүрсээр шахмал түлш үйлдвэрлэх нь муу илчлэгтэй нүүрсийг илчлэг ихтэй, өндөр агуулгатай, жигд, хатуу, аливаа нөлөөлөлд тэсвэртэй агломерац болгон дулаан ялгаруулалтыг нэмэгдүүлэх үйл явц юм. Үүнийг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэдэг. Энэ үйл явцад усыг зөвхөн хөргөлтийн үйл ажиллагаанд хэрэглэдэг ба баригчийн хэсэгт хэрэглэж бас болдог. Зураг 16-д техникийн сонголт болон ус хэмнэх боломжийн талаар харуулав.

Зураг 16 Шахмал түлшний үйлдвэрийн усны эрэлт багасгах техникийн хувилбарууд

ШИЛДЭГ ЖИШЭЭ




4.1.3. Нүүрс угаах үйлдвэр

Нүүрс угаах гэдэг нь нүүрснээс үнс, чулуу, хүхэр зэрэг хольцыг салгаж, шаталтыг сайжруулах замаар үнэ цэнийг өсгөх үйл явц юм. Гравитацын аргаар бохирдуулагчдыг ялгах механик аргыг өргөн хэрэглэдэг. Мөн нүүрснээс бохирдуулагчдыг ялгахад усыг их өргөн ашигладаг.

Зураг 17-д нүүрс угаах үйлдвэрийн усны хэрэгцээг бууруулахад ашиглаж болох техникийн ерөнхий хувилбаруудыг харуулав.


Зураг 17 Нүүрс угаах үйлдвэрийн усны хэрэгцээг бууруулах техникийн хувилбарууд



4.1.4. Нүүрс олборлолт

Нялга-Шивээ Овоо болон Тавантолгой бүсийн уурхайнуудын усны гол хэрэгцээ нүүрс тээврийн зам болон нүүрсний овоолго орчмын тоосжилт дарахад зориулагддаг. Ус шүрших маягаар тоосжилт дарахад ашигладаг усны нарийн хэмжээ нь уур амьсгалын нөхцөл, нүүрсний овоолго болон нүүрс тээврийн замын орчноос хамаардаг. 18-р зурагт харуулсанчлан химийн гаралтай тоосжилт дарагч бодисуудаар усыг орлуулж болох гол хувилбар болно.

Зураг 18 Уурхайн тоосжилт дарахад усны эрэлтийг бууруулах техникийн хувилбарууд



4.2. Ус хангамжийг нэмэгдүүлэх шийдлүүд

Тус шинжилгээгээр нүүрсний уурхайн шүүрлийн усыг эргүүлэн ашиглах, газрын доорх усыг ашиглах талбайг шинээр тогтоох, төлөвлөж байгаа гадаргын ус дамжуулах байгууламж барих замаар ус хангамжийг нэмэгдүүлэх хувилбар шийдлүүдэд шинжилгээ хийв.

4.2.1. Газрын доорх ус ашиглах нэмэлт талбайг тодорхойлох

Тус судалгааны хүрээнд одоогийн батлагдсан нөөцөөс (3.2-р хэсэг) гадна дээрх хоёр бүсэд газрын доорх усны нэмэлт эх үүсвэр болох боломжит талбайг хамруулан авч үзэв.

3.2-р хэсэгт үзүүлсэн усны нөөцийн үнэлгээтэй адил үнэлгээнд бага гүний уст давхаргуудыг оруулаагүй. Гүний уст давхаргууд нөхөн сэлбэлт үгүй, төлөвлөсөн төслүүдийн усны нийт хэрэгцээг хангахын тулд газрын доорх усны боломжит нөөцийн тооцоо 25 жилээр хийгдсэн байна.

БОНХАЖЯ-наас гаргасан аргачлалд туссан балансын аргыг ашигласан тооцоололд өнгөрсөн хугацаанд (газар дээр) хийгдсэн усны нөөцийн үнэлгээний үр дүнгүүдийг ашиглан уст давхаргын зузаан болон тэжээгдлийг дахин тодруулав. Судалгаанд авч үзсэн ус татах байгууламжийн хэсгийн төлөвлөсөн талбайнуудын усны нөөцийн тооцоонд бодит нөөц, хууль эрх зүйн болон техникийн талаас тавигдсан хязгаарлалтууд, байгаль орчны шаардлагуудыг авч үзэн көвхөн ашиглах боломжит усны нөөцийг тодорхойлон энд оруулсан юм.

Хамгийн зардал багатай шийдэл гэдгийг батлахын тулд ус татах байгууламж барих зардлыг мөн тооцож гаргасан. Тооцсон нийт зардалд 25 жилд усан санг тооцолгүйгээр ус татах байгууламжийн талбайд хийгдэх хөрөнгө, үйл ажиллагааны зардал орсон. Ус татах байгууламжийн талбай тус бүрийн хөрөнгийн зардалд барилга, хуваарилах самбар, шахуурга, уурхайн талбайд хүргэх хоолой, байгууламжийн багана, гол байгууламж болон тоног төхөөрөмж, бага вольтын гэрэл, халаалт, бусад шаардлагатай зүйлийн зардал багтсан. Хүчдэл бууруулах трансформаторт тусгай зардал төлөвлөсөн. Үйл ажиллагааны зардалд ус хангамж, хоолойн системийн засвар үйлчилгээний зардал, эрчим хүчний зардал (ихэвчлэн шахуургыны), эд анги солих зардал орсон.

Хавсралтад судалгааны талбай, мэдээллийн эх үүсвэр, газрын зураг зэрэг дэлгэрэнгүй мэдээлэл оруулсан. Мэдээлэл, аргачлал зэргийг дэлгэрүүлсэн бүх баримт бичиг тус судалгааны нэмэлт тайланд бий.

Ашиглах боломжит нөөцийг баталгаажуулах зорилгоор уламжлалт аргачлалыг сонгосон гэдгийг тэмдэглэх нь зүйтэй бөгөөд усны нөөцийг нарийвчлан тогтоох судалгааг цаашид газар дээр нь хийх шаардлагатай юм.

4.2.1.1. Нялга-Шивээ Овоогийн бүсэд газрын доорх ус олборлох цооногийн байгууламж барих боломжтой

Нялга-Шивээ Овоогийн судалгааны бүсэд цаашид газрын доорх ус татах байгууламж барих боломжтой 10 усны нөөц бүхий талбай тодорхойлогдсон байна. Судалгааны бүсийн гидрогеологийн онцлогоос хамаарч үүсч болохуйц ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгахад боломжтой 50 км радиус дотор хүрээтэй нөөцийг өмнө нь тогтоогдсон байна. Тиймээс талбайг өргөтгөн 100 км радиусыг хамаарах өөр газарт судалгаа хийх шаардлагагүй байна.

Хүснэгт 12 Нялга-Шивээ Овоогийн бүсэд цаашид ус татах байгууламж барих боломжтой талбайн талаар дэлгэрэнгүй мэдээлэл тусгаснаас гадна татсан усаа нийлүүлэх уурхай, уурхай хүртэлх зай, шаардагдах хөрөнгө болон үйл ажиллагааны зардлыг тооцоолон харуулав.

Газрын доорх ус татах байгууламж барьж ашиглах боломжтой талбайнуудаас авч болох нийт усны нөөцийг тооцвол одоогийн хэмжээг 1000 л/сек-ээр нэмэгдүүлэх боломжтой (шүүрлийн ус ороогүй) ба үүнд шаардагдах хөрөнгийн зардал 210.6 сая ам.доллар, үйл ажиллагааны зардал жилд 10.9 сая ам.доллар болох нь.


Хүснэгт 12 Нялга-Шивээ Овоогийн бүсэд цаашид газрын доорх ус олборлох цооногийн байгууламж барьж ашиглах боломжтой газрууд

Ус татах байгууламжийн талбайн (УТБТ)	УТБТ -н ундарга (л/сек)	Хүрэх зай	Уурхай хүртэлх зай (~км)	Хөрөнгийн зардал (ам.доллар сая)	Жилийн үйл ажиллагааны зардал (ам.доллар сая)
УТБТ В	100	Шивээ Овоо	26	29.7	1.4
УТБТ С	150	Шивээ Овоо	31	33.2	1.8
УТБТ Е	100	Төгрөг нуур	0	20.7	1
УТБТ F	150	Төгрөг нуур	0	21.5	1.1
УТБТ G	100	Төгрөг нуур	27	30.7	1.7
УТБТ Н	100	Төгрөг нуур	16	26.3	1.3
УТБТ I	150	Бөөрөлжүүтийн тал	0	21.4	1.1
УТБТ J	150	Бөөрөлжүүтийн тал	16	27.1	1.5
Нийт	1,000	-	-	210.6	10.9

Тайлбар: А болон D дугаартай УТБТ -г цаашидын судалгаанд оруулаагүй. Засгийн газраас баталсан нөөцөд ороогүй хэдий ч эдгээрийг судалгааны бүс нутагт бүртгэсэн. Уламжлалт аргачлал сонгосноор эдгээр УОЦБТ -г энэхүү судалгаанаас хасахад хүргэв.

Зураг 19-т УТБТ -аас татах ус нь одоо байгаа газрын доорх ус (600 д/сек) болон шүүрлийн устай (550 л/сек) харьцуулахад **нийт усны нөөцийг 1000 л/сек-ээр (87%) нэмэгдүүлэх** боломжтойг харуулж байна.

Зураг 19 Тодорхойлсон УТБТ -аас нэмэлтээр олборлох усны ундарга



4.2.1.2. Тавантолгойн бүсэд газрын доорх ус татах байгууламж барьж ашиглах боломжтой талбайнууд

Судалгааны бүсэд багтсан бусад сав газруудад авч үзсэнтэй ижил нөхцөлөөр шинээр 9 цооногийн байгууламжийг тодорхойлсон. Судалгааны бүсийн гадна Дундговийн хүрэн нүүрсний талбайн орчимд нэмэлтээр цооногийн байгууламж байгуулах 2 талбайг тодорхойлсон.

Тодорхойлсон цооногийн байгууламжийн талбай болон татсан усаа нийлүүлэх уурхай, уурхай хүртэлх зай, хөрөнгө болон үйл ажиллагааны зардлыг Хүснэгт 13-т харуулав.


Орон нутгийн болон бүс нутгийн хэмжээнд тогтоогдсон шинээр ГДУ ашиглах боломжтой газруудыг ашиглавал усны хүртээмжийг 600 л/сек болон 300 л/сек-ээр тус тус нэмэгдүүлэх боломжтой. Шинээр ГДУ татах бүх байгууламжийг барих нийт зардалд хөрөнгө оруулалтын зардал 580.44 сая ам.доллар болон жилийн үйл ажиллагааны зардалд 37.1 сая ам.доллараас шаардагдана.

Хүснэгт 13 Тавантолгойн бүсэд тогтоогдсон шинээр ГДУ ашиглах боломжтой талбайнууд

Шинээр ГДУ ашиглах боломжтой талбайнууд	Шинээр ГДУ ашиглах боломжтой талбайн ундарга (л/сек)	Хүрэх зай, ойролцоогоор км	Хөрөнгийн зардал	Үйл ажиллагааны зардал (ам.доллар сая)
Талбай А	50	90	54	4.3
Талбай В	50	80	49.7	3.8
Талбай С	100	84	58.1	3
Талбай D	50	39	34	2.5
Талбай E	50	111	61.5	4.7
Талбай F	100	90	62.1	3.2
Талбай G	50	33	32	2.4
Талбай H	100	102	66.6	3.4
Талбай I	50	78	49.1	3.8
Талбай J1+J2	300	141	113.3	6.9
Нийт	900	-	580.44	37.1

Зураг 20-д ус хангамжийн хувилбаруудын нийт усны хүртээмжийг үзүүлэв. Тухайн бүсийн одоо байгаа газрын доорх ус (370 л/сек) болон шүүрлийн усыг (17 л/сек) –тэй харьцуулахад орон нутагт тогтоосон цооногийн байгуулмжийн талбайн ундарга нь усны хүртээмжийг 600 л/сек-ээр (154%) нэмэгдүүлэх боломжтой. Үүнээс гадна бүсийн хэмжээнд тогтоосон ус татах талбайн ундарга нь нийт усны хүртээмжийг дахин 300 л/сек-ээр (30%) нэмэгдүүлнэ.

Зураг 20 Бүсийн хэмжээнд шинээр ГДУ ашиглах боломжтой талбайгаас нэмэлтээр авах ундарга



4.2.2. Гадаргын ус шилжүүлэн ашиглах

Орхон-Говь ус шилжүүлэн ашиглах төслийг Өмнөд Говийн бүсдэх Тавантолгойн нутагт ус хангамжийг бодитоор нэмэгдүүлэх боломжтой төсөл гэж авч үзэв. Орхон голын голидролыг өөрчлөн усыг дамжуулах хоолойгоор шилжүүлэн түүний дагуу орших хөдөө аж ахуй болон хот суурин газрын хэрэгцээнд өдөрт ойролцоогоор 216,000 м³ ус нийлүүлэн цаашид Өмнөговийн уул уурхай, үйлдвэрлэлийн хэрэгцээнд өдөрт дунджаар 100,000 м³ ус нийлүүлэх боломжтой. Тавантолгойн бүсэд өдөрт дунджаар 47,000 м³ усыг хүргэнэ гэж тооцоолсон байна.

Төслийн хүрээнд Улаанбаатар хотоос баруун урагш 250 км зайд Орхон гол дээгүүр боомт барьж усан сан үүсгэж, ус авах байгууламжийг барина. Ус дамжуулах шугам хоолой, шахуургын станц болон холбогдох дэд бүтцийн байгууламжийг мөн барьж, Тавантолгой болон Оюутолгойд 740 км урттай шугам хоолойгоор ус дамжуулах ба Мандалговь, Даланзадгадад салбар шугам хоолойтой байх ажээ.

Энэхүү газрын доорх усыг шилжүүлэн ашиглах томоохон төсөл, түүний эцсийн үр ашгийн талаар оролцогч талууд янз бүрийн байр суурьтай байдаг. Ус дамжуулах схемтэй холбоотой мэдээллүүд тодорхойгүй байгаа тул төслийг эн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтад багтаахын тулд одоо байгаа мэдээллийг экспертийн нарийвчилсан дүгнэлт гаргуулахаар нэмэлт судалгаа хийсэн.²⁰ Нэмэлт зардлын тооцоолол, усны хүртээмж, зардал болон төслийн эдийн засаг, байгаль орчин, нийгмийн нөлөөлөлд анхаарал хандуулсан болно.²¹

Орхон-Говь төслийн мэдээлэлд нарийвчилсан шинжилгээ хийснээр түүнд 1,295 сая ам.долларын зардал шаардлагатайг шинэчилсэн тооцоолсон бөгөөд энэ нь нилээд өндөр нарийвчлалтай, баталгаатай байна. Төслийн хүрээнд 2.5 м³/сек усыг шугам хоолойгоор дамжуулах боломжтой боловч экологийн урсацыг тэтгэх зорилгоор голын уснаас авч болох хэмжээнээс хамаарна. Энэхүү ус дамжуулах төслийг гидро-эдийн засгийн шинжилгээнд хамруулах явцад тухайн төслийн эдийн засаг, байгаль орчин, нийгмийн нөлөөллийг мөн харгалзаж үзсэн болно.

Төслийн талаарх мэдээллээс уг төсөл боловсруулалтын “урьдчилсан” шатанд байгааг тэмдэглэж байна. Тиймээс гидрологийн мэдээлэл болон түүний зураг төсөл, хувилбаруудын талаарх мэдээлэл хязгаарлагдмал байгааг дурдах нь зүйтэй. Төслийн зардлын тооцоонд эдгээр тодорхойгүй зүйлсийг урьдчилсан болон техник эдийн засгийн судалгааны шатанд тодруулах шаардлагатай. Түүнчлэн Тавантолгой бүсийн усны эрэлт болон энэхүү ус дамжуулах төслийн хэрэгцээ шаардлага нь төлөвлөсөн төслүүд хэрэгжих эсэхээс хамаарна гэдгийг мөн дурдах байна.

Нэмэлт мэдээллийг хавсралт А.5.4, А.5.5 болон энэхүү тайлангийн хавсралтаас үзнэ үү

²⁰ 2030 Усны нөөцийн бүлэг, Амек Фостэр Вилэр, Газрын доорх усны менежментийн шийдэл (2016) “Орхон-Говь ус дамжуулах төслийн экспертийн үнэлгээ”.

²¹ Үнэлгээнд ашигласан мэдээллийг “Прэстиж” –ийн тайлангаас авсан (2014). Эдийн засаг, санхүү, байгаль орчин, нийгмийн анхан шатны судалгааны тайлан – Орхон голын урсгал өөрчлөх, усан сангийн цогцолбор барих ТЭЗҮ-ийн Ажлын удирдамж, 2 тодруулах хүсэлтийн хариулт бүхий дагалдах мэдээлэл
Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах эрэмбэлсэн шийдлүүд
PwC

5. Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах шийдлүүдийг эрэмбэлэх, сонгох

5.1. Үнэлгээний хүрээ

Өмнөх бүлгүүдэд үзүүлснээр усны эрэлтийг бууруулж, ус хангамжийг нэмэгдүүлснээр усны хүртээмж дахь нийт өсөлт 2040 он гэхэд өндөр эрэлттэй хувилбараар зөрүүг арилгахад шаардагдах уснаас давсан байх тооцоо гарч байна. Өөрөөр хэлбэл, сонгосон арга хэмжээг авч хэрэгжүүлснээр Нялга-Шивээ Овоогийн бүсийн одоогийн усны хүртээмжийг (зөрүү: 34.25 сая м³/жил) 55.64 сая м³/жилээр, Тавантолгой бүсэд (зөрүү: 18.85 сая м³/жил) 57.12 сая м³/жилээр нэмэгдэх төлөв гарч байна.²²

Тиймээс 2040 онд Нялга-Шивээ Овоо, Тавантолгой бүсүүдийн ус хангамж, усны эрэлтийн тооцоолж буй зөрүүг арилгах зардал багатай, үр ашигтай хувилбарыг сонгохын тулд 4-р хэсэгт үзүүлсэн төслийн янз бүрийн хувилбарт санхүү, эдийн засаг, байгаль орчин, нийгмийн шалгуурын дагуу үнэлгээ хийлээ. Зураг 21-д Үнэлгээний аргачлалын тоймыг харуулав.

Зураг 21 Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах шийдлүүдийг эрэмбэлэх үнэлгээний аргачлал



²² Хавсралтаас өмөн нэмэгдэх усны нөөц болон бүх шийдлийн суурь үзүүлэлтийн тухай дэлгэрэнгүйг харна уу.
Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах эрэмбэлсэн шийдлүүд
PwC

Төслийн янз бүрийн хувилбаруудын үнэлгээнд хэрэглэсэн шалгууруудын тухай болон үнэлгээ хийсэн аргын талаар Хүснэгт 14-т харуулав. Үнэлгээний аргачлалд ерөнхийдөө дараахь шалгууруудыг ашиглав:

- **Тоон шалгуур** бодит тоон мэдээлэл буюу жишиг тоонд үндэслэж үнэ цэнийг тооцох боломжтой. Энэ шалгуурыг санхүүгийн болон зардлын нэгдсэн муруй боловсруулахад ашиглав²³.
- **Хагас чанарын шалгуур** тоон мэдээлэл байхгүй байсан тул тооцоог холбогдох баримт материалд үндэслэж хийх боломжгүй байв. Гэхдээ нөлөөллийн тухай баримт материал болон хэлэлцүүлгийн үр дүнг ашиглан өртгийг хуваарилсан.
- **Чанарын шалгуур** тоон болон тоон утгыг хуваарилах дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй байв. Үнэлгээгээр бусад ус хэрэглэгчдэд үзүүлэх нөлөөллийн тухай хязгаарлагдмал баримтад гол анхаарал хандуулав.

Хүснэгт 14 Үнэлгээний шалгуурууд

	Шалгуур	Тоон/ш	Хагас чанарын/ш	Чанарын/ш
Санхүүгийн шалгуур	Төслийн хувилбаруудын санхүүгийн өртөг зардал (хөрөнгийн зарцуулалт ба үйл ажиллагааны өртөг)	★		
	Техникийн үр ашигтай байдал (усны хэмнэлт буюу ус хангамжийг сайжруулах)	★		
	Өртөг, үр ашгийн харьцаа	★		
	Ус олборлолтын хураамж, төлбөрийг нэмэгдүүлснээр үзүүлэх боломжит нөлөө			★
Эдийн засгийн шалгуур	Амралт зугаалга, (байгалийн) аялал жуулчлалд үзүүлэх нөлөө			★
	Хүний эрүүл мэндийн эрсдлийг бууруулах	★		
	Ажил эрхлэлт		★ ²⁴	
	Чиглэсэн хөрөнгө оруулалт ба түүний өсөлт			★
Байгаль орчны шалгуур	Усны байгаа нөөцөд үзүүлэх нөлөөлөл		★	
	Ус, газар химийн бодисоор бохирдох		★	
	Дулаан эрчим хүчтэй холбоотой үүсэх ус, газрын бохирдол		★	
	Агаарын чанар ба уур амьсгалын өөрчлөлт	★		
	Амьдрах орчин ба биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөлөл	★		
Нийгмийн шалгуур	Усны хүртээмж ба боломжийн үнэ өртөг бүхий усны үйлчилгээ			★
	Эрчим хүчний хүртээмж ба боломжийн үнэ өртөг бүхий эрчим хүчний үйлчилгээ			★
	Ус, цахилгаан эрчим хүчний хүртээмжийг сайжруулснаар хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл			★

²³ Санхүүгийн зардлаас гадна зардлын нэгдсэн муруйд төслийн янз бүрийн хувилбаруудын эдийн засгийн болон байгаль орчны нөлөөллийг тооцсон

²⁴ Зөвхөн усны үр ашгийн арга хэмжээнд зориулав
Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах эрэмбэлсэн шийдлүүд
PwC

Дүн шинжилгээг ялгавартай хийхийн тулд хоёр багц зардлын муруйг танилцуулж байна:

1. Санхүүгийн зардлын муруй: Хөрөнгө оруулалтын боломжуудын эрэмбэлэлтийг зөвхөн санхүүгийн шалгууруудад үндэслэдэг
2. Зардлын нэгдсэн муруй: Хөрөнгө оруулалтын боломжуудын эрэмбэлэлтийг санхүүгийн шалгууруудаас гадна эдийн засгийн болон байгаль орчны шалгууруудад үндэслэдэг. Тоон баримт мэдээлэл дутмаг байсан тул нийгмийн шалгуурыг тоон болон хагас чанарын үнэлгээнд оруулаагүй.

Нэгдсэн зардлын муруйн хувьд дээр дурдсан шалгууруудын жинлэсэн дүнг авч төслийн янз бүрийн хувилбаруудыг эрэмбэлсэн. Жинлэсэн дүнг оролцогч талуудын хэлэлцүүлэгт үндэслэн гаргасан. Янз бүрийн шалгууруудын харьцангуй ач холбогдлыг тусгахын тулд дараахь жинг ашигласан (бүгдийг 1 хүртэл хураангуйлсан):

- Санхүүгийн болон техникийн үр ашиг – 0.2
- Эдийн засгийн үр ашиг – 0.3
- Байгаль орчны үр ашиг – 0.5

5.2. Зардлын муруйн танилцуулга


- Зардлын муруй бол ус хангамж нэмэгдүүлэх, усны эрэлтийг багасгах арга хэмжээг ил тод танилцуулах, харьцуулах боломж олгодог, шийдвэр гаргахад чухал арга хэрэгсэл болдог. Ялангуяа ус хангамжийг нэмэгдүүлэх, ус хэмнэх боломжийг төрөл бүрийн техникийн арга хэмжээ болон холбогдох өртөг зардлаар биелүүлж болохыг харуулна. Түүнчлэн тооцсон нэмэлт усны хүртээмжийг төлөвлөсөн ус хангамж, усны эрэлтийн зөрүүтэй харьцуулж, хамгийн зардал багатай арга хэмжээний цар хүрээ, дарааллыг тодорхойлох боломж олгодог.
- Зардлын муруйд усны эрэлтийг багасгах, ус хангамжийг нэмэгдүүлэх төрөл бүрийн арга хэмжээг хэрэгжүүлэхийн үр ашиг буюу бий болгож буй усны хэмжээг тусгадаг (хэвтээ тэнхлэг, сая м³/жил). Босоо тэнхлэгт жилд хэмнэсэн болон нэмсэн м³ тутмын зардлыг харуулна (босоо тэнхлэг, ам.доллар/ м³).
- Зардлын муруйд үйлдвэр болон талбайн түвшинд хэрэгжүүлэхээр санал болгож буй арга хэмжээний техникийн боломжийг тусгадаггүй гэдгийг энд дурдах нь зүйтэй. Ялангуяа (а) хамгийн зардал багатай технологийн хувилбарыг сонгож хэрэгжүүлэх дээд зэрэглэлийн уян хатан чанартай шинэ, боломжийн төслүүд болон (б) технологийн шинэчлэл буюу процессын өөрчлөлт хийх боломжоор бага одоо ажиллаж буй төслүүдийг ялгаж үзээгүй.
- Цаашилбал зардлын муруйн хүрээнд газрын доорх ус олборлох цооногийн байгууламжийг шинээр байгуулах, ДЦС болон НШҮ-үүдэд хуурай аргаар угаах технологи буюу хуурай/агаараар хөргөх систем суурилуулах зэрэг техникийн арга хэмжээнд дүн шинжилгээ хийсэн. Өөрөөр хэлбэл зардлын муруйд тухайн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх болон хэрэгжилтийг урамшуулах бодлогыг авч үзээгүй.
- Зардлын муруй дээр харуулсан зардал болон усны хүртээмжийг шууд нэмэж болохгүй бөгөөд муруй дээр усны нэгж зардлыг их хэмжээгээр хэмнэх болон нэмэгдүүлэх боломжтой технологийн хувилбаруудыг талбай болон үйлдвэр тус бүрт байгаа бусад хувилбаруудтай харьцуулсны үндсэн дээр тодорхойлдог. Ус ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх технологийн хувилбарууд нь харилцан уялдаатай, эсвэл зөрчилдөж (тухайлбал тоосжилт дарахад органик баригч, эсвэл кальцийн хлорид ашиглах г.м) байдаг тул нэмэлт зүйл биш юм.
- Шинжилгээгээр хоёр өөр зардлыг ялгасан: **Нийт зардал (НЗ)**, **өсөн нэмэгдэх зардал (ӨНЗ)**. Тус хоёр зардлыг **жилийн зардлын тэнцэлээр (ЖЗТ)** харуулсан. **ЖЗТ**-д хөрөнгийн ашиглалтын хутагаан дахь нэг жилийн хөрөнгийн, үйл ажиллагааны болон засвар үйлчилгээний зардлыг тусгадаг. НЗ нь технологиос (суурь) үл хамаарах хөрөнгө оруулалтын нийт зардал байдаг. Харин ӨНЗ нь одоо байгаа болон төлөвлөсөн хөрөнгө оруулалтын зардал юм. ДЦС-ыг жишээгээр авбал судалгаа шинжилгээгээр тодорхойлсон арга хэмжээ нь тухайн арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийхээс илүү байгаа технологийг шинэчлэхэд чиглэгдэнэ гэсэн үг. Зарим төслүүд төлөвлөлтийн

шатандаа байгаа. ДЦС, НШҮ, ШТҮ болон олборлолтын талбайн (тоосжилт дарах) ус ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ зэрэг технологийн сонголттой төслүүдэд суурь үзүүлэлтийн болон анхны хувилбартай харьцуулсан хоёр багц ӨНЗ гарна. Анхны хувилбартай харьцуулсан ӨНЗ-ыг (тухайлбал хуурай/агаарын хөргөлттэй хөргөх системийн суурилуулалтыг ДЦС-ын холимог системтэй харьцуулах) зардлын муруй байгуулахад ашигладаг. Зарим тохиолдолд нэг төсөлд олон арга хэмжээ санал болгодог. Тухайлбал дулааны цахилгаан станцад хөргөлтийн арга хэмжээ төлөвлөх. Эдгээр арга хэмжээ хоорондоо зөрчилдөх тохиолдолд хамгийн дэвшилтэт арга хэмжээ бол НЗ болон ӨНЗ-ыг тооцох байдаг. Жишээлбэл, хэрэв ус хангамж, усны эрэлтийн зөрүү арилгах арга хэмжээнд дулааны цахилгаан станцын шинэчлэл багтсан мөртлөө хуурай хөргөлттэй ДЦС болгон солих шаардлага гарвал зөвхөн хуурай хөргөлттэй ДЦС барих асуудлыг авч үзэн давхар зардал гаргахаас зайлсхийнэ. Төлөвлөсөн арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх технологи нь ус хэмнэхээс гадна анх төлөвлөснөөс хямд байх тохиолдолд ӨНЗ сөрөг гарах магадлалтай. Өөрөөр хэлбэл НЗ эерэг байсан ч хэмнэлт гарна.

Зардлын муруйн үзүүлэлтүүд:

- Төслийн янз бүрийн хувилбаруудын **санхүүгийн зардалд** (ам.доллар/жил) **хөрөнгө оруулалтын**, тухайлбал барилга угсралт болон тоног төхөөрөмжийн зардал гэх мэт төслийн нэг удаагийн, тогтмол зардал, ус шахалт, агаараар хөргөлт, тоног төхөөрөмжийн засварын цахилгааны зардал зэрэг **жилийн үйл ажиллагааны** болон **засвар үйлчилгээний зардал** багтсан. Газрын доорх ус олборлолтыг хөргөх технологийн шинэчлэлтэй харьцуулахдаа хөрөнгийн, жилийн үйл ажиллагааны, засвар үйлчилгээний гэсэн зардлуудыг жилийн зардлын тэнцэлээр (ам.доллараар) илэрхийлж, янз бүрийн хугацаатай төслүүдэд харьцуулалт хийлээ. Зардлын нэгдсэн муруй байгуулахын тулд **эдийн засгийн** (хүний эрүүл мэндийн эрсдэл бууруулах) болон **байгаль орчны** (агаарын чанар, уур амьсгалын өөрчлөлт, амьдрах орчин болон биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөлөл) зардлуудыг авч үзэн, санхүүгийн зардалтай жинлэсэн (5.1-ийг үзнэ үү). Технологийн хувилбар тус бүрийн тухайд анхны хувилбартай харьцуулсан ӨНЗ-ыг зардлын муруй байгуулахад ашиглав.
- Нялга-Шивээ Овоо, Тавантолгой бүсэд төслийн янз бүрийн хувилбаруудын **техникийн үр ашиг** гэдэгт (сая м³/жил) ус хангамж нэмэгдүүлэх, усны эрэлт бууруулах төрөл бүрийн арга хэмжээ хэрэгжүүлэх замаар хэр их ус хэмнэх буюу хангахыг тусгав. Төслийн янз бүрийн хувилбаруудад зориулж өсөн нэмэгдэх зардлыг усны нэмэгдсэн хүртээмжтэй харьцуулж илэрхийлэх хоёр арга байгаа гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Онолын хувьд арга хэмжээ бүрийг суурь үзүүлэлт буюу хоёр дахь хамгийн сайн сонголттой харьцуулж болно. Зардлын муруйг өсөн нэмэгдэх усны нөөцийг анхны буюу хоёр дахь хамгийн сайн технологийн хувилбартай харьцуулж байгуулсан.
- **Зардал, үр ашгийн харьцаа** (ам.доллар/ сая м³/жил): Нялга-Шивээ Овоо, Тавантолгой бүсийн төслийн янз бүрийн хувилбаруудын зардал, үр ашгийн харьцааг тэдгээрийн тооцсон ӨНЗ-ыг ЖЗТ-аар илэрхийлсэн анхны хувилбарт хувааж, мөн жилд хэмнэсэн буюу нийлүүлсэн усны хэмжээг хоёр дахь хамгийн сайн сонголттой харьцуулан хэмжиж тооцов. Зардал, үр ашгийн харьцаанд үндэслэж зардлын муруй дээр үзүүлсэн төсөл бүрийн хувилбарыг анхныхтэй харьцуулж үнэлсэн. Тухайлбал ДЦС-ын ус эргүүлэн ашиглах нойтон ба ус эргүүлэн ашиглах хөргөлтийн технологийг холимог (хуурай/нойтон) системээр солиход усны эрэлтийг 1.1 м³/мвц-аас 0.78 м³/мвц хүртэл бууруулна. Үүнтэй адил хуурай/агаарын хөргөлттэй хөргөх систем суурилуулахад усны хэрэгцээ 0 м³/мвц болдог. Өсөн нэмэгдэх усны нөөцийг суурь үзүүлэлттэй харьцуулан тооцоход холимог хөргөлтийн систем суурилуулахад усны эрэлт 0.32 м³/мвц-аар буурах ба хуурай/агаарын хөргөлттэй хөргөх систем суурилуулахад 1.1 м³/мвц-аар буурна. Харин өсөн нэмэгдэх усны нөөцийг хоёр дахь хамгийн сайн хувилбартай харьцуулан тооцоход холимог хөргөлтийн систем суурилуулахад тооцоолж буй усны хэмнэлт 0.32 м³/мвц байх ба хуурай/агаарын хөргөлттэй хөргөх систем суурилуулахад 0.78 м³/мвц байна. Учир нь технологийн хувилбарыг суурь хувилбар болох усыг эргүүлэн ашиглах нойтон, хаалттай циклтай бус хөргөлтийн холимог систем суурилуулахтай харьцуулж үзсэн.

Зураг 22 Зардлын муруй тайлбар



Зураг 22-т зардлын муруйг хэрхэн (тайлах) унших жишээг харуулав. Дээр дурдсанчлан хэвтээ тэнхлэг дээр өсөн нэмэгдэх усны нөөцийг харуулав (энэхүү үнэлгээнд төслийн хувилбар буюу багана бүрд нэмэлт усны нөөцийг технологийн анхны хувилбартай харьцуулсныг үзүүлэв). Багануудын өргөн нь усны нөөцийн харьцангуй нэмэгдлийг харуулах буюу өөрөөр хэлбэл багана өргөсөх тусам усны нөөц төдий чинээ нэмэгдэнэ гэсэн үг.

Босоо тэнхлэг дээр ДЦС-ын хуурай хөргөлт, уурхайн сайт дээр кальцийн хлорид ашиглан тоосжилт дарах зэрэг ус хангамж нэмэгдүүлэх, усны эрэлт багасгах замаар м3 ус хангах зардлыг (ам.доллар) харуулав. Шоо метр усны зардал нь сөрөг байж болох ба арга хэмжээ авсны үр дүнд усны нөөцийг нэмэгдүүлж, хөрөнгө мөнгө хэмнэх нөхцөлийг тусгасан. Багануудын өргөний адилаар өндөр нь шоо метр тутмын зардлыг харуулна. Багана намсах тусам нэмэлт куб метр усаар хангах зардал хямд болно. Үүнтэй адилаар багана өндөр байх тусам хэмнэлт их байна.

Зардлын муруй дээр зүүн талд байрлуулсан төслийн хувилбаруудыг муруйн баруун талын эгц хэсэгтэй харьцуулбал харьцангуй зардал багатай. Дээрх жишээнд ус хангамж, усны эрэлтийн зөрүүг саарал хэсэгт харуулсан арга хэмжээг хэрэгжүүлснээр арилгах боломжтой.

5.3. Зардлын муруй

Нялга-Шивээ Овоо, Тавантолгой бүсийн санхүүгийн болон зардлын нэгдсэн муруйг байгуулсан. Санхүүгийн зардлын муруйг А.1 хавсралт, зардлын нэгдсэн муруйн талаар дараагийн бүлэгт дэлгэрэнгүй өгүүлэв. Хавсралтад санхүүгийн болон зардлын нэгдсэн муруйн харьцуулсан анализын талаар оруулав.

Зардлын муруй байгуулахын тулд Нялга-Шивээ Овоо, Тавантолгой бүсийн төслийн бүх боломжит хувилбаруудыг зардал-үр ашгийн харьцаагаар хамгийн багаас хамгийн өндөр оноо хүртэл ангиллаа.

Зардлын муруйд багтаагүй хэд хэдэн төрлийн төслийн хувилбар байсан гэдгийг энд дурдах нь зүйтэй. Тэдгээрээс дор дурдвал:

- Төслүүдийн суурь технологийн хувилбарууд нь төслийн хувилбаруудыг үнэлсэн жишиг хувилбарыг бүрдүүлсэн (зардал, ус нэмэгдүүлэх боломжийн тухайд)
- Суурь технологийн хувилбар нь хамгийн шилдэг технологийн хувилбарыг бий болгодог. Төслийн хувилбар (ДЦС-ын хуурай/агаараар хөргөх хөргөлтийн систем)
- Усны хэмнэлт гаргах төслийн хувилбарууд, өөрөөр хэлбэл илүү эрчимжүүлсэн хувилбарыг анхны хувилбартай харьцуулах
- Нүүрс олборлоход уурхайн усыг шавхах шаардлагатай тул шүүрлийн усыг ууссан зардал гэж тооцсон. Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг үнэлэхэд шүүрлийн усыг усны бэлэн нөөц гэж тооцсон ба зардлын муруйд оруулах нь давхардал үүсгэнэ.


Зардлын муруй дээр арга хэмжээнүүдийг шинжилгээнд зориулж дугаарласан ба өмнө хүснэгтүүдэд энэ тухай дурдсан.

5.3.1. Зардлын нэгдсэн муруй – Нялга-Шивээ Овоогийн бүс

Нялга-Шивээ Овоо бүсийн бага болон дунд эрэлттэй хувилбарын ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах өсөн нэмэгдэх зардал 2040 онд жилд ойролцоогоор 23 сая ам.доллар, өндөр эрэлттэй хувилбарын зөрүү арилгах зардал 33 сая ам.доллар болж байна. Бага болон дунд эрэлттэй хувилбараар ус хангамж, усны эрэлтийн 21.2 сая м³/жил-ийн бага зөрүү, 23 сая м³/жил-ийн дунд хэмжээний зөрүү арилгахад 25 сая м³ усны нөөц бий болгоно. Өндөр эрэлттэй хувилбараар 2040 онд 34.25 сая м³/жил-ийн зөрүү арилгахад 35 сая м³ ус жилд бий болгоно.

Зураг 23-т Нялга-Шивээ Овоо бүсийн санхүү, эдийн засаг, байгаль орчны шалгууруудыг авч үзсэн зардлын нэгдсэн муруйг харуулав.

Зураг 23 Нялга-Шивээ Овоо бүс –Зардлын нэгдсэн муруй



Хамгийн бага зардал бүхий технологийн төрөл бүрийн хувилбаруудыг хэрэгжүүлэхийг тусгасан нэгдсэн зардлын муруйг байгуулсны дараа өндөр эрэлттэй хувилбарын зөрүү арилгах арга хэмжээнүүдийг тодорхойлсон. Дээрх зардлын муруйд үзүүлснээр зардал багатай технологийн олон хувилбарууд нэг үйлдвэр болон сайтад хамаарч байна. Тухайлбал 270 мв-ын ДЦС-д (дугаар #1) зориулсан технологийн 4 хувилбарыг (1h, 1g, 1i, 1j) оруулан зардал-үр ашгийн хувьд өндөр гэж ангилав. Практикт эдгээр технологийн хувилбаруудыг дараалуулан хэрэгжүүлэхгүй (буулгахгүй/сайжруулахгүй). Харин тухайн ДЦС-ыг суурь технологиос бэлэн байгаа хувилбаруудын жагсаалт дахь хамгийн дэвшилтэт технологийг сонгож хөрөнгө оруулалт хийнэ. Ийм онцгой тохиолдолд CFB бойлэр, хөргөлтийн ус боловсруулалт, хөргөх болон бойлэроос гарах усыг эргүүлэн ашиглах (суурь) системтэй ус эргүүлэн ашиглах нойтон, хаалттай циклээс CFB бойлэр, бойлэроос гарах усыг эргүүлэн ашиглах хуурай/агаараар хөргөх хөргөлтийн систем (хувилбар 1j) рүү шилжинэ гэсэн үг. Тухайн шилжилтийн зардал болон усны нөөцийн өөрчлөлттэй холбоотой *нийт* нөлөөллийг тогтоохын тулд 1j хувилбарын өсөн нэмэгдэх зардал болон нэмэлт усны хүртээмжийг суурь хувилбартай (анхны хувилбар 1i-тай) харьцуулж үзэх хэрэгтэй. Үүний тулд эрэмбэлсэн шийдлүүдийг жагсаасан Хүснэгт 15-д технологийн өөрчлөлтийг тайлбарлан, суурь хувилбартай (эхлэх цэг) харьцуулж авч үзсэн технологийн хувилбар тус бүрийн өсөн нэмэгдэх зардал, нэмэгдэх усны нөөцийг үзүүлэв. Ингэснээр ус хангамж, усны нөөцийн зөрүү арилгахын тулд зардлын муруй дээр санал болгосноос цөөн арга хэмжээ хэрэгжүүлэх хэрэгтэй болно. **Error! Reference source not found.**Хавсралтад зардлын муруйн суурь болсон бүх арга хэмжээний жагсаалтыг оруулав. ²⁵

Хүснэгт 15 Нялга-Шивээ Овоо – Эрэмбэлсэн шийдлүүдийн жагсаалт (зардлын нэгдсэн муруй)

Анги лал	Дуг аар	Нэр – төслийн нэр	Суурь технологи	Технологийн бүрэн тайлбар	Нийт зардал (ам.доллар, ЭЖЗ)	Өсөн нэмэгдэх зардал (суурь үзүүлэлттэй харьцуулсан ам.доллар, ЭЖЗ)	Нэмэгдэх усны нөөц (сая м3/жил, суурь үзүүлэлттэй харьцуулсан н)	Зардал- үр ашгийн харьцаа (ам.долл ар/м3)
1	7с	Шивээ Овоо уурхай	Тоосжилт бууруулахад ус ашиглах	Тоосжилт бууруулахад кальци хлорид ашиглах	1,551,076	1,542,661	0.95	-5.58
2	8с	Төгрөг нуур уурхай	Тоосжилт бууруулахад ус ашиглах	Тоосжилт бууруулахад кальци хлорид ашиглах	517,026	514,221	0.32	-5.58
3	9с	Бөөрөлжүүт ийн тал уурхай	Тоосжилт бууруулахад ус ашиглах	Тоосжилт бууруулахад кальци хлорид ашиглах	517,026	514,221	0.32	-5.58
4	39с	Бусад уурхай NSO	Тоосжилт бууруулахад ус ашиглах	Тоосжилт бууруулахад кальци хлорид ашиглах	10,340,502	10,284,405	6.32	-5.58
5,6,8, 11	1 g, h, i, j	Дулааны цахилгаан станц (270 МВ) – Шивээ Овоо	Ус эргүүлэн ашиглах нойтон, хаалттай цикл, CFB бойлер, Хөргөлтийн ус боловсруулах, хөргөлтөөс гарах усыг дахин ашиглах, бойлэроос гарах усыг дахин	Хуурай/агаар хөргөх, CFB бойлер, бойлэроос гарах усыг дахин ашиглах	5,439,601	-3,918,516	0.71	-5.02 to - 0.77

²⁵ А 5.1.4 хавсралтаас кальц хлорид ашиглан тоосжилт дарах талаар дэлгэрэнгүй материалыг үзнэ үү .
Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах эрэмбэлсэн шийдлүүд
PwC

Анги лал	Дуг аар	Нэр – төслийн нэр	Суурь технологи	Технологийн бүрэн тайлбар	Нийт зардал (ам.доллар, ЭЖЗ)	Өсөн нэмэгдэх зардал (суурь үзүүлэлттэй харьцуулсан ам.доллар, ЭЖЗ)	Нэмэгдэх усны нөөц (сая м3/жил, суурь үзүүлэлттэй харьцуулсан н)	Зардал- үр ашгийн харьцаа (ам.долл ар/м3)
ашиглах								
7,9,10	2j, k, l	Дулааны цахилгаан станц (750 МВ) – Шивээ Овоо	Ус эргүүлэн ашиглах нойтон, хаалттай цикл, Яндангийн утааг нойтон аргаар хүхэргүйжүүл эх, Хөргөлтийн ус боловсруулах, Хөргөлтөөс гарах усыг дахин ашиглах	Холимог (хуурай/нойтон) хөргөх, хөргөлтөөс гарах усыг дахин ашиглах, бойлороос гарах усыг дахин ашиглах, CFB бойлер, яндангийн утааг хуурай аргаар хүхэргүйжүүлэх	18,405,625	-4,292,083	2.95	-2.38 to - 0.94
12,13, 14	10b , c, d	Шахмал түлшний үйлдвэр – Төгрөг нуур	Нойтон ба усыг эргүүлэн цикл үүсгэх	Хөргөлтийн ус боловсруулах, яндангийн утааг хуурай аргаар хүхэргүйжүүлэх, хэмнэлттэй шүршигч	513,952	513,952	0.03	-0.05
15-17, 24-28	5h, i, j, k, l, n, o, p	Нүүрс шингэрүүлэх үйлдвэр - Төгрөг нуур	Нойтон ба усыг эргүүлэн цикл үүсгэх, яндангийн утааг нойтон аргаар хүхэргүйжүүл эх	Хуурай/агаар хөргөх, яндангийн утааг хуурай аргаар хүхэргүйжүүлэх, бойлороос гарах усыг дахин ашиглах, CFB бойлер	16,453,389	12,308,578	9.52	-0.03 to - 0.01
18- 20, 29-33	6h, i, j, k, l, n, o, p	Нүүрс шингэрүүлэх үйлдвэр - Бөөрөлжүүт ийн тал	Нойтон ба усыг эргүүлэн цикл үүсгэх, яндангийн утааг нойтон аргаар хүхэргүйжүүл эх	Хуурай/агаар хөргөх, яндангийн утааг хуурай аргаар хүхэргүйжүүлэх, бойлороос гарах усыг дахин ашиглах, CFB бойлер	7,478,813	5,594,808	4.28	-0.03 to - 0.01
Нийт бага (21.2 сая м3) болон дунд (23 сая м3) эрэлтийн зөрүү					61,217,010	23,062,247	25	

Анги лал	Дуг аар	Нэр – төслийн нэр	Суурь технологи	Технологийн бүрэн тайлбар	Нийт зардал (ам.доллар, ЭЖЗ)	Өсөн нэмэгдэх зардал (суурь үзүүлэлттэй харьцуулсан ам.доллар, ЭЖЗ)	Нэмэгдэх усны нөөц (сая м3/жил, суурь үзүүлэлттэй харьцуулсан н)	Зардал- үр ашгийн харьцаа (ам.долл ар/м3)
21-23, 34-38	24h , i, j, k, l, n, o, p	Нүүрс шингэрүүлэх үйлдвэр – Шивээ Овоо	Нойтон ба усыг эргүүлэн цикл үүсгэх, яндангийн утаа нойтон аргаар хүхэргүйжүүл эх	Хуурай/агаар хөргөх, яндангийн утааг хуурай аргаар хүхэргүйжүүлэх, бойлороос гарах усыг дахин ашиглах, CFB бойлер	8,974,576	6,713,770	4.55	-0.03 to - 0.01
39	36b 1	Газрын доорх ус татах цооног I - Бөөрөлжүүти йн тал	Байхгүй	Сонгосон талбайд газрын доорх ус шинээр татах цооногийн бүтээн байгуулалт (усан сангүй) Бөөрөлжүүтийн тал руу хүргэх	3,457,597	3,457,597	4.73	0.20
Нийт (өндөр эрэлттэй хувилбарын зөрүү – 34.25 сая м3)					73,649,183	33,233,614	35	

Эдгээр технологийн хувилбаруудыг хэрэгжүүлэх ажлын өсөн нэмэгдэх зардлыг авч үзэхээс гадна (тэдгээрийн суурь технологитой харьцуулан) тус арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын нийт зардлыг авч үзэж болно (нийт зардал нь өсөн нэмэгдэх зардлаас их байна). Ялангуяа тус арга хэмжээг Нялга-Шивээ Овоо бүсэд хэрэгжүүлэх ажлын нийт жилийн зардлын тэнцэл бага болон дунд эрэлттэй хувилбараар ойролцоогоор 61 сая ам.доллар/жил байх ба өндөр эрэлттэй хувилбараар 74 ам.доллар/жил байна (төслийн суурь хувилбаруудын зардал хамаарахгүй).

Нялга-Шивээ Овоо бүсийн нэгдсэн судалгаа шинжилгээний үр дүнг авч үзэхэд дараахь онцлох зүйлс гарч байна. Үүнд:

- **Кальц хлорид ашиглан тоосжилт бууруулах** Нялга-Шивээ Овоо бүсэд кальц хлорид ашиглан тоосжилт бууруулах нь хамгийн үр ашигтай арга хэмжээ ба тус бүсэд жилд нийт 7.9 сая м3 ус хэмнэхийн сацуу м3 ус тутамд 5.58 ам.долларын зардал хэмнэх боломжтой (тоосжилт бууруулах суурь технологитой харьцуулав).
- **ДЦС-уудад холимог ба хуурай хөргөлтийн систем суулгах** нь жилд нийт 3.7 сая м3 ус хэмнэн, м3 ус тутамд 5.02 - 0.94 ам.долларын зардал хэмнэх боломжтой.
- **Төгрөг Нуурын ШТҮ-т** ус хэмнэх арга хэмжээг хэрэгжүүлснээр жилд 0.03 сая м3 ус хэмнэн, м3 тутамд 0.05 ам.долларын зардлыг хэмнэх боломжтой.
- **НШҮ-үүдэд ус хэмнэх арга хэмжээ** хэрэгжүүлэх нь төдийлөн үр ашигтай бус буюу м3 тутамд 0.03 – 0.01 ам.долларын зардал хэмнэх боломжтой ба нийт 18.4 сая м3 ус жилд хэмнэх боломжтой.
- Өртөг үр ашгийн хувьд хамгийн тохиромжтой (м3 тутамд 0.20 ам.доллар) цооногийн талбайгаас эхлэн шинээр **газрын доорх ус татах** арга хэмжээ нь ус хангамж нэмэгдүүлэх, зөрүү арилгахад хамгийн чухал арга хэмжээ болж байна.


Шинжилгээний үр дүнгээс харахад Нялга-Шивээ Овоо бүсэд ус хэмнэх, усны нөөц нэмэгдүүлэх төслүүдийг хослуулан хэрэгжүүлснээр 2040 оны байдлаар тус бүсэд бага, дунд, өндөр эрэлттэй хувилбараар ус хангамж, усны эрэлтийн зөрүүг бүрэн арилгах боломжтой байна.

5.3.2. Зардлын нэгдсэн муруй –Тавантолгойн бүс

Бага болон дунд эрэлттэй хувилбараар тус бүсэд ус хангамж, усны эрэлтийн зөрүү гарахгүй гэж үзэв. Тавантолгой бүсэд дунд болон өндөр эрэлттэй хувилбарын зөрүү арилгах өсөн нэмэгдэх зардал нь жилд ойролцоогоор 4 сая болон 21 сая ам.доллар байна. Дунд эрэлттэй хувилбараар 6.21 сая м³ зөрүү арилгахад 9.3 сая м³ ус хэмнэнэ. Өндөр эрэлттэй хувилбараар 2040 онд 18.85 сая м³ зөрүү арилгахад 21 сая м³ ус хэмнэнэ.

Зураг 24-т Тавантолгой бүсийн санхүү, эдийн засаг, байгаль орчны шалгууруудыг авч үзсэн зардлын нэгдсэн муруйг харуулав.

Зураг 24 Тавантолгой –Зардлын нэгдсэн муруй



Дээрх зардлын муруй дээр харвал зардал багатай технологийн олон хувилбарууд нэг хэсэгт хамаарч байна. Тухайлбал зардал багатай технологийн 4 хувилбар (19с, 20с, 30с, 40с) тоосжилт дарахад органик баригчаас илүү кальцийн хлорид ашиглах хувилбарт хамаарч байна. Практикт ч органик баригч ашиглах хувилбарт хөрөнгө оруулахгүй нь мэдээж. Тэхээр өөрчлөлтийг тоосжилт дарахад ус ашиглах хувилбараас (суурь) кальц хлорид ашиглах хувилбар руу шилжих (хувилбар с) замаар хэрэгжүүлнэ. Тус шилжилтийн зардал болон усны нөөцөд гарах өөрчлөлтийн *нийт* нөлөөллийг тогтоохын тулд 19с, 20с, 30с, 40с хувилбаруудын өсөн нэмэгдэх зардал болон усны нөөцийг суурь хувилбартай (анхны хувилбар болох 19b, 20b, 30b, 40b-тэй) харьцуулж авч үзэх хэрэгтэй.

Тиймээс эрэмбэлсэн шийдлүүдийг жагсаасан Хүснэгт 16-д технологийн өөрчлөлтийг тайлбарлан, суурь хувилбартай (эхлэх цэг) харьцуулж авч үзсэн технологийн хувилбар тус бүрийн өсөн нэмэгдэх зардал, нэмэлт ус хүртээмжийг үзүүлэв. Ингэснээр ус хангамж, усны нөөцийн зөрүүг арилгахын тулд зардлын муруй дээр санал болгосноос цөөн арга хэмжээ хэрэгжүүлэх хэрэгтэй болно. Хавсралтад зардлын муруйн суурь болсон бүх арга хэмжээний жагсаалтыг оруулав.²⁶

Хүснэгт 16 Тавантолгой – Эрэмбэлсэн шийдлүүдийн жагсаалт (зардлын нэгдсэн муруй)

²⁶ А 5.1.4 хавсралтаас кальц хлорид ашиглан тоосжилт дарах талаар дэлгэрэнгүй материалыг үзнэ үү.

Анг ила л	Дуг аар	Нэр – төслийн нэр	Суурь технологи	Технологийн бүрэн тайлбар	Нийт зардал (ам.доллар, ЭЖЗ)	Өсөн нэмэгдэх зардал (суурь үзүүлэлттэй харьцуулса н ам.доллар, ЭЖЗ)	Нэмэгдэх усны нөөц (сая м3/жил, суурь үзүүлэлттэй харьцуулса н)	Зардал- үр ашгийн харьцаа (ам.долл ар/м3)
1	19с	Эрдэнэс Тавантолг ой уурхай	Ус ашиглан тоосжилт дарах	Кальц хлорид ашиглан тоосжилт бууруулах	1,874,243	1,864,075	1.15	-5.58
2	20с	Ухаа худаг уурхай	Ус ашиглан тоосжилт дарах	Кальц хлорид ашиглан тоосжилт бууруулах	1,185,022	1,178,593	0.72	-5.58
3	30с	Тавантолг ой ХҮ уурхай	Ус ашиглан тоосжилт дарах	Кальц хлорид ашиглан тоосжилт бууруулах	530,911	528,031	0.32	-5.58
4	40с	Бусад уурхай Тавантолг ой	Ус ашиглан тоосжилт дарах	Кальц хлорид ашиглан тоосжилт бууруулах	4,142,551	4,120,078	2.53	-5.58
5	25b	Нүүрс угаах - Эрдэнэс Тавантолг ой	Усны 60%-ийг эргүүлэн ашиглаж нүүрс угаах	Хуурай аргаар нүүрс угаах технологи	3,674,368	-4,034,498	4.54	-0.30
Нийт (дунд эрэлттэй хувилбарын зөрүү – 6.21 сая м³)					11,407,095	3,656,279	9.3	
6	32b	Нүүрс угаах - Монголиа н майнинг ХХК	Усны 60%-ийг эргүүлэн ашиглаж нүүрс угаах	Хуурай аргаар нүүрс угаах технологи	1,837,184	-2,017,249	2.27	-0.30
7	33b 10	Газрын доорх ус татах цооног J1+J2 – Тавантолг ой	NA	Сонгосон талбайд газрын доорх ус шинээр татах цооногийн бүтээн байгуулалт (усан сангуй) Тавантолгой руу хүргэх	19,382,043	19,382,043	9.46	0.46
Нийт (өндөр эрэлттэй хувилбарын зөрүү – 18.85 сая м³)					32,626,322	21,021,073	21	

Тавантолгой бүсэд дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын жилийн зардлын тэнцэл нь дунд болон өндөр эрэлттэй хувилбараар жилд ойролцоогоор 11-33 сая ам.доллар байна (төслийн суурь хувилбаруудын зардал хамаарахгүй).

Тавантолгой бүсийн судалгаа шинжилгээний нэгдсэн үр дүнг авч үзэхэд дараахь онцлох зүйлс гарч байна. Үүнд:

- **Кальц хлорид ашиглан тоосжилт бууруулах** Тавантолгой болон Ухаа худаг уурхайд кальц хлорид ашиглан тоосжилт бууруулах нь хамгийн үр ашигтай арга хэмжээ ба жилд нийт 4.7 сая м3 ус хэмнэхийн сацуу м3 ус тутамд 5.58 ам.долларын (санхүүгийн хэмнэлтээс гадна усны хэмнэлт гарна) зардал хэмнэх боломжтой (тоосжилт бууруулах суурь технологитой харьцуулав).
- Нүүрс угаах үйлдвэрүүдэд **хуурай аргаар нүүрс цэвэрлэх технологи** ашиглах нь жилд нийт 6.8 сая м3 ус хэмнэн, м3 ус тутамд 0.30 ам.долларын зардал хэмнэх боломжтой.
- Өртөг үр ашгийн хувьд хамгийн тохиромжтой (м3 тутамд 0.46 ам.доллар) цооногийн талбайгаас эхлэн **шинээр газрын доорх ус татах арга хэмжээ** нь ус хангамж нэмэгдүүлэх, зөрүү арилгах хамгийн чухал арга хэмжээ болж байна.

- **Орхон-Говь ус дамжуулах төсөл нь** 17.2 сая м3 усыг нэмэгдүүлэх боломжтой хэдий ч ус хэмнэх арга хэмжээ, газрын доорх ус татах шинэ талбай байгуулах зэрэг харьцангуй өндөр үр ашигтай хувилбаруудыг хэрэгжүүлбэл Тавантолгой бүсийн усны зөрүүг бүрэн арилгах боломжтой тул тус төслийг хэрэгжүүлэх шаардлагагүй байх гэж үзэв.

Шинжилгээний үр дүн Тавантолгой бүсэд ус хэмнэх, ус нэмэгдүүлэх төслүүдийг хослуулан хэрэгжүүлснээр 2040 оны байдлаар тус бүсэд бага, дунд, өндөр эрэлттэй хувилбараар ус хангамж, усны эрэлтийн зөрүүг бүрэн арилгах боломжтойг харуулж байна.

5.3.3. Хагас чанарын болон чанарын шалгуурууд

5.1-д танилцуулсан үнэлгээний аргачлалд өнөөдрийг хүртэл тоон мэдээлэл байхгүй шалгууруудыг хамруулсан. Бүх төслийн болон технологийн хувилбарт зориулсан өгөгдөл/мэдээлэл байгаагүй бөгөөд шалгууруудыг ач холбогдолтой гэж тооцсон тул цаашид мэдээлэл цуглуулан зардлын муруйд багтаана гэж найдан хагас чанарын болон чанарын үнэлгээний шалгууруудын талаар цаашид судалгаа хийхийг зөвлөж байна.

Түүнээс гадна тоон мэдээлэл, тоон үр ашгийг хуваарилах дэлгэрэнгүй мэдээлэл аль аль нь байхгүй байсан тул үнэлгээний олон шалгуурыг чанарын шалгуураар үлдэв.

Ажиглалтын аргаар тус үнэлгээнд төслийн хувилбаруудын нийгмийн нөлөөллийг ач холбогдлоор нь авч үзвэл:

- **Орон нутгийн иргэдийн усны хүртээмж:**
 - Орон нутгийн иргэдийн усны хүртээмж нь чухал асуудал (тухайлбал Өмнөговь аймгийн Цогтцэций сумын хувьд). Гэхдээ орон нутгийн иргэдийн усны хүртээмжид төлөвлөж буй хөрөнгө оруулалтын нөлөөллийг (эерэг, сөрөг) тооцох тус бүсийн бага гүний усны нөөцийн талаар үнэн зөв мэдээлэл хомс, тохиолдлын чанартай судалгаагаар үнэлгээ өгөх боломжгүй билээ.
- **Малчдын усны хүртээмж:**
 - Хөдөө орон нутагт мал услах нь хамгийн хэцүү ажилд тооцогддог.²⁷ АХБ-ны судалгаагаар (2013)²⁸ говийн бүсийн малчин айлууд 90 хүртэл км зам туулж жилд 6-7 удаа нүүдэг. Ингэснээр МАА-д нүүрлээд буй усны хүртээмжид алдагдал үүсгээд зогсохгүй нөөц бэлчээр болон улирлын бэлчээрийн хүртээмжид мөн нөлөөлж байна.
 - Уурхайн үйл ажиллагаанаас улбаалж малчин иргэдийг нүүлгэн суурьшуулах нь тэдний орлогыг бууруулж, улмаар нүүдэл хийх болон орлогоо төрөлжүүлэх боломжийг үгүй хийж байна.²⁹ Нүүлгэн суурьшуулах тухайд уул уурхайн компаниудаас үзүүлж буй дэмжлэг, хөгжлийн хөтөлбөр нь наад захын ёс төдий байдаг.
 - Эдгээр нийгмийн асуудлыг Хөндлөнгийн судалгааны хүрээлэнгээс хийсэн суурь хүртээмж, мэдрэмжийн судалгаанд авч үзсэн байдаг (2014)³⁰. Тус судалгаанд орон нутгийн усны хэмжээ, чанарын статусын талаар нэлээн гутранги хандлагаар хандсан байдаг ч энэ нь зөвхөн үзэл бодол гэдгийг ойлгох хэрэгтэй.
- **Ус, эрчим хүчний боломжийн үнэ өртөг бүхий үйлчилгээ:**
 - Ус, эрчим хүчний боломжийн үнэ өртөг бүхий үйлчилгээ нь нийгмийн чухал асуудал. Эрчим хүчний төслүүдийн эрсдэлтэй байдлын улмаас найдвартай, боломжийн үнэ өртөг бүхий эрчим хүчний үйлчилгээний талаар баримт сэлт элбэг биш ч цахилгааны

²⁷Батима П,Мягмаржав Б, Батнасан Н, Жадамба Н, Хишигсүрэн П, 2010. Urban water vulnerability to climate change in Mongolia. UNEP

²⁸ ADB, 2013. Making Grasslands Sustainable in Mongolia. Adapting to Climate and Environmental Change.

²⁹Walters, M., 2009. Southern Mongolia Infrastructure strategy. Washington, DC: World Bank

³⁰IRIM, 2014. Baseline community perceptions survey for International Finance Corporation. Final Report (May 2014).

IRIM (Independent Research Institute of Mongolia), Mongolia.

Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах эрэмбэлсэн шийдлүүд

PwC

эрэлтийн өсөлтийн дөнгөж талыг тариф нэмэх замаар нөхнө. Үнэн хэрэгтээ суурилуулсан хүчин чадалд зориулж нөөцийг хангалттай хэмжээнд хүргэх, системийг бүхлээр нь сэргээх, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор үйлчилгээний тарифыг аль эрт нэмэх байсан (ECA, 2008³¹).

- Шинэ төслүүдийг санхүүжүүлснээр ус болон цахилгааны тариф нэмэх шаардлага гарах магадлалтай. Зардал нөхөх зарим тооцооны дагуу шинэ төсөл санхүүжүүлэх нь ундны усны тарифыг 2010 оны түвшнээс 230%, цахилгааны тарифыг 350% өсгөж болзошгүй (McGrath et al., 2011)³². Үүнийг илүү нарийн судлах шаардлагатай.
- Ус, эрчим хүчний үйлчилгээний дээрх асуудлын тухайд Энержи рэсурс аль 2011 онд Цогтцэций сумын оршин суугчдад татаас өгч байжээ. Энэ ажил одоо үргэлжилж байгаа эсэх талаар баримт сэлт байхгүй байна.

5.3.4. Усны эрэлтийг бууруулах арга хэмжээний тухайд

Говийн бүсийн гүний уст давхаргууд нөхөн сэргээгдэх магадлал тун хязгаарлагдмал, үл нөхөгдөх, шавхагдах нөөцөд багтана. Гэхдээ эдгээр уст давхаргын хэмжээ, зузааныг тооцож үзэхэд олон жилийн ашиглалтыг хангах усны нөөцтэй. Ус хангамжийг нэмэгдүүлэх шийдлээр бий болгох нөөцийг усны түвшин бууралтын шалгуурт үндэслэн тооцсон ба үүгээр төлөвлөсөн төслүүдийн бүхий л хугацааны усны эрэлтийг ирэх 25 жил хангах тооцоотой байна. Энэ тайланд санал болгосон хамгийн зардал багатай шийдлийг хэрэгжүүлсний дараа газрын доорх усны нэмэлт хайгуул хийж болох ч өртөг үр ашгийн харьцаа таагүй байсан ч гэсэн усны эрэлтийг бууруулах шийдэлд гол анхаарал хандуулна. Нялга-Шивээ Овоогийн бүсэд усны эрэлтийг бууруулах арга хэмжээнд жилд 33.0 сая ам.доллар зарцуулан 31.3 сая м3 ус хэмнэх боломжтой. Үлдсэн 2.95 сая м3 зөрүүг жилд 3.5 сая ам.долларын зардлаар газрын доорх ус олборлох замаар арилгах боломжтой. Үүний өсөн нэмэгдэх зардал жилд 36.5 сая ам.доллар болно (5.3.1-ийг үзнэ үү).

Усны эрэлтийг бууруулах бүхий л арга хэмжээг хэрэгжүүлснээр Тавантолгой бүсэд жилд 11.5 сая м3 усыг жилийн 1.6 сая ам.доллар зарцуулан хэмнэх боломжтой. Үлдсэн 7.4 сая м3-ын зөрүүг газрын доорх ус олборлон хамгийн хэмнэлттэй аргаар арилгах боломжтой (19.4 сая ам.доллар/жил). Тухайн зөрүүг мөн Орхон-Говь төслөөр арилгаж болох боловч тус төслийн зардал хамаагүй өндөр байхаас (нийтдээ 212 сая ам.доллар) гадна цаашдын эрэлт хэрэгцээний тодорхойгүй байдал гэх мэт эрсдэл ихтэй (5.3.2-ыг харна уу).

Говийн бүсийн үл нөхөгдөх газрын доорх усны нөөцийг ашиглах тохиолдолд үндсэн уст давхаргад зориудаар нөлөөлж нөхөн сэргээхийн тулд усны түвшин болон ус хангамжийн хугацааг уртасгах ажлуудыг хэрэгжүүлэх талаар авч үзэж болно. Үүний тулд уурхайд орох урсац, гадаргын урсац, цэвэршүүлсэн бохир ус зэрэг орон нутгийн илүүдэл усыг тооцох хэрэгтэй. Гадаргын урсац нь улирлын чанартайгаар тодорхой хэмжээний ус бий болгодог ба үүгээр бага гүний уст давхарга, орон нутгийн хэрэглээ, экосистемийг тэжээгддэг. Гэхдээ говийн бүсэд урсац, түүнийг голиоролыг өөрчлөх боломж бараг байхгүй. Зарим уурхайн үйл ажиллагаа болон бохир ус цэвэршүүлэлтээс гарах харьцангуй бага хэмжээний усыг зориудаар нөхөн сэргээх ажиллагаанд ашиглаж болох ч ихэнх тохиолдолд ийм усыг өөр зорилгоор буюу гүний уст давхаргаас олборлох усны хэмжээ, зардлыг багасгах зорилгоор ашигладаг.

³¹ECA, 2008. Mongolia: Power Sector Development and South Gobi Development. Draft Report (September 2008) submitted to the World Bank. ECA (Economic Consulting Associates), UK.

³²McGrath et al., 2011. McGrath F., Martsynkevych V., Hoffman D., Richter R., Dugersuren S., Yaylymov A., 2011. Spirited away – Mongolia's mining boom and the people that development left behind. CEE Bankwatch Network, Urgewald, Bank Information Center, Oyu Tolgoi Watch

Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах эрэмбэлсэн шийдлүүд
PwC

6. Дүгнэлт, зөвлөмж

6.1. Тулгамдсан асуудал/ Сорилт

Уул уурхай нь Монголын эдийн засгийн гол тулгуур. Улсын нүүрсний гол нөөц болох Тавантолгой, Шивээ Овоо ордууд говийн бүсэд оршдог. Энэ бүсэд цахилгаан станц, нүүрс угаах, нүүрс шингэрүүлэх болон шахмал түлшний үйлдвэр зэрэг нэмүү өртөг шингэх олон төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ба эдгээр бүтээн байгуулалтын ажлын гол шалгуур нь усан хангамжийн асуудал юм.

Дээрх төлөвлөсөн төслүүд хэрэгжихгүй тохиолдолд Нялга-Шивээ Овоо бүсийн усны эрэлт хэрэгцээг бүх хувилбараар одоо байгаа нөөц буюу засгийн газраас баталсан газрын доорх усны нөөц болон уурхайн шүүрлийн усаар хангах боломжтой.³³ Харин төлөвлөсөн төслүүд хэрэгжих тохиолдолд уурхайн шүүрлийн ус ашигласан ч гэсэн 2030 он гэхэд бүх хувилбараар ус хангамж, усны эрэлтэд зөрүү гарна. Ямар нэг арга хэмжээ авагдахгүй тохиолдолд ус хангамж, усны эрэлтийн зөрүү өндөр эрэлттэй хувилбараар 35% (34.25 сая м³/жил), бага болон дунд эрэлттэй хувилбараар 30-31% -д хүрнэ.

Тавантолгойн бүсэд төлөвлөсөн төслүүд хэрэгжихгүй тохиолдолд бага болон дунд эрэлттэй хувилбарын усны эрэлт хэрэгцээг одоо байгаа нөөц буюу засгийн газраас баталсан газрын доорх усны нөөц болон уурхайн шүүрлийн ус, эргүүлэн ашиглах усаар хангах боломжтой. Харин усны өндөр эрэлттэй хувилбараар 2040 онд ус хангамж, усны эрэлтийн зөрүү 41% хүрэх тооцоо гарч байна. Төлөвлөсөн төслүүд хэрэгжих тохиолдолд дунд болон өндөр эрэлттэй хувилбарын 33% (6.21 сая м³/жил), 60% (18.85 сая м³/жил)-ийн усны эрэлтийг одоо байгаа нөөцөөр хангах боломжгүй болно.

Судалгаанд авч үзсэн бүх төсөл нь нүүрстэй холбоотой. Нүүрсний зах зээлийн савлагаа, нүүрсний үнэ бууралт, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой яриа хэлэлцээ зэрэг хэд хэдэн хүчин зүйлийн улмаас эдгээр төслийн санхүүгийн боломж, үр ашиг тодорхойгүй байна. Эдгээр хүчин зүйл нь Монголын эрчим хүчний болон эдийн засгийн гол эх үүсвэр болсон нүүрсийг уналтад оруулж магадгүй байна. Ялангуяа Тавантолгойд нэмүү өртөг шингэх төслүүдийн хэрэгжилт Эрдэнэс Тавантолгой олон улсын консорциум байгуулахаас хамааралтай. Усны цаашдын эрэлт хэрэгцээний энэхүү тодорхойгүй байдал усны менежментийн уян хатан арга хэмжээ хэрэгжүүлэхийг шаардаж байна. Ямар ч тохиолдолд уян хатан арга хэмжээг усны өндөр эрэлттэй хувилбарт зориулж хэрэгжүүлэх хэрэгтэй. Цаашдын ус хангамжийн асуудал тодорхой болбол хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж, улмаар эдийн засгийн өсөлтөд дэмжлэг болно.

6.2. Эн тэргүүнд хэрэгжүүлэх шийдлүүд

Усны эдийн засгийн цогц судалгаанд үндэслэн тооцоход Нялга-Шивээ Овоогийн бүсэд усны өндөр эрэлттэй хувилбарын 34.25 сая м³ зөрүүг арилгах хамгийн зардал багатай хувилбарын жилийн нийт зардал 33.2 сая ам.доллар болно. Дийлэнх зөрүүг (86%) усны эрэлт багасгах дор дурдсан арга хэмжээ хэрэгжүүлж арилгаж болно. Үүнд:

1. Шивээ Овоо, Төгрөг нуур, Бөөрөлжүүтийн тал болон бусад уурхайд тоосжилт дарахад кальцийн хлорид ашиглах (7.9 сая м³/жил);
2. Шивээ Овоогийн ДЦС-уудад (270 мВт болон 750мВт) хуурай/агаараар хөргөх хөргөлтийн систем суурилуулах (3.7 сая м³/жил);
3. Шахмал түлшний үйлдвэрт хөргөлтөөс гарах усыг боловсруулах систем, хуурай аргаар сульфурьг ялгах, хэмнэлттэй шүршигч суурилуулах (0.03 сая м³);
4. Төгрөг нуур, Бөөрөлжүүтийн тал уурхайд төлөвлөж буй Нүүрс Шингэрүүлэх Үйлдвэрт хуурай/агаарын хөргөлтийн систем суурилуулах (13.8 сая м³/жил);
5. Шивээ Овоогийн уурхайд төлөвлөж буй Нүүрс Шингэрүүлэх Үйлдвэрт хуурай/агаарын хөргөлтийн систем суурилуулах (4.5 сая м³/жил) тус тус орно.

Үлдсэн зөрүүг (4.7 сая м³/жил) ГДУ олборлох цооногийн байгууламж байгуулах замаар арилгах боломжтой байна.

³³ Нялга-Шивээ Овоо бүсэд газрын доорх усны А, В, С1 ангиллуудыг авч үзэв.

Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах эрэмбэлсэн шийдлүүд

PwC

Тавантолгойн бүсийн усны эдийн засгийн шинжилгээний дүнгээр өндөр эрэлттэй хувилбарын жилийн 18.85 сая м³-ын зөрүүг арилгах хамгийн зардал багатай хувилбарт жилд 21.0 сая ам.доллар зарцуулах тооцоо гарч байна (Одоогийн технологийн хувилбартай харьцуулахад). Усны эрэлтийг бууруулах дор дурдсан хамгийн зардал багатай арга хэмжээг хэрэгжүүлснээр ус хангамж, усны эрэлтийн зөрүүг 50% бууруулах боломжтой:

1. Тоосжилт бууруулахад кальцийн хлорид ашиглах (4.7 сая м³/жил),
2. Одоо байгаа болон төлөвлөж буй нүүрс угаах үйлдвэрүүдэд хуурай аргаар нүүрс угаах технологийг нэвтрүүлэх (6.8 сая м³/жил) зэрэг болно.

Үлдсэн зөрүүг хамгийн бага зардлаар ГДУ олборлох цооногийн байгууламж байгуулах замаар арилгах боломжтой (9.5 сая м³/жил).

Говийн бүсийн газрын доорх ус үл нөхөгдөх тул зардал өндөр гарах магадлалтай ч гэсэн усны эрэлтийг бууруулах арга хэмжээнд гол ач холбогдолтой юм.

Нялга-Шивээ Овоогийн бүсэд усны эрэлтийг бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэхэд жилд 33.0 сая ам.доллар зарцуулан 31.3 сая м³ ус хэмнэх боломжтой. Үлдсэн 2.95 сая м³ зөрүүг жилд 3.5 сая ам.долларын зардлаар газрын доорх ус олборлох замаар арилгах боломжтой. Үүний өсөн нэмэгдэх зардал жилд 36.5 сая ам.доллар болно.

Усны эрэлтийг бууруулах бүх арга хэмжээг хэрэгжүүлснээр Тавантолгой бүсэд жилд 11.5 сая м³ усыг 1.6 сая ам.доллар зарцуулан хэмнэх боломжтой. Үлдсэн 7.4 сая м³ зөрүүг газрын доорх ус олборлон хамгийн хэмнэлттэй аргаар арилгах боломжтой (19.4 сая ам.доллар/жил). Тухайн зөрүүг мөн Орхон-Говь ус дамжуулах төслөөр хангаж болох боловч тус төслийн зардал ихээхэн өндөр байгаагаас (нийтдээ 212 сая ам.доллар) гадна цаашдын эрэлт хэрэгцээний тодорхойгүй байдал гэх мэт эрсдэл ихтэй байна.

Засгийн газраас баталсан газрын доорх усны нөөц, энэ судалгаагаар тогтоосон газрын доорх ус татах байгууламж барих талбай, Орхон-Говь төслийн нийт зардал, ус нэмэгдүүлэх хүчин чадал болон байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, Нялга-Шивээ Овоогийн бүсэд төлөвлөж буй 5,280 мв, 600 мв-ын ДЦС-уудын ус хэмнэх боломж бүхий ТЭЗҮ боловсруулах чиглэлээр нэмэлт судалгаа хийж, баталгаажуулах хэрэгтэй.

6.3. Дараагийн алхмууд

Газрын доорх усыг ашиглах нэгдсэн шийдвэр

Говийн бүсийн газрын доорх ус ихэнх тохиолдолд үл нөхөгдөх тул түүнийг ашиглах эсэх, ямар зорилгоор ашиглах дээр талууд нэгдсэн шийдвэрт хүрэх хэрэгтэй.

Энэхүү шийдвэр гаргах үйл явцад төрийн болон хувийн хэвшил, иргэний нийгмийг татан оролцуулах нь чухал. Оролцогч талуудын байр суурийг бүрэн дүүрэн ойлгож мэдэхийн тулд мэдээллийн кампанит ажил зохиож, тэднээс бичгээр санал авахыг зөвлөж байна. Үүний тулд тэдэнд санал болгож буй хувилбарууд болон тэдгээрийн зардлын (боломж болон ерөнхий зардал) талаар тодорхой ойлголт өгч хэлэлцүүлэх хэрэгтэй.

Засгийн газраас авах арга хэмжээ

Цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх яриа хэлэлцээг ус-эрчим хүчний уялдаанд чиглүүлэх хэрэгтэй. Эрчим хүч үйлдвэрлэх бүх төсөлд ус хэрэгтэй. Ус ашиглалт, эрчим хүч үйлдвэрлэлийн солилцоонд эн тэргүүнд ач холбогдол өгөх хэрэгтэй. БОНХАЖЯ, ЭХЯ, УУЯ, АҮЯ-наас Ус, Эрчим хүчний талаарх бодлогын болон стратегийн баримт бичгүүдийн уялдаа холбоог хангаж нэгтгэх хэрэгтэй байна.

Эрх зүйн зохицуулалт болон урамшууллын механизмыг аль хэсэгт хийх шаардлагатайг шийдэх хэрэгтэй.

- **Эрх зүйн зохицуулалтын арга хэмжээ:** Ус ашиглах зөвшөөрлийг зөвхөн усны хэмнэлттэй технологи ашиглах тохиолдолд олгох буюу усыг үргүй зарцуулах, усан хөргөлт бүхий цахилгаан станц барих төсөлд зөвшөөрөл олгохгүй байх гэх мэт зохицуулалтын арга хэмжээг авах
- **Урамшууллыг бий болгох:** Монголын тэргүүлэгч банкуудтай хамтран ус эргүүлэн ашиглахад хөнгөлөлт үзүүлэх, ус хэмнэх технологийн импортын татварыг бууруулах зэргээр ус хэмнэх технологийн хөрөнгө оруулалтыг урамшуулах, үнийн түвшин тогтоох г.м

Усны үнэлгээ, урамшууллын тал дээр 2030 Усны нөөцийн бүлэгтэй нягт хамтарч ажиллах боломжтой.

Компани/хөрөнгө оруулагчдаас хийх ажлууд

Усны эрэлтийг бууруулах бүх арга хэмжээг үйл ажиллагаа явуулж буй компани/хөрөнгө оруулагчид хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ хөрөнгө оруулалтын шаардлагыг ойлгох, шаардлагатай шийдлүүдийг тодорхойлох, холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэх зэрэгт тус компани/хөрөнгө оруулагчдад дэмжлэг туслалцаа үзүүлэх хэрэгтэй.

Монголын болон гадаадын компаниудын хооронд мэдлэг солилцох, чадавхийг бэхжүүлэх нь компаниуд/хөрөнгө оруулагчдад оновчтой, зардал багатай шийдэл олж хэрэгжүүлэхэд хувь нэмэр болно. Үүний тулд усны асуудалд чиглэсэн уул уурхайн сайн дурыг бүлэг байгуулж болох ба үүндээр Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Уул уурхайн дугуй ширээний техникийн багтай хамтарч ажиллах боломжтой.

Оролцогч талуудын хэлэлцүүлгийн ач холбогдол

Ус хангамж, усны эрэлтэд зөрүү гаргахгүйн тулд тодорхойлсон, хамгийн үр ашигтай төслүүдийн хэрэгжилтэд талууд оролцож арга хэмжээ авах шаардлагатай ба ингэснээр хэрэгжилтэд хүндрэл нэмэгдэнэ.

Дээр дурдсан хүндрэлийг даван туулах хоёр арга санал болгож байна: 1) Зохицуулалтад суурилсан арга буюу ус ашиглах зөвшөөрлийг зөвхөн ус хэмнэх хамгийн сайн технологи бүхий хэрэглэгчдэд олгох, 2) Оролцогч талуудад суурилсан арга буюу хөрөнгө оруулагчид үйл ажиллагаа явуулж буй бүс нутагтаа ус хэмнэх арга хэрэгжүүлэх тал дээр зөвшилцөж, зардал гарган, төслүүдэд зориулсан санхүүгийн хангалттай нөөцтэй байх. Цаашилбал усны нөөцийн тогтвортой менежментийг дээр дурдсан 2 аргатай хамтад нь болон дангаар нь хэрэгжүүлэх нөхцөлийг урамшуулах талаар судалгаа хийж болно. Урамшууллаар усны хэрэглээ, хэмнэлтэй холбоотой хэв маягийг өөрчлөх ажлын үр дүн нь санал болгож буй 2 аргыг хэрэгжүүлэхээс илүү тодорхойгүй байгааг энд онцлох нь зүйтэй.

Дээрх шийдвэрүүд Монголчуудад шууд болон шууд бусаар нөлөөлөх тул оролцогч талуудын хэлэлцүүлгийн үйл явц чухал ач холбогдолтой.

Судалгаа шинжилгээний үр дүнд дараахь хүснэгтэд жагсаасан оролцогч талуудыг бодит үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд оролцуулахыг зөвлөж байна. Хүснэгт 17-д Нялга-Шивээ Овоо бүсийн, Хүснэгт 18-д Тавантолгойн бүсийн оролцогч талуудыг оруулав.

Хүснэгт 17 Нялга-Шивээ Овоогийн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа оролцогч талууд

Хувийн хэвшил/ Хөрөнгө оруулагчид	Төрийн байгууллага	Иргэний нийгэм
One Power Global Limited	БОНХАЖЯ	МБОИЗ
IM Power Plc	УУЯ	WWF Монгол дахь хөтөлбөрийн алба
State Grid Corporation of China	ЭХЯ	УУДБХОДТөсөл
Цэцэнс Mining and Energy	УУХороо	Хил хязгааргүй гол мөрөн
Гермон газ ХХК	УУЯ	Монголын УУҮ Ассоциаци
CTL Mongolia ХХК	СГЗ	The Nature Conservancy (TNC)l
Цэцэнс Майнинг Энержи	Сум/ багын засаг дарга	Ус хангамжийн салбар,

Геоэкологийн хүрээлэн

Camex ХХК

Гол санхүүгийн байгууллага,
Хаан банк г.м*Хүснэгт 18 Тавантолгой бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа оролцогч талууд*

Хувийн хэвшил/ Хөрөнгө оруулагчид	Төрийн байгууллага	Иргэний нийгэм
Монголын уул уурхайн корпораци	БОНХАЖЯ	МБОИЗ
Consortium in discussion for Power Plant 450 Mw/ Lead MCS Energy	УУЯ	Монголын малчдын нэгдсэн ассоциаци
Монголын уул уурхайн корпораци	ЭХЯ	WWF МОНгол дахь хөтөлбөрийн алба
Тавантолгой ХК	УҮХороо	ОУСК Дутуй ширээний уулзалт
Consortium in discussion for coal washing/ Lead MMC	СГЗ	УУДБХОДТөсөл
Consortium in discussion for coal washing/ Lead Erdenes Тавантолгой	Сум/ багын засаг дарга	Хил хязгааргүй гол мөрөн
Эрдэнэс Тавантолгой		Монголын УУҮ Ассоциаци
Оюу толгой		Ус хангамжийн салбар, Геоэкологийн хүрээлэн
Гол санхүүгийн байгууллага, Хаан банк г.м		The Nature Conservancy (TNC)

7. Үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөө

Үйл ажиллагаа 1: Хөрөнгө оруулалтын итгэлтэй байдлыг нэмэгдүүлэх

Үйл ажиллагаа 2: Тухайн нөхцөлд хамгийн тохиромжтой шийдлүүдийг сонгох шийдвэр гаргахад оролцогч талуудтай хэлэлцэж шийдвэрлэх

- Нөхөн сэргээгдэхгүй ГДУ-ны нөөцийн ашиглах эсэх болон эрэлтийн болон нийлүүлэлтийн аль арга хэмжээг илүүд үзэх
- Засгийн газар (Гадаргын ус дамжуулах), хувийн хэвшил/ хөрөнгө оруулагчид (нэмүү өртөг шингэсэн төслүүд, ГДУ ашиглах)-ийн хэрэгжүүлж байгаа шийдлүүдээс сонгох сонголт
- Засгийн газар, ажлын хэсгийн гишүүдэд өгөх санал, зөвлөмжийг авах үүднээс бүх оролцогч талуудын урин оролцуулах
- Бүх хүчин зүйлүүдийг авч үзэх (ТЭЗҮ, зардал, усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл, нийгэм, байгаль орчин, эдийн засгийн нөлөөлөл)
- Говийн бүсэд нүүрс болон усны менежменттэй холбоотой амна хийгдсэн, одоо хийгдэж байгаа, цаашид хийгдэх ажил, арга хэмжээг бүхэлд нь авч үзэх

Үйл ажиллагаа 3: Шийдлүүд дээр нарийвчилсан шинжилгээг хийх

- Өмнө судалгаа хийж нөөцийг нь баталсан тухайн бүсийн усны нөөцөөс ашиглах боломжит нөөцийг нь нарийвчлан тодорхойлох, байгаль орчны тооцох
- Энэ судалгаанд авч үзсэн шинээр ус татах байгууламж барих талбайг баталгаажуулах
- Гадаргын усыг дамжуулах төслийн нийт зардал, ус хангамжийг нэмэгдүүлэх хүчин чадал болон нийгэм, байгаль орчны нөлөөллийг тогтоох, үнэлгээ хийх
- Энэ шинжилгээнд авч үзсэн усны эрэлтийг бууруулах шийдлүүдийн ТЭЗҮ-ийн нарийвчилсан судалгааг боловсруулах
- Нялга Шивээ Овоогийн бүсэд барихаар төлөвлөсөн 5280 МгВ ба 600 МгВ-ийн ДЦС-ийн ус хэмнэлтийн боломж болон зардлын ТЭЗҮ-ийн нарийвчилсан судалгаа хийх

Үйл ажиллагаа 4: Санхүүгийн шийдлүүдийг тодорхойлох

- Усыг үр ашигтай ашиглах, усыг эргүүлэн ашиглах г.м шилдэг технологиудыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх компани, аж ахуй нэгжүүдэд банкны зээл олгох зэрэг санхүүгийн шийдлүүдийг бий болгоход дотоодын болон олон улсын санхүүгийн байгууллагуудтай холбож өгөх

Үйл ажиллагаа 5: Шаардлагатай байгаа эрх зүйн зохицуулалт, урамшууллын механизмийг тодорхойлох

- Усыг эргүүлэн ашиглах, усны үр ашигтай хэрэглээ бий болгох зэрэг ашиглах боломжтой шилдэг технологиудыг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн тохиолдолд ус ашиглах зөвшөөрлийг олгодог байх
- Дэвшилтэт технологийг ашигласан тохиолдолд (импорт) татварын урамшуулал үзүүлэх

Үйл ажиллагаа 6: Олон улсын хөрөнгө оруулагчдийн итгэх байдлыг сэргээхэд чиглэн ажиллах

- Боломжит шийдлүүд, тэдгээрт ус гол хүчин зүйл болж байгаа гэдэг талаар мэдээлэл өгөх
- Хөрөнгө оруулагчдийн итгэлийг сэргээхэд чиглэсэн арга хэмжээг өргөжүүлэх (энд авч үзсэн асуудлаас өөр хэдий ч ирээдүйн хөгжилд чухал байр суурьтай)

Хавсралт А. Хавсралтууд

А.1. Нэмэлт тайлангийн товч мэдээлэл

Шинжилгээг хийхдээ тайланд орсон мэдээллүүдийг олон нийтэд ил тод байлгах тал дээр анхаарсан. Тайлангийн хэмжээнээс хамааран нэмэлт тайланд багтсан мэдээллүүдийг уг тайлангийн хавсралтад оруулаагүй болно. Нэмэлт тайланд орсон мэдээллийн жагсаалтыг доор дурьдвал:

- Тайлангийн нэмэлт #1: Усны эрэлтийг тооцох аргачлал
- Тайлангийн нэмэлт #2: ГДУ-ны үнэлгээний аргачлал ба ГДУ-ыг авч ашиглах шийдлүүд, Үүнд:
 - ТН #2.1 Говийн бүсийн ГДУ-ны тархацийн ерөнхий тойм
 - ТН # 2.2 ГДУ-ны нөөцийн өмнө нь хийгдсэн тооцооны харьцуулалт
 - ТН # 2.3 болон ТН #2.4 Нялга шивээ овоо, Таван Толгойд тус тусдаа хийгдсэн нарийвчилсан үнэлгээ
 - ТН # 2.5 Энэ судлагаанд ашигласан аргачлал болон нөөцийг тооцсон албан ёсны дүнгийн харьцуулалт болон хэлэцүүлэг
- Тайлангийн нэмэлт #3 Усны эрэлтийг бууруулах шийдлүүд
- Тайлангийн нэмэлт # 4 Орхон-Говь ус дамжуулах схемийг дахин нягтлах
- Тайлангийн нэмэлт #5 Үнэлгээний хамрах хүрээ

А.2. Оролцогчидийн жагсаалт (Ярилцлага, Зорилтот бүлгэтэй хийсэн хэлэлцүүлэг болон семинар)

Хүснэгт 19. Ярилцлага хийсэн оролцогч талуудын жагсаалт

#	Нэр	Харъяалагдах байгууллага	Байгууллагийн төрөл	Албан тушаал
1	Анхбат	УБ хотын захирагчийн ажлын алба	Засгийн газар	Ахлах мэргэжилтэн, Стратегийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
2	Эрдэнэ	Монголын байгаль орчны иргэний зөвлөл	ТББ	Гүйцэтгэх захирал
3	Балдан-Очир	Монголын малчдийн нэгдсэн холбоо	ТББ	Захирал
4	Басандорж	Монголын байгаль орчны иргэний зөвлөл	ТББ	Газар, газрын хэвлий, хөрс, усны хэлтсийн дарга
5	Баярмаа	Монголын байгаль орчны иргэний зөвлөл	ТББ	Үүсгэн байгуулалгч, Байгаль орчныг хамгаалах иргэний түншлэл
6	Чимэд-Очир	WWF Монгол дахь Хөтөлбөрийн алба	ТББ	Захирал
7	Нэргүй	Уул уурхай яам	Засгийн газар	Уул уурхай бодлогын газрын дарга
8	Товуудорж	Эрчим хүчний яам	Засгийн газар	Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга
9	Бадамдорж	МУ-ын Засгийн газар, Усны Үндэсний Хороо	Засгийн газар	Ажлын албаны орлогч дарга
10	Энхбаатар	УУДБХОД төсөл	ОУ-ын байгууллага	Төслийн хэрэгжүүлэгч нэгжийн

#	Нэр	Харъяалагдах байгууллага	Байгууллагийн төрөл	Албан тушаал
				захирал
11	Нэгүй	УУДБХОД төсөл	ОУ-ын байгууллага	Гэрээний удирдлага, хяналт шинжилгээний хэлтэс
12	Бат-Эрдэнэ	УУДБХОД төсөл	ОУ-ын байгууллага	Байгаль орчин, экологийн мэргэжилтэн
13	Дөлгөөн	НҮБ: Далайд Гарцгүй Хөгжингүй орнуудийн Олон Улсын эрдэм шинжилгээний байгууллага	ОУ-ын байгууллага	Судлаач зохицуулагч
14	Гансүх	СГЗ: Галба-Өөш-Долоодын говын СГЗ	Засгийн газар	Ахлах мэргэжилтэн
15	Энхбаяр	СГЗ: Алтайн Өвөр Говийн СГЗ	Засгийн газар	Ахлах мэргэжилтэн
16	Жаргалсайхан	СГЗ: Умард Говийн Гүвээт-Халхын Дундад Говийн СГЗ	Засгийн газар	Дарга
17	Сүхгэрэл	Хил хязгааргүй гол мөрөн	ТББ	Монгол талын зохицуулагч
18	Чулуунцэцэг	Камекс Төгрөг нуурын Энержи	Хувийн хэвшил	Төслийн зохицуулагч
19	Сумьяа	Камекс Төгрөг нуурын Энержи	Хувийн хэвшил	Гидрогеологич
20	Цэрэнноров	Аж үйлдвэрийн яам	Засгийн газар	Байгалийн нөөцийн менежментийн зөвлөх
21	Тэмүүжин	Аж үйлдвэрийн яам	Засгийн газар	Ахлах мэргэжилтэн
22	Далай	Престиж Групп	Хувийн хэвшил	Ерөнхийлөгч , Ерөнхий захирал
23	Саранмандал	Престиж Групп	Хувийн хэвшил	Төслийн болон Санхүүгийн менежер
24	Батдэлгэр	Престиж Групп	Хувийн хэвшил	Захирал
25	Бат-Эрдэнэ	Шивээговь сумын ЗДТГ	Засгийн газар	Засаг дарга
26	Намуунцэцэг	Шивээговь сумын ЗДТГ	Засгийн газар	Байгаль орчны ажилтан
27	Шинэгэрэл	Баян сум (Төв аймаг) ЗДТГ	Засгийн газар	Засаг дарга
28	Буяндэлгэр	Цогтцэций сумын иргэн	Орон нутгийн иргэн	Цагаан-Овоо багын малчин
29	Туяа	Цогтцэций сумын иргэн	Орон нутгийн иргэн	Цагаан-Овоо багын малчин
30	Нацагдаш	Эрдэнэс-Таван Толгой ХК	Хувийн хэвшил	Уурхайн менежер
31	Баярсайхан Цагаанхүү	Цагаан-Овоо баг	Засгийн газар	Багын Засаг дарга
32	Шархүү	Билэгт багын Засаг Дарга	Засгийн газар	Багын Засаг дарга
33	Норовсүрэн	Цагаан-Овоо баг	Засгийн газар	Нийгмийн ажилтан
34	Мөнх-Эрдэнэ	Цэций нутаг	ТББ	Мэргэжилтэн
35	Баттогтох	Цагаан-Овоо баг	Засгийн газар	ИТХ-ын Дарга
36	Ардтүмэн	Сийрст баг	Засгийн газар	ИТХ-ын Дарга
37	Соёлбадрах	Цогтцэций сумын иргэн	Орон нутгийн иргэн	Малчин
38	Отгонбаяр	Цогтцэций сум	Засгийн газар	Байгаль орчны мэргэжилтэн
39	Одгэрэл	Цогтцэций сум	Орон нутгийн иргэн	Сургуулийн багш
40	Мөнхдэлгэр	Цогтцэций сум	Засгийн газар	ИТХ-ын Дарга
41	Баасандорж	Монголын уул уурхайн Корпораци	Хувийн хэвшил	Дэд ерөнхийлөгч, Уурхайн дэд бүтцийн төслийн дарга

#	Нэр	Харъяалагдах байгууллага	Байгууллагийн төрөл	Албан тушаал
42	Мөнхтөр	MCS Energy	Хувийн хэвшил	СЕО
43	Баясгалан	Монголын уул уурхайн Корпораци	Хувийн хэвшил	Ерөнхий менежер, Боловсруулах хэлтэс (Нүүрс боловсруулах, ус хангамж, Эрчим хүчний түгээлт)
44	Батсүх	Эрдэнэс Таван Толгой ХК	Хувийн хэвшил	Ус хангамжийн төслийн удирдагч
45	Марк Ньюби	Оюу Толгой ХХК	Хувийн хэвшил	Байгаль орчны менежер
46	Анх-Од	Эрдэнэс Таван Толгой ХК	Хувийн хэвшил	Нүүрс боловсруулах, бэлтгэх станц төслийн менежер
47	Мөнхбаатар	Шивээ Овоо ХК	Хувийн хэвшил	Орлогч захирал

Хүснэгт 20. Зорилтот бүлгийн хэлэлцүүлэгт оролцсон оролцогч талууд

#	Нэр	Байгууллага	Байгууллагын төрөл	Албан тушаал
1	Г.Мөнх-Эрдэм	БОНХАЖЯ	Засгийн газар	Газар зохион байгуулалт болон усны нэгдсэн бодлого зохицуулалтын газар
2	Энхтайван	Эрчим хүчний яам	Засгийн газар	Ахлах мэргэжилтэн
3	Нэргүй	Уул уурхайн яам	Засгийн газар	Уул уурхайн бодлогын хэлтсийн дарга
4	Жаргалцэцэг	Умард говийн гзвээт халхын дундад СГЗ	Засгийн газар	Сав газрын удирдлагын хэлтэс
5	Базаррагчаа	Таван Толгой ЦС (Эрчим хүчний яам)	Засгийн газар	Төслийг хэрэгжүүлэгч нэгж (PIU is under the Ministry of Energy and responsible for TPP from GoM side)
6	Анхбат	Улаанбаатар хотын захирагчийн алба	Засгийн газар	Senior officer, Policy Strategy Planning Division
7	Энхбаатар	УУДБХОДТөсөл	ОУ-ын байгууллага	Төслийн нэгжийн захирал
8	Алтангэрэл	УУДБХОДТөсөл	ОУ-ын байгууллага	Газрын доорхи усны менежментийн нэгж
9	Анармаа	GGGI	ОУ-ын байгууллага	Төслийн менежер
10	Бямбацэрэн	NAMAC/ Малчдын ассоциаци	Төрийн бус байгууллага	Олон улсын хамтын ажиллагаа ба эрх зүйн зөвлөгөөний хэлтсийн дарга
11	Энхтуяа	The Nature Conservancy	Төрийн бус байгууллага	Тэргүүн
12	Батцэрэн	ACF - Wash Action	Төрийн бус байгууллага	Захирал
13	Д.Энхболд	Монголын Уул уурхайн Ассоциаци	Төрийн бус байгууллага	Гадаад харилцааны менежер, Хэлмэрч
14	Басандорж	Монголын усны түншлэл	Төрийн бус байгууллага	Тэргүүн
15	Эрдэнэ	Байгаль орчны иргэний зөвлөл	Төрийн бус байгууллага	Гүйцэтгэх захирал
16	Отгон-Эрдэнэ	Эдийн засгийн бодлого судалгааны төв	Төрийн бус байгууллага	Судлаач
17	Батбаяр	Эрдэнэс Монгол ХК	Хувийн	Уулын ашиглалт олборлолтын хэлтсийн дарга
18	Батсүх	Эрдэнэс Монгол ХК	Хувийн	Ус хангамжийн төслийн удирдагч
19	Дима	Erdenes TT JSC	Хувийн	Харилцааны менежер
20	Саранмандал	Престиж Инженерн ХХК	Хувийн	Төслийн болон санхүүгийн менежер
21	Далайцэрэн	Престиж Инженерн ХХК	Хувийн	

Ус хангамж, усны эрэлтийн зөрүүг арилгах эрэмбэлсэн шийдлүүд
PwC

#	Нэр	Байгууллага	Байгууллагын төрөл	Албан тушаал
22	Баасандорж	Энержи Ресурс ХХК	Хувийн	Уурхайн төслийн талбайн дэд бүтцийн төслийн удирдагч, Дэд ерөнхийлөгч
23	Л.Мягмаржав	MCS LTD	Хувийн	Захирал
24	Марк Ньюби	Оюу Толгой Төсөл	Хувийн	Байгаль орчны менежер
25	Золбаяр	MCS Энержи ХХК	Хувийн	

Хүснэгт 20 Хоёр дахь зорилтот бүлгийн хэлэлцүүлэгт оролцосон оролцогч талууд

